

DDC
363.2
Б-342

ЦАГДАА СУДЛАЛ

Онол арга зүйн
улирал тутмын
сэтгүүл

Хэвлэлийн эх бэлтгэсэн. Г. Чэрэлмаа

Хэвлэлийн хуудас 10.5

Цаасны хэмжээ: В.5

Хэвлэсэн газар: Номын цацал ХХК

Дугаарыг эрхлэн гаргасан: Докторант Г.Бямбадорж

ISBN 978-99962-8882-2-7

2015 №1 (12)

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Зөвлөлийн дарга: **Ж.Болдбаатар** Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор

Зөвлөлийн гишүүд:

- **Ж.Долгорсүрэн** Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор
- **Б.Пүрэв** Хууль зүйн доктор (Ph.D), хүндэт профессор
- **Ж.Заанхүү** Түүхийн шинжлэх ухааны доктор, (Sc.D), дэд профессор
- **Г.Гантөмөр** Хууль зүйн ухааны доктор, (Ph.D), профессор
- **З.Төрмандах** Хууль зүйн ухааны доктор (Ph.D)
- **Т.Оюунчимэг** Хууль зүйн ухааны доктор (Ph.D), профессор
- **Ж.Мөнхболд** Хууль зүйн ухааны (Ph.D)

Сэтгүүлийн эрхлэгч: ХСИС-ийн тэргүүн дэд захирал **Б.Бат-Эрдэнэ** Хууль зүйн ухааны доктор (Ph.D), профессор

Эрхлэн гаргасан, нарийн бичгийн дарга: Докторант **Г.Бямбадорж**

Сэтгүүлийн редакцийн зөвлөл:

- **Т.Бямбаа** Хууль зүйн ухааны доктор (Ph.D)
- **О.Цэцэгмаа** Хууль зүйн ухааны доктор (Ph.D)
- **Д.Энхжаргал** Хэл шинжлэлийн ухааны доктор (Ph.D), дэд профессор
- **Д.Мягмарцэрэн** Хууль зүйн ухааны доктор (Ph.D)
- **Ш.Ариунбилэг** Хууль зүйн ухааны доктор (Ph.D)
- **Б.Баярмагнай** Хууль сахиулахуйн доктор (Ph.D)

ЦАГДАА СУДЛАЛ
Онол арга зүйн улирал тутмын сэтгүүл
(дугаар, 2015 №1)

**ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ
 ПРАКТИКИЙН АСУУДАЛ**

Д.МӨРӨН. ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН НОТЛОХ БАРИМТЫН ОЙЛГОЛТ, АНГИЛАЛ.....

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Б.ХИШИГТОГТОХ. ХУУЛЬ ЁСНЫ ЭРХЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ ГЭМТ ХЭРГИЙГ ҮГҮЙСГЭХ НӨХЦӨЛ
 БАЙДАЛ БОЛОХЫГ ОЛОН УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖИД
 ТУСГАЖ ИРСЭН НЬ.....

О.ОТГОНТУЯА. ГЭМ ХОР, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ.....

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Ш.ЧУЛУУН. ЖАГСААЛ ЦУГЛААН, НИЙТИЙН ЭМХ ЗАМБАРААГҮЙ БАЙДАЛ БИЙ БОЛСОН ҮЕД
 ОЛОН ХҮНД НӨЛӨӨЛӨХ ТУСГАЙ ХЭРЭГСЛИЙГ ХЭРЭГЛЭХ ҮНДЭСЛЭЛ ЖУРАМ,
 АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ.....

Б.БАЯНМӨНХ. ЦАГДААГИЙН ХЭСГИЙН БАЙЦААГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТУЛГАРЧ БҮЙ
 ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛИЙГ ШИНЖЭХҮЙ.....

Г.БЯМБАДОРЖ. СОГТУУРАХ, МАНСУУРАХ ДОНТОЙ ЭТГЭЭДИЙГ АЛБАДАН ЭМНЭЧИЛГЭЭНД
 ХАМРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ.....

Д.НЯМБАТ. ГЭМТ ХЭРГИЙН ГАЗРЫН ЗУРАГ.....

Д.БУЛГАН. ЯЛТАНЫГ НИЙГЭМШҮҮЛЭХ НЬ ГЭМТ ХЭРГЭЭС УРДЬЧИЛАН СЭРГИЙЛЭХ
 АРГА МӨН.....

Д.МӨНХЖАРГАЛ. ТУСГАЙ БЭЛТГЭЛТЭЙ БҮЛГИЙН МЭРГЭН БУУДАГЧ, ТҮҮНИЙ ҮЙЛ
 АЖИЛЛАГААНД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ.....

Г.МӨНХ-ЕРТӨНЦ. МОНГОЛЧУУД ГАЗРЫН ЗУРАГ ХИЙЖ БАЙСАН НЬ.....

БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН АСУУДАЛ

С.ОРГИЛ. БНХАУ-ААС МОНГОЛ УЛСАД ХУДАЛДАА, ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН
 АЖИЛЛАГААНЫ БҮС БАЙГУУЛАХ БОЛОМЖИЙН ТУХАЙ СУДАЛГАА.....

Л.ЦОГТБАЯР. ХУУЛЬ САХИУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ДАХЬ СЭТГЭЛГЭЭНИЙ ТУЛГАМДСАН
 АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ, ЧИГ ХАНДЛАГА.....

Ч.БАТЧИМЭГ. ЦАГДААГИЙН АЖИЛ-ЭРХ ЗҮЙ МЭРГЭЖЛЭЭР СУРАЛЦАГЧ НАРЫН
 ХАРИЛЦААНЫ УР ЧАДВАРЫГ ГАДААД ХЭЛНИЙ СУРГАЛТААР
 ТӨЛӨВШҮҮЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ.....

ОРЧУУЛАГЫН НИЙТЛЭЛ

О.НАРАНТУЯА. ГАДААД ОРНУУДЫН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЦАХИМ ГЭМТ ХЭРГИЙН
 ТАЛААР ТУСГАСАН НЬ.....

ГАДААД ХЭЛ ДЭЭР БИЧИГДСЭН ӨГҮҮЛЭЛ НИЙТЛЭЛ

П.ЭРДЭНЭБААТАР. ПРАВОВЫЕ ОСНОВЫ АДМИНИСТРАТИВНОЙ ОТВЕТСТВЕННОСТИ
 ДОЛЖНОСТНЫХ ЛИЦ В МОНГОЛИИ

ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН НОТЛОХ БАРИМТЫН
ОЙЛГОЛТ, АНГИЛАЛ



Д.Мөрөн

Монгол Улсын Гавъяат Хуульч

БНМАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх 1963 оны хуулиас Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх шинэ хууль 2002 онд батлах хүртэл нотлох баримтын тухай ойлголтыг хэрхэн тодорхойлох талаар онолын маргаан хүчтэй дэгдсэн болно. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 79 дүгээр зүйлд зааснаар гэмт хэргийн нөхцөл байдлын талаар энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан баримт сэлт, мэдээллийг нотлох баримт гэнэ. Гэхдээ хууль тогтоогч баримт сэлт, мэдээлэл гэж юу болохыг тайлбарлаагүй.

Энд онолын зарим эх сурвалжаас дурдъя.

Профессор Б. Бат-эрдэнэ: “нотлох баримт гэдэг нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан баримт сэлт, мэдээлэл мөн”- хэмээн нотлох баримтын онцлог шинжийг тодорхойлжээ¹.

Профессор Д. Баярсайхан: “Нотлох баримт гэдэг нь тухайн хууль зүйн факт гэмт хэрэг мөн эсэхийг эрх зүйн хэм хэмжээний дагуу процессын арга, хэрэгслээр бүх талаар батлах буюу няцаах замаар илрүүлж, хянан тогтоосон бүхий л мэдээлэл, тэдгээрийн баримтат эх сурвалжийн нийлбэр цогц мөн”²-гэжээ.

М.А.Чельцовын үзэж байгаагаар, баримт сэлт, мэдээлэл гэдэг нь гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж тэмдгийг зааж буй материаллаг ертөнцийн үзэгдэл, өөрөөр хэлбэл, бодитоор байсан нөхцөл байдал, үйл явдал мөн³. Харин М.С. Строгович нотлох баримтыг, нэгдүгээрт, гэмт хэрэг болон эрүүгийн хэрэгт нотолбол зохих баримт, хоёрдугаарт, эдгээр мэдээллийн эх сурвалж хэмээн үзсэн байдаг⁴.

Хэдий тийм боловч бусад эрдэмтэн дээрх тодорхойлолтыг дэмжээгүй. Нэгдүгээрт, ерөнхийд нь авч үзвэл, бодит нөхцөл байдал мөрдөн байцаалт, шүүх ажиллагааг хэрэгжүүлж буй хүнээс огт шалтгаалахгүйгээр оршиж байдаг. Тодорхой баримтыг нотолгоонд ашиглахад түүнийг хэн нэгэн хүн танин мэдэн, ухамсартаа тусгасан байх шаардлагатай.

Гэмт хэргийг бүрдүүлж буй баримтыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч мэдэрч чадах уу? Үгүй. Учир нь гэмт хэрэг нотолгооны үед болж өнгөрсөн үйл явдал болсон байдаг. Хэрэв мөрдөн байцаагч гэмт хэрэг үйлдэгдэхийг харсан бол гэрч болж, түүнийг татгалзах үндэслэл бий болно.

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч гэмт хэргийн материаллаг байдлаар үлдсэн ул мөр/цус, тээврийн хэрэгслийн мөр, баримт бичиг г.м/, аль эсвэл хүмүүсийн оюун санаанд хадгалагдсан төсөөллийг л шууд хүртэж мэдэрдэг онцлогтой. Эдгээр нь баримт бус, харин тэдгээрийн тухай мэдээлэл юм⁵.

В.Я. Дороховын үзэж байгаагаар, нотолгооны зүйлд хамаарах баримт болон бусад баримтыг нотлох баримт гэж үзэж болохгүй. Хүний оюун ухаанд эд зүйл биш,

¹ Бат-эрдэнэ Б. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. Ерөнхий анги. Улаанбаатар, 2004, 128 дахь тал.

² Баярсайхан Д. Эрүүгийн процессын эрх зүй. Улаанбаатар, 2014, 137 дахь тал.

³ Чельцов М.А. Советский уголовный процесс. М., 1962. С.132-135.

⁴ Строгович М.С. Курс советского уголовного процесса. М., Т.1. С.288-289

⁵ Карнеева Л.М. Доказательства в советском уголовном процессе. // Советский уголовный процесс. М., 1982. С.119-120

түүний тухай ойлголт, төсөөлөл, мэдээлэл оршиж байдаг⁶. Хоёрдугаарт, бодит ертөнц дэх баримтыг өөрийг нь таньж мэдэх, нотлох шаардлагатай байдаг тул түүнийг нотлох баримт гэж үзэх боломжгүй.

Гуравдугаарт, материаллаг ертөнц дэх баримт нь бодитой оршин байдаг тул үнэн, аль эсвэл худал байдаггүй. Харин түүний тухай мэдээлэл үнэн, эсвэл худал байх боломжтой.

Сэжигтэн, яллагдагч гол төлөв худал мэдүүлэг өгдөг. Гэрч, хохирогч хүртэл төрөөлдөж, санаатай гажуудуулж худал мэдүүлэг өгөх явдал заримдаа гардаг.

Тэгэхээр “баримт сэлт, мэдээлэл” гэсэн нэр томъёог “баримтын тухай мэдээлэл” гэж ойлгож болохоор байна. Баримт сэлт, мэдээлэл нь эрүүгийн процессын хувьд 6 төрлийн учир холбогдолтой: а/эрүүгийн процессын нотлох баримт, б/нотолгооны хэрэгсэл, в/нотлох баримтын бүтцийн элемент, г/баримтын тухай мэдээлэл, д/бодит баримт.

Мэдээллийг хуульд заасан эх сурвалжаас олж авсан нөхцөлд л тэр нь нотлох баримтын хуулийн хүчин чадалтай болно гэдгийг анхаарвал зохино. Эдгээрт сэжигтэн, яллагдагчийн мэдүүлэг, хохирогч, гэрчийн мэдүүлэг, шинжээч, мэргэжилтний дүгнэлт, мэдүүлэг, эд мөрийн баримт, мөрдөх болон шүүх ажиллагааны тэмдэглэл болон бусад баримт бичиг хамаарна.

Нотлох баримтын тодорхойлолтоос үзэхэд, мэдээллийг хуулиар тогтоосон журмын дагуу цуглуулж, ашиглах шаардлагатай. Энэ нь нотлох баримтыг хуульд заасан аргаар тогтоосон журмын дагуу олж авч, бэхжүүлнэ гэсэн үг. Үүнээс гадна, нотлох баримтын бас нэгэн чухал чанар бол түүний тусламжтайгаар эрүүгийн хэргийг мөрдөх явцад нотолбол зохих нөхцөл байгаа эсэх, хэрэгт ач холбогдол бүхий өөр бусад нөхцөл байдал байгаа эсэхийг тогтоодог.

Ийм байдлаар, нотлох баримтын дараах шинжийг онцлох боломжтой:

1/Мөрдөж буй гэмт хэрэгтэй холбоо бүхий баримтын тухай мэдээлэл;

2/Эдгээр мэдээллийг хуульд заасан эх сурвалжаас авсан байх шаардлагатай;

3/Эдгээр мэдээллийг процессын журмын дагуу олж авч, бэхжүүлсэн байвал зохино;

4/Эдгээр мэдээлэл нь эрүүгийн хэрэгт нотолбол зохих нөхцөл байдлын талаар байх ёстой.

Дээр дурдсаныг үндэслэн дараах тодорхойлолтыг томъёолж болохоор байна:

Нотлох баримт гэдэг бол эрүүгийн хэрэгт нотолбол зохих, хуульд заасан эх сурвалжаас, тогтоосон журмын дагуу олж авсан нөхцөл байдлын талаарх аливаа мэдээлэл мөн.

Эдгээр мэдээллийг үндэслэн мөрдөн байцаагч болон шүүгч хууль зүйн учир холбогдолтой баримтыг олж илрүүлэн, эрүүгийн хэргийн талаар үнэн зөв шийдвэр гаргах үүрэгтэй.

Нотлох баримтын тодорхойлолтыг үргэлжлүүлээд, мэдээлэл болон түүний эх сурвалжийн харилцан холбоог авч үзэх хэрэгтэй. Учир нь нотлох баримтыг үнэлэхдээ түүний эх сурвалжийг давхар үнэлдэг.

Нэг талаас, нотлох баримт болон эх сурвалжийн нийлээд нэг цул эх сурвалжийг бүрдүүлдэг бөгөөд нотлох баримтыг процессын тодорхой эх сурвалжаас ангид авч үзэх боломжгүй. Энэхүү нэгдэл нь хэлбэр ба агуулгаар илэрхийлэгдэх бөгөөд эх сурвалжийг хэлбэр, харин нотлох баримтыг агуулга гэж тооцож болно.

⁶ Дорохов В.Я.Понятие доказательств//Теория доказательств в советском уголовном процессе.М.,1973.С.207-211

Жишээлбэл: Хэргийн газрын үзлэгийн тэмдэглэлд хэрэг гарсан нөхцөл байдал, ул мөр, эд мөрийн баримт тусгагддаг. Уг тохиолдолд хэргийн газрын үзлэгийн тэмдэглэл нотлох баримтын эх сурвалж/хэлбэр/, харин түүнд тусгагдсан мэдээлэл нотлох баримт/агуулга/ болно. Үүнтэй мөн адил шинжээчийн дүгнэлт өөрөө-эх сурвалж, түүнд тусгасан мэдээлэл, тусгай мэдлэг бүхий хүний дүгнэлт-нотлох баримт байна. Эд мөрийн баримтын тухайд бол тухайн объект-эх сурвалж, түүн дээр байгаа ул мөр, шинж тэмдэг-нотлох баримтын үүрэг гүйцэтгэнэ.

Нөгөө талаас, нотлох баримт болон эх сурвалжийг хооронд нь зааглавал зохино. Учир нь нотолгооны үр дүнд хүрэхийн тулд мэдээллийг шалгаж, шинжлэн судалж, үнэлэх хэрэгтэй болдог. Нэг баримтын тухай мэдээлэл хэд хэдэн эх сурвалжид, эсвэл эсрэгээрээ нэг эх сурвалжид хэд хэдэн баримтын тухай мэдээлэл агуулагдаж байх боломжтой. Мэдээж хэрэг, хэд хэдэн эх сурвалжаас олж авсан нэг баримтын тухай баттай мэдлэг илүү чанартай байх нь ойлгомжтой.

Тэгэхээр нотлох баримт болон түүний эх сурвалж нэгдмэл хэдий ч тус тусдаа бие даасан эрх зүйн ойлголт юм.

Гэсэн хэдий ч Эрүүгийн байцаан шийтгэх хуульд уг ялгааг зааглаагүй: нотлох баримт болон эх сурвалжийг бүхэлд нь нотлох баримт гэж томъёолсон. ЭБШХ-ийн 79.2-т: Хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий баримт сэлт, мэдээлэл нь гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт, мэдүүлэг, эд мөрийн баримт, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүх хуралдааны тэмдэглэл болон бусад баримтаар тогтоогдоно-гэж заасан байна.

Эндээс нотлох баримт гэдэг нь “мэдээлэл” юмуу, аль эсвэл уг мэдээллийг агуулсан процессын хэлбэр юмуу ? гэсэн зүй ёсны асуулт урган гарна. Эрх зүйн өөр өөр ойлголтыг “нотлох баримт” гэсэн нэр томъёогоор илэрхийлсэнийг арга зүйн хувьд зөв гэвэл учир дутагдалтай. Тэгэхээр нотлох баримтын тодорхойлолт нэг л байвал зохино.

Уг зөрчлийг арилгахын тулд ЭБШХ-ийн 79.1-д заасан нотлох баримтын тодорхойлолтыг тэр хэвээр нь үлдээгээд 79.2-т: “...бусад баримтаар...” гэсний оронд: “...бусад эх сурвалжаар...” гэж оруулбал нотлох баримт агуулга болж, эх сурвалж процессын хэлбэр болон, дээрх 2 ойлголт өөр өөрийн байр суурийг эзлэх боломжтой болно.

Нотлох баримтын ангилал нь түүний шинж чанар, нотолгооны явцад ашиглах онцлогийг нь нээн гаргахад ач холбогдолтой. Нотлох баримтыг тусад нь болон эх сурвалжтай нь хамт ангилж болно.

Яллах ажиллагаатай холбоотойгоор яллах нотлох баримт ба цагаатгах нотлох баримт гэж хувааж болно.

Яллах нотлох баримт нь сэжигтэн, яллагдагчийг гэмт хэрэг үйлдсэнд нь илчилж, ял хүндрүүлэх нөхцөл байдлыг тогтоодог.

Жишээлбэл, хулгайн хэргийн газраас илрүүлсэн гарын мөр сэжигтнийх мөн гэсэн шинжээчийн дүгнэлт. Энэ нь яллах нотлох баримт мөн. Түүнчлэн, 3 хүн дээрмийн халдлага үйлдсэн тухай хохирогчийн мэдүүлэг нь ял хүндрүүлэх нөхцөл байдлын тухай мэдээлэл болно.

Цагаатгах нотлох баримт нь яллагдагчийг цагаатгах юмуу ял хөнгөрүүлэх нөхцөл байдлыг тогтооно. Жишээлбэл: Таньж олуулах ажиллагаа явуулахад хохирогч урьд нь мэдүүлэгтээ дурдсан хүн байхгүй байна гэж мэдэгдэх. Ял хөнгөрүүлэх нөхцөл байдал гэвэл 14-18 насны хүн, өөрөөр хэлбэл насанд хүрээгүй хүн гэмт хэрэг үйлдсэн гэдгийг тогтоосон байж болно.

Нотолгооны зүйлд хамааруулан нотлох баримтыг шууд нотлох баримт ба шууд бус нотлох баримт гэж ангилж болно.

Нотолбол зохих нөхцөл байдлыг шууд тогтоож буй нотлох баримтыг шууд нотлох баримт гэнэ.

Тухайлбал, ослын актад тээврийн хэрэгслийн гэмтэл, засварлах өртөг зэрэг нь гэмт хэргийн улмаас учирсан хохирлын шинж чанар, хэр хэмжээг тодорхойлно /ЭБШХ-ийн 80.1.5/. Гэмт хэрэг гарсан байдлын талаарх хохирогчийн мэдүүлэг мөн шууд нотлох баримтад хамаарна /ЭБШХ-ийн 80.1.1/.

Шууд бус нотлох баримтад ЭБШХ-ийн 80-р зүйлд заасан нөхцөл байдлыг шууд бусаар тогтооход хэрэгтэй мэдээлэл орно.

Шууд бус нотлох баримт нь тогтоосон үйл явдлын өмнө болж өнгөрсөн, аль эсвэл дагалдаж бий болсон баримтын тухай мэдээллийг агуулж байдаг бөгөөд тэдгээрийг үндэслэн, гэмт хэрэг үйлдэгдсэн эсэх, тухайн яллагдагч гэм буруутай эсэх талаар дүгнэлт хийдэг. Жишээлбэл, хүн алах хэргийг мөрдөх явцад шууд бус нотлох баримтыг /яллагдагчийн хутгаар хүн алсан, хэргийн газарт түүний гутлын мөр олдсон, яллагдагч хохирогчтой эв түнжингүй байсан зэрэг/ үндэслэн, тухайн яллагдагч уг хэргийг үйлдсэн эсэх талаар дүгнэлт хийнэ.

Зөвхөн шууд бус нотлох баримтаар нөхцөл байдлыг тогтоох нь шууд нотлох баримтыг бодвол нэлээд төвөгтэй.

Үүсэн бий болсон шинж байдлаас хамаарч нотлох баримт болон түүний эх сурвалжийг анхдагч ба дамжмал гэж хуваана.

Анхдагч эх сурвалжаас үүссэн нотлох баримтыг *анхдагч нотлох баримт* гэнэ. Тэдгээрт боловсролын баримт бичгийн эхэд буй мэдээлэл, нүдээр харсан гэрчийн мэдүүлэг, эд мөрийн баримт хамаарна.

Дамжмал нотлох баримт гэдэг нь хоёрдогч эх сурвалжаас олж авсан мэдээлэл юм. Энэ нь дээд боловсролын дипломын хуулбар, нүдээр харсан гэрчээс гэмт хэргийн талаар мэдэж авсан гэрчийн мэдүүлэг байж болно.

Мэдээллийн эх сурвалжаас шалтгаалан нотлох баримтыг хувийн нотлох баримт ба эдийн мөрийн баримт гэж ангилна.

Хувь хүнээс эхтэй нотлох баримтыг *хувийн нотлох баримт* гэнэ. Үүнд хохирогч, гэрч, сэжигтэн, яллагдагч, шинжээч, мэргэжилтний мэдүүлэг, шинжээч, мэргэжилтний дүгнэлт хамаарна.

Материаллаг эд зүйл эх сурвалж нь болдог нотлох баримтыг *эд мөрийн баримт* гэдэг. Гэмт хэргийн багаж зэвсэг, ул мөр бүхий эд зүйл, халдлагын зүйл, хэргийн нөхцөл байдлыг тодруулахад хэрэгсэл болж болох бусад эд юм, баримт бичиг үүнд орно.

Мэдээлэл хадгалах, дамжуулах аргаас хамааруулан нотлох баримтыг тэмдэгт *нотлох баримт* ба *тэмдэгт бус нотлох баримт* хэмээн ангилж болох талтай.

Мэдүүлэг, тэмдэглэл, баримт бичиг болон амаар болон бичгээр илэрхийлэгдэх ердийн болон зохиомол хэл /математик, кибернетик, логикийн томъёо/ ашигласан мэдээллийг *тэмдэгт нотлох баримтад* хамаарна.

Тэмдэгт бус нотлох баримт /материаллаг/ гэдэгт эд мөрийн баримт болон харьцуулах шинжилгээний загвар орно. Үүнд гар бичмэлийн чөлөөт болон туршилтын загвар, гарын хээний дардас, цус, шүлсний сорьц, сумны хошуу, хонгио, хөрсний сорьц гэх мэт хамаарна.

**ХУУЛЬ ЁСНЫ ЭРХЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ ГЭМТ ХЭРГИЙГ ҮГҮЙСГЭХ НӨХЦӨЛ
БАЙДАЛ БОЛОХЫГ ОЛОН УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖИД
ТУСГАЖ ИРСЭН НЬ**



Б.Хишигтогтох

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн, МАОТ-ийн
ахлах багш, цагдаагийн дэд хурандаа, докторант

Сүүлийн жилүүдэд гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлыг дагнаж судалсан олон улсын эрүүгийн эрх зүйн бүхэл бүтэн, бие даасан салбар (институт) үүссэн байна. Гэхдээ энэ нь олон улсын эрх зүйн хувьд нилээд, этгээд зүйлээс эхэлсэн байдаг нь сонирхол татдаг. Тухайлбал тодорхой нөхцөлд тухайн хүн хийж гүйцэтгэсэн үйл ажиллагаагаа “тушаал шийдвэрийг хэрэгжүүлсэн” гэж үзсэн улмаар түүнийг нь гэмт хэрэгт тооцох эсэх, уг асуудлыг хууль-эрх зүйн хувьд хэрхэн шийдвэрлэх вэ? гэдгээс бүх асуудал эхэлжээ. Тухайлбал: НҮБ-ын Олон улсын эрх зүйн комисс, Нюрнбергийн хэргийг хэлэлцэхдээ “Хэрвээ тухайн хүн өөрийн хийж байгаа үйл ажиллагаагаа үнэхээр ухамсартайгаар, бодитойгоор хэрэгжүүлсэн бол засгийн газар буюу даргын тушаал-шийдвэрийг гүйцэтгэсэн ч гэсэн хариуцлагаас чөлөөлөгдөхгүй”⁷ гэж шийдвэрлэсэн байдаг.

Хууль тогтоомжийн энэхүү заалт нь олон улсын эрүүгийн шүүхийн Римийн эрх зүйн баримт бичгийн 33-р зүйлийн үндэслэл болсны дагуу “Хуулийн урьдчилсан заалт ба даргын тушаал гэсэн бие даасан эрх зүйн баримт бичиг гаргахад хүргэсний улмаас дараахи нөхцөл байдалд хийсэн үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй байхаар тогтоосон байдаг. Үүнд:

а) Тухайн этгээд засгийн газар ба шууд захирах даргынхаа тушаалыг хэрэгжүүлэх үүргийг хууль ёсны дагуу хүлээсэн бол.

б) Тухайн хүн уг тушаал хууль бус гэдгийг мэдээгүй байсан бол.

в) Уг тушаалын илтэд хууль бус гэдэг нь мэдэгдэхгүй байсан бол уг үйлдэлийг гүйцэтгэсэн ч гэмт хэрэгт тооцогдохгүй”⁸ гэж үзсэн байна. Тэгэхдээ дээрхи нөхцөл байдлуудын сүүлийн хоёр тохиолдол нь гагцхүү даргын тушаалд хамаарах бөгөөд дурьдсан баримт бичгийн 33.2 дахь зүйлд заасан зүйл тухайлбал хүнийг аймаглан устгах буюу хүн төрөлхтний эсрэг хийсэн гэмт хэрэг нь илтэд хууль бус зүйл тул эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөхгүй болох нь тодорхой учир заасан тохиолдлоос өөр төрлийн үйл ажиллагаа буюу хуульд урьдчилан заасан ба хууль ёсны тушаалыг биелүүлсэнээс байгаа бусад үйл ажиллагаануудыг гэмт хэрэг үйлдсэнд тооцдог байв.

Тэгэхдээ энэ баримт бичигт “Гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал” гэсэн нэр томъёо-томёололыг огтхон ч хэрэглэдэггүй байсан гэдгийг дурьдах нь зүйтэй. Энэ тухай А.Г.Кибальник бичихдээ: “... аливаа улсын эрүүгийн эрх зүйд уламжлал ёсоороо тухайн үйл ажиллагааны хууль цаазын мөн чанар нөхцөлийг харгалзан дараахь тохиолдлуудыг гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалд хамруулж байв. Тухайлбал:

- Тухайн этгээд үнэхээр гэмт үйлдлийн халдлагаас хамгаалах зорилгоор тийм нөхцөл байдал бодитой тулгарсан үед бусдад гэм хор учруулбал;

- Хэрэг хариуцах чадваргүй этгээд бусдад гэм хор учруулбал;

⁷ Нюрнбергский процесс: право против войны и фашизма (ред. И.А.Ледях, И.И.Лукашук) М.1995.113-р тал

⁸ Римский статус Международного уголовного суда. М.2000, 57-р тал

- Хууль цаазны алдаанаас буюу бодит нөхцөл байдлыг үнэхээр андуурснаас бусдад хор хохирол учруулбал тус гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалд тооцох үндэслэлтэй”⁹ гэснийг бид дэмжиж байна.

Дээр дурьдсан нөхцөл байдлууд нь тухайн этгээдийг зөвхөн хариуцлагаас чөлөөлөөд зогсохгүй хийсэн үйл ажиллагаа нь олон улсын эрүүгийн эрх зүй ба тухайн улсын (жишээлбэл Монгол Улсын) үндэсний хуулиар хамгаалсан эрх ашигт хохирол учруулсан байсан ч гэсэн үүрэг болгосон, хууль ёсны ажиллагаа гэж үзэх талтай.

Ийнхүү орчин үеийн олон улсын эрүүгийн хууль тогтоомжид дүн шинжилгээ хийж үзвэл ихэнх улс хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалд тооцож үзэх байдлаар, зонхилон эрүүгийн эрх зүйнхээ ерөнхий ангид гол үндэслэлүүдийг нь зааж өгсөн бөгөөд ер нь энэ чиглэлийн бодлого нь нилээд олон жилийн уламжлалтайн дээр гол төлөв үүнийг хууль ёсны зарчимдаа хамааруулан үзэж дээр гэмт хэрэг ба гэмт хэргийн бус үйл явдлыг нарийн зааглах, нэн ялангуяа бодит шалгуурыг нь хуулинд тодорхой урьдчилан заах асуудлыг онцгой анхаарч иржээ.

Ер нь гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлын хэмжээ хязгаар, шалгуурыг гагцхүү эрүүгийн хуулинд бодитой тодорхойлон заах шаардлагатай, эрүүгийн хууль тогтоомжоос өөр төрлийн хуульд үгүйсгэх нөхцөл байдлуудын шалгуурыг заавал тэр нь эцсийн дүндээ хууль ёсны зарчмыг зөрчихөд хүргэх болно гэдгийг ихэнх судлаачид санал нэгтэй дэмждэг байна.

Дээр дурьдснаас үндэслэж дүгнэвэл гадаад орнуудын хууль тогтоомжид хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг тодорхойлох ерөнхий үндэслэл-шалгуур нь нийтдээ нилээд төсөөтэй боловч харин үгүйсгэх нөхцөл байдлыг тодорхойлж буй хууль тогтоомжийн хэлбэр нь харилцан адилгүй байгаа нь анхаарал татаж буй боловч хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг тодорхойлж байгаа хууль тогтоомжийн хэлбэрийг үндсэн 3 хэсэгт хувааж болох талтай байна.

Үүнд:

Нэгдүгээр хэсэгт тухайн болсон бодит үйл ажиллагаа нь нэн ялангуяа хэлбэрийн хувьд түүнчлэн агуулгын хувьд ч гэсэн гэмт хэргийн шинжийг илэрхийлдэг боловч мөн чанарын хувьд гэмт хэрэгт тооцохгүй байх тухай нилээд ерөнхий үндэслэлүүдийг заасан байдаг.

Хоёрдугаар хэсэгт гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлуудын нилээд төрөлжсөн хэлбэрүүд буюу нэн ялангуяа эрүүгийн хуулиар хамгаалсан эрх ашигт хохирол учруулсан үйл ажиллагааны нөхцөл байдлуудыг, нарийвчлан заасан хууль тогтоомжууд;

Гуравдугаар хэсэгт гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлуудын нийтлэг үндэслэл-шалгуурыг заахын хамтад хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа нөхцөл-журмыг тусгайлан зохицуулсан хэм хэмжээ бүхий хуулиуд эдгээр болно. Нэгдүгээр хэсэгт хамаарах эрүүгийн хууль тогтоомжтой улс гэвэл Голланд, Испани, Япон, Франц, Швецарь зэрэг болно. Тухайлбал Голланд Улсын эрүүгийн хуулийн 43-р зүйлд заахдаа “хууль ёсны шаардлагаа хэрэгжүүлэхдээ эрх зүйн зөрчил гаргасан этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй”¹⁰ гэсэн байна.

Энэ зүйлийн томъёолол ялангуяа “шаардлага” (хууль ёсны) гэсэн үг нь нилээд маргаан дагуулдаг байна. Яагаад гэвэл “шаардлага” нь тэр болгон хууль ёсны нэн ялангуяа эрх зүйн мөн чанарын хувьд тэр болгон хуулиар тогтоосон тодорхой журам, нөхцөлтэй нийцэхгүй байж болох талтай гэдгийг бодит амьдрал-практик алхам тутамдаа харуулж байдаг.

Харин Испани улсын 1995 онд баталсан одоо дагаж мөрдөж буй эрүүгийн хууль нь баруун Европын эрүүгийн эрх зүйн орчин үеийн шаардлага, хандлагыг

⁹ Кибальник.А.Г. Введение в международное уголовное право.Ставрополь, 2001.183-р тал

¹⁰ Голландия. Законы.Уголовный кодекс Голландий, СПб 2000, 73-р тал

бодитой тусган илэрхийлсэн байна. Жишээлбэл: Испани улсын Эрүүгийн хуулийн 21 дүгээр зүйлд дараахь тохиолдолд хийсэн үйл ажиллагааг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөхөөр заажээ.

Тодруулбал “албан тушаалын ба мэргэжлийн үүргээ хэрэгжүүлэхдээ хуульд тодорхойлон заасан үндэслэл, журмыг яг нэгэн мөр ягштал хэрэгжүүлсэн нөхцөлд уг этгээдийг бусдад гэм хор учруулсан ч гэсэн эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө”¹¹ гэжээ. Энэ заалттай бараг адилхан үндэслэлийг Швецари улсын эрүүгийн хуулийн 32 дугаар зүйл буюу “Эрх ёсны үйлдлүүд”¹² гэсэн 8-р бүлэгт тодорхойлсон байна.

Хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх үйл ажиллагааг гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалд тооцох тухай зохицуулалтыг Япон улсын Эрүүгийн хуулийн 35-р зүйл буюу “Гэмт хэргийн бүрэлдэхүүн үүсэхгүй байх нөхцөл байдлууд” гэсэн 7-р бүлэгт нилээд дэлгэрэнгүй тусгаж “хууль тогтоомжид урьдчилан заасан нөхцөл байдалд буюу эрх ёсны (хууль ёсны) үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх тохиолдолд ял шийтгэл хүлээлгэхгүй”¹³ гэсэн ерөнхий үндэслэл-томъёоллыг тодорхойлж өгчээ.

Энэхүү хууль тогтоомжийн заалт-үндэслэлийн онцлогийн талаар Японы эрдэмтэн Сугияма, Вата нар бичихдээ “Энэхүү үйл ажиллагаа хуульд заасан үндэслэлийн дагуу болсон уг үйл ажиллагаа нь хэлбэрийн хувьд (мөн чанарын хувьд ч гэсэн) гэмт хэргийн бүрэлдэхүүнийг буй болгож болох боловч гэмт хэрэгт тооцогдохгүй Жишээлбэл: Цаазаар авах таслан шийдвэрлэх тогтоолыг хэрэгжүүлж байгаа түүнчлэн тодорхой этгээдийн биеийн хүчний эрх чөлөөг хязгаарлаж байгаа буюу өөрт олгогдсон эрхийн дагуу тодорхой гэмт этгээдийг баривчлан саатуулж байгаа цагдаагийн ажилтны үйл ажиллагаа нь гэмт хэргийн бүрэлдэхүүнийг буй болгохгүй, цаашилбал хуулиар хүлээн зөвшөөрсний дагуу тодорхой үйл ажиллагаа явуулж байгаа тухайлбал янз бүрийн бооцоот тоглоом (жишээ нь морин уралдаан, сугалаа (лотерей) зэрэг нь гэмт хэрэг болохгүй гэсэн бол Японы Васэда хотод болсон онол-практикийн бага хуралдаанд илтгэл хэлэлцүүлсэн зохиогчид дараахь үйл ажиллагаануудыг:

1.Албаны үүргээ биелүүлж байгаа. Жишээлбэл: тодорхой сэжигтнийг баривчилж байгаа цагдаагийн үйлдэл.

2.Өөртөө байгаа эрхээ хэрэгжүүлж буй. Жишээлбэл: хүүхдээ цээрлүүлж байгаа эцэг эхийн болон гэмт этгээдийг газар дээр нь үйл ажиллагааг нь таслан зогсоож байгаа тодорхой хувь хүний үйлдэл.

3.Нийтээр хүлээн зөвшөөрч дагаж мөрдөж байгаа тодорхой шашны зан үйл ёсоор жирэмслэлтийг зогсоож байгаа үйл ажиллагаа, хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн оргон зайлалт зэргийг гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалд хамааруулан үзэх үндэстэй¹⁴ гэсэн санал дэвшүүлсэн нь үнэхээр сонирхол татахуйц, шуугиан тарьсан зүйл болжээ.

Цаашилбал дээр дурьдсан хурлын зарим илтгэлд спортын төрөл бүрийн тулаан (бокс, сумо г.м), эмч нарын төрөл бүрийн эмчилгээнүүд (янз бүрийн мэс заслын ажилбар) зэрэг нь холбогдох бодит үндэслэлүүдийг нь тогтоосон нөхцөлд бүгд хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа ажиллагаанд тооцогддог, тодруулбал мэргэжлийн тамирчин уралдаан тэмцээнд оролцох, өмгөөлөлийн төрөл бүрийн ажиллагаа, сэтгүүлч-сурвалжлагчийн тухайн чиглэлээрээ холбогдох янз бүрийн материал

¹¹ Испания. Законы. Уголовный кодекс. Испаний. /офиц. Текст./под ред. И предисловий И.Ф.Куцнецовой и Ф.М.Решетникова.

¹² Швецария.Законы.Уголовный кодекс Швецурий.офиц текст. СПб, 2002, 84-р тал

¹³ Уголовное законодательство заруежных стран (Англий,США, Франций, Германий,Японий) М, 2001.338-р тал

¹⁴ Основы законий уголовного права. 1 Общая часть / составлено семинаром Васэда для экзамены на право занятия юридической деятельностью/ Токио, 1997, 43-р тал
Уголовное право зарубежных государств. / под. ред. Проф.И.Д.Казочкина. М.2003, 472-р тал /

цуглуулах зэргийг хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа ажиллагаанд хамааруулж үзсэн байна.

Гэхдээ энэ нь бидний үзэж байгаагаар гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалд тэр болгоныг нь хамааруулан үзэхэд учир дутагдалтай. Яагаад гэвэл ямар ч ажил мэргэжлийн болон албан тушаалын төрөл бүрийн үйл ажиллагаа нь хууль ёсыг зөрчихгүй байх ёстой гэдэг нь хууль-эрх зүйн үндсэн нөхцөл болох ёстой.

Франц улсын Эрүүгийн хуулийн 102-р зүйлийн 4 дэх хэсэгт заахдаа “аливаа хууль дүрэмд урьдчилан заасан буюу зөвшөөрсөн ямарваа үйлдэл хийсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй, цаашилбал хууль ёсны засаг захиргааны шаардлагын дагуу илтэд хууль бус үйлдэл хийгээгүй этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө”¹⁵ гэжээ.

Ер нь хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйлдлийг гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалд өргөн хамааруулж үздэг нь Францын эрүүгийн эрх зүйн хувьд нилээд эртний уламжлалтай бөгөөд энэ нь бүр 1810 оны эрүүгийн хуулиас эхлэлтэй ажээ. Энэхүү уламжлалаа одоо ч хадгалсаар буй тул 1992 онд эрүүгийн хуулиа өөрчлөхдөө дурьдсан нөхцөл байдлуудын үндэслэл, шалгуурыг нилээд нарийвчилж зөвхөн хуульд заасан төдийгүй тодорхой эрх зүйн акт-дүрэм, заавар зэрэгт заасан үндэслэлээр гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлыг тогтоож мэргэжлийн ба албан тушаалын үүрэг төдийгүй нийгмийн эрх, үүргээ хэрэгжүүлсэн тохиолдлыг ч мөн адилтган үзсэн байна.

Түүгээр ч үл барам хүчний спортын янз бүрийн төрлүүд (бөх, бокс, регби г.м)–ийн явцад бусдад гэм хор учруулсан түүнчлэн тодорхой эмчилгээ-мэс засал буюу ажилбарын үед тухайн этгээдийн (хохирогчийн) “дуугүй (битүү)”, “зөвшөөрөл”–ийг тооцох тодорхой дүрэм журмыг хүртэл гаргасан байдгаараа онцлогтой бөгөөд иймэрхүү үзэл бодлыг дэвшүүлж байгаа Францын ихэнх зохиогч-мэргэжилтнүүдийн дийлэнх нь хуулинд урьдчилан заасан буюу хүлээн зөвшөөрсөн байдлын “цагаатгах” мөн чанарыг нь бодитой тогтоож өгөх ёстой гэж үздэг байна. Иймд төрийн болон олон нийтийн тодорхой үүрэг гүйцэтгэх талаар хуулинд урьдчилан зааж тухайн үйл ажиллагааны гэмт хэргийн мөн чанарыг үгүйсгэдэг байна.

Энэ тухай Францын эрдэмтэн М.Рассат бичихдээ: “тодорхой байгууллагын тухайн нөхцөлд хийсэн үйл ажиллагаа нь гол төлөв холбогдох хуулинд нь тодорхой заасан байдаг тул мөн чанарынх нь хувьд түүнийг цагаатгах, хүлээн зөвшөөрөх үндэстэй. Жишээлбэл: Мэс засалчийн хийж байгаа байгаа зүй ёсны хэвийн үйл ажиллагаа нь мөн чанарын хувьд үнэхээр “цагаатгах” үйлдэл байх боловч харин тухайн мэс засалчийн санамсаргүй байдлаар (хэвлийн хөндийд багаж мартах г.м) өвчтөнд гэм хор учруулбал түүнийг яав ч “цагаатгах” үндэслэлгүй үйлдэл болох нь нэн тодорхой тул уг ажиллагааг зохих журам стандартыг ягштал даган мөрдсөн ч гэсэн санамсаргүй байдлын улмаас гэм хор учруулсаныг нь тун нарийвчлалтай бодитой тогтоох шаардлагатай”¹⁶ гэжээ.

Энэ нь практикт нэн ярвигтай тул Францын зарим судлаачид хуулиар хүлээн зөвшөөрсөн зарим үйл ажиллагаануудыг тухайлбал гоо зүйн мэс хагалбарын нэн хүнд төрлүүдийг учруулсан хохиролынх нь мөн чанар үндэслэлийг харгалзан гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалд тооцохгүй байх нь зүйтэй гэдэг саналыг дэвшүүлжээ.

Ингэснээр Францын эрүүгийн хууль тогтоомжид хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа бодит үйл ажиллагааг зохицуулах хууль журмыг нарийвчлан боловсруулах нэн ялангуяа тэдгээрийн үйл ажиллагааны хэр хэмжээ шалгуурыг холбогдох хууль тогтоомжид заавал урьдчилан зааж өгөх шаардлагатай болсон байна.

¹⁵ Уголовное законодательство зарубежных стран (Англи, США, Францийы, Германий, Японий) М. 2001, 198-р тал

¹⁶ Rassat.M.L.Droit penal. Presses Universitaires de France.1987.P, 397 (цит. По книге: Уголовное право зарубежных государств) под. ред. проф. И.Д.Казочкина. М.2003, 818-р тал

Хоёр дахь хэсэгт хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны тодорхой хэлбэрүүдийг тухайн улсынхаа эрүүгийн хуульд шууд заасан улсууд хамаарах бөгөөд тухайлбал Швед, Украин, Беларусь, Казакстан, Литва зэрэг орныг дурьдаж болох юм.

Гэхдээ эдгээр улсын хуулийг хоёр дэд төрөлд хувааж болох талтай. Үүнд: нэгдүгээрт тухайн үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн хэм хэмжээ нь бланкет буюу заах шинжтэй, хоёрдугаарт уг хуулинд тодорхой эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг шууд заасан байдаг байна. Жишээ нь: Швед улс хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг зохицуулах хэм хэмжээгээ эрүүгийн эрх зүйн бус харин холбогдох салбар эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулдаг тул бланкет буюу заах төрлийн хэм хэмжээтэй байдаг ажээ. Тухайлбал, “Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх ерөнхий үндэслэлүүдийн тухай” гэсэн 5-р бүлгийн 24-т заахдаа “цагдаагийн (1984 он) тухай хуулийн 16-р зүйлд заасны дагуу тодорхой үйлдэл хийсэн хүнийг (цагдаагийн ажилтан) эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө гэсэн заасан бөгөөд тэгэхдээ уг үйл ажиллагааны ерөнхий нөхцөл, эрх зүйн үндэслэлийг нилээд нарийвчлалтай зааж өгсөн байна.¹⁷

Цаашилбал Украин, Беларусь, Казакстан, Литва зэрэг бүгд найрамдах улсуудын эрүүгийн хууль тогтоомжид хууль ёсны эрхээ хэрэгжүүлж буй үйл ажиллагааны тухай “тусгай даалгавар гүйцэтгэх явцад бусдад гэм хор учруулах тухай” (ерөнхийд нь утгачлан товчлов) гэсэн тусгай бүлэг байдаг бөгөөд энэ хэсгийг нь задлан шинжилж үзвэл хууль ёсны эрхээ хэрэгжүүлж буй үед учруулдаг гэм хорыг дараахь нөхцөл-төрөлд хувааж үзэж болох талтай байна. Үүнд:

1. Зайлшгүй шинжтэй ажиллагаа;
2. Зохион байгуулалттай бүлэглэл буюу гэмт хэргийн байгууллагад биечлэн оролцох замаар гүйцэтгэж байгаа тусгай даалгавар;
3. Ялангуяа зохион байгуулалттай бүлэглэл болон гэмт байгууллагын үйл ажиллагааг таслан зогсоох буюу илрүүлэх зорилготой тусгай ажиллагаа;
4. Уг үйл ажиллагааны (тусгай даалгавар) явцад онцолвол Украин улсын Эрүүгийн хуулийн 43.2-т зааснаас бусад гэмт хэрэг үйлдсэн зэрэг болно;

Гэвч бидний үзэж байгаагаар энэхүү дурьдсан үйл ажиллагааны (хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа) зохицуулалтанд нилээд учир дутагдал байна. Үүнд:

Нэгдүгээрт: Дээр дурьдсан үйл ажиллагаануудын бодит нөхцөл-журмыг тодорхойлохын тулд Украин улсын өөр бусад хууль, тухайлбал 2001 оны 3-р сарын 22-нд батлан гаргасан “Украины тагнуулын байгууллагуудын тухай хууль”, 1992 оны 02-р сарын 18-нд батлан гаргасан “Эрүүгийн эрэн сурвалжлах үйл ажиллагааны тухай хууль” зэргийг зөрчихөд хүргэсэн байна. Тухайлбал “Украины тагнуулын байгууллагын тухай хууль”-д заахдаа эрэн сурвалжлах ажиллагааны даалгаврыг хэрэгжүүлэх явцад уг ажиллагаанд эмнэлгийн ба шашны байгууллагын ажилтан, өмгөөлөгч, түүний үйлчлүүлэгч, эмнэлгийн өвчтөн нь хамрагдахаар байвал тэдгээрийг татан оролцуулахыг хориглоно гэж заажээ.¹⁸ Ийм учир зохион байгуулалттай бүлэглэл буюу гэмт байгууллагын үйл ажиллагаанд дээр дурьдсан хүмүүс ямар нэг байдлаар оролцож байвал тэдгээрийг эрэн сурвалжлах ажиллагаанд татан оролцуулах нь хуулиар хориотой буюу хууль ёсны бус үйл ажиллагаа болох нь тодорхой байна.

Хоёрдугаарт: Украин улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 385-р зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу гэрч мэдүүлэг өгөхөөс татгалзах, шинжээч, орчуулагч нар хүлээлгэсэн үүргийг хэрэгжүүлэхээс татгалзсан тохиолдлыг хэрхэн шийдвэрлэх вэ? гэдэг нь нилээд эргэлзээтэй; яагаад гэвэл эдгээр дурьдаж буй үйл ажиллагаа нь

¹⁷ Швеция.Законы.Уголовный кодекс Шведий. Офиц текст.М.2000, 105-р тал

¹⁸ Научно-практический комментарий Уголовного кодекса Украины от 5 апреля 2001 года / под. ред. Н.И.Мельника / Н.И.Хавронюка, Оиев, 2002, 142-р тал

үндэслэл, мөн чанарын хувьд бидний үзэж байгаагаар хууль ёсны эрхээ хэрэгжүүлж буй тохиолдолд хамаарах магадлалтай юм.

Гуравдугаарт: АНУ-ын Эрүүгийн хууль тогтоомжид гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлын зохицуулалт, нэн ялангуяа тэрхүү бодит үйл ажиллагааны илрэх хэлбэрийн талаар нилээд сонирхолтой үндэслэлүүдийг зааж өгсөн байдаг. Ялангуяа хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа тодорхой ажиллагаануудыг зохицуулах ерөнхий ба тусгай хэм хэмжээнүүдийг тодорхойлон заасан бөгөөд нэн ялангуяа тусгай хэм хэмжээнүүдийн нэмэгдэл нөхцөл байдлыг хуулинд тодорхойлон заахыг шаарддаг байна. Жишээлбэл: Пенсильвани мужийн эрүүгийн хуулийн 504-р зүйл нь “Нийтлэг эрхийг хэрэгжүүлэх” гэсэн нэртэй бөгөөд энэ зүйлд хууль ёсны эрхийг биелүүлэх ерөнхий журам, хуулиудыг тодорхойлж өгчээ. Үүнд:

1.Төрийн албан хаагчдад үүргээ хэрэгжүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, ерөнхий үүрэг-журам

2.Эрх зүйг хэрэгжүүлэх үйл явцыг зохицуулдаг хуулинд хүлээн зөвшөөрсөн ерөнхий журам

3.Эрх бүхий шүүх буюу цэргийн хээрийн шүүхийн тушаалаар зохицуулдаг урьдчилан тогтоосон зөвшөөрлүүд (ажиллагаа)

4.Хуулинд урьдчилан заасан тодорхой нөхцөлөөр зохицуулагддаг цэргийн алба түүнд холбогдох хууль

5.Нийтээр дагаж биелүүлэх үүрэг ажиллагаанд баримталдаг эрх зүйн аливаа акт (баримт бичиг) гэж төрөлжүүлсэн байна. Үүнээс гадна дурьдсан бүлгийн зарим заалтыг хэрэгжүүлэх онцгой тохиолдлуудыг зааж өгчээ. Үүнд:

а) Тухайн зүйлд заасан журмыг зайлшгүй хэрэгжүүлэхийн тулд тодорхой этгээдийн хүчирхийллийг газар дээр нь таслан зогсоож болно.

б) Дайны цагт холбогдох тусгай хуулинд тодорхойлон заасан нөхцөлд үхэлд хүргэж болох зэвсэг хэрэгслийг ашиглаж болно.¹⁹ гэсэн байна.

Ер нь тухайн үйл ажиллагааг зохицуулахад хүч хэрэглэх замаар хууль ёсны эрхийг хэрэгжүүлж байгаа үйл явцыг гол төлөв тусгайлан тогтоосон тусгай журмаар зохицуулдаг байна. Тухайлбал: Пенсильвани мужийн эрүүгийн хуулийн 509-р зүйлд зааснаар тодорхой этгээдийн эсрэг хүч, хэрэглэсэн үйл ажиллагааг дараахь үндэслэлүүдээр зөвтгөдөг буюу хариуцлагаас чөлөөлдөг байна. Үүнд:

1.Насанд хүрээгүй хүн буюу бусад тодорхой этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавьдаг буюу тодруулбал асран хамгаалагч ба харгалзан хүмүүжүүлэгчээр тогтоосон тодорхой этгээд болон төрөл төрөгсөд, эцэг эхийнх нь хийсэн үйл ажиллагаа.

2.Эрх зүйн чадамжгүй этгээдийг хянан харгалзах буюу асран хамгаалах үүргийг зохих хууль ёсны дагуу хүлээсэн тодорхой этгээдийн үйл ажиллагаа.

3.Мөн эмч буюу эмнэлгийн ажилтны хийсэн үйл ажиллагаа.

4.Засан хүмүүжүүлэх байгууллагын бүрэн эрхт ажилтан буюу даргын хийсэн үйл ажиллагаа.

5.Ямарваа нисэх хэрэгсэл буюу агаарын ба усан замын хөлгийн аюулгүй байдлыг хариуцсан тодорхой этгээдийн хийсэн үйл ажиллагаа.

6.Аливаа тээврийн хэрэгсэл ба галт тэргэнд хэв журам сахиулах үүргийг тодорхой хуульд заасны дагуу хариуцдаг буюу тэрхүү ажиллагаатай холбоотой ямарваа асуудлыг зохицуулах бүрэн эрхийг хүлээсэн этгээд тухайн нөхцөлд хүч хэрэглэсэн байсан ч зохих хэр хэмжээний дотор холбогдох хууль тогтоомжид заасан үндэслэлийн дагуу явагдсан бол уг үйлдлийг зөвтгөдөг буюу хариуцлагаас чөлөөлнө²⁰ гэжээ.

¹⁹ Соединенные Штаты Америки: Конгституция и законодательные акты. М, 1993, 660-р тал

²⁰ Соединенные Штаты Америки: Конгституция и законодательные акты. М, 1993, 660-662-р тал.

АНУ-ын холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хууль ёсны эрхээ хэрэгжүүлж буйд тооцогддог өөр нэгэн онцгой хэлбэр байдаг нь тухайн этгээдийг гэмт хэрэг үйлдэхэд өдөөн хатгасан үйлдэл юм.

Энэ тохиолдлыг Нью-Йорк мужийн эрүүгийн хуулинд зааснаар “Занганд оруулах ажиллагаа” гэж томъёолдог бөгөөд энэ хуулийн 40-р зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар тодорхой этгээдийг гэмт хэрэг үйлдэхэд өдөөн түлхсэн буюу өдөөн хатгасан ажиллагааг “занганд оруулсанд” тооцдог бөгөөд энэ үйлдлийг гол төлөв цагдаагийн (мөн өөр бусад албаны) ажилтан тодорхой этгээдээс бодит нотолгоо олж авах зорилгоор үйлддэг тухайн болсон гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд хамаарч байгаа хүний эсрэг чиглэгдсэн шууд өдөөн хатгасан үйл ажиллагаа байдаг байна.²¹

Энэ нь зөвхөн цагдаагийн ажилтнуудад зөвшөөрдөг үйл ажиллагаа төдийгүй тийм бодит шаардлагаар хэнийг ч гэсэн уг ажиллагаанд татан оролцуулахыг холбогдох хуулиар зөвшөөрдөг боловч тэрхүү ажиллагааны бодит үндэслэлийг нарийн шалгаж тогтоох, нэн ялангуяа насанд хүрээгүй хүний эсрэг уг ажиллагааг хэрэглэхийг хатуу хориглосон, түүнийг зөрчвөл шууд хариуцлага хүлээлгэдэг байна. Жишээлбэл: Калифорни мужид нэгэн эрэгтэй хүн 16 настай охидуудад нэг авдар шар айрагийг тэдний өөрсдийнх нь мөнгөөр авч өгснийхөө төлөө торгуулж, албадан ажил хийлгэх ял хүлээсэн байна.

Яагаад гэвэл энэ нь хэдийгээр цагдаагийн даалгавраар хийсэн ч гэсэн тэдгээр охид нь насанд хүрээгүй хүмүүс байсан тул уг ажиллагааг хууль ёсны эрхээ хэрэгжүүлсэн ажиллагаанд тооцоогүй байна. Иймд АНУ-ын Эрүүгийн хууль тогтоомжид хууль ёсны эрхээ хэрэгжүүлсэнд тооцогдох үйл ажиллагааны ерөнхий нийтлэг журмаас гадна тусгайлсан хэм хэмжээг нарийвчлан зааж өгдгөөрөө онцлогтой ажээ.

Дээр дурьдсанаас үзвэл хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа ажиллагааг гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалд тооцдог болох нь олон улсын эрүүгийн эрх зүйд болон ер нь дэлхийн орчин үеийн эрх зүйн системд хүлээн зөвшөөрсөн буюу зөвшөөрч эхэлж байгаа ажиллагаа байдаг болох нь тодорхой.

Иймд гадаад орнуудын эрүүгийн хууль тогтоомжид хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл явдлыг гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалд тооцох талаар зааж өгсөн буюу зохицуулсан хэм хэмжээг үндсэн гурван хэсэгт хувааж үзэж болох талтай байна. Үүнд:

1.Тухайн үйл ажиллагаа нь хэлбэрийн хувьд (мөн чанарын хувьд ч гэсэн) аливаа гэмт хэргийн шинжийг агуулдаг боловч хэрвээ холбогдох хуулиндаа түүнийг гэмт хэрэгт тооцохгүй байх талаар шууд зааж өгсөн ерөнхий хууль тогтоомжууд (Голланд, Испани, Швецарь, Франц, Япон).

2.Хууль ёсны эрх ашигт хохирол учруулсан ч гэсэн гэмт хэрэгт тооцохгүй байх тохиолдлууд болон тэдгээрийн тодорхой хэлбэрүүдийг нэн ялангуяа эрх ёсны үйлдэлд тооцох тодорхой нөхцөл шалгуурыг шууд эрүүгийн хуулиндаа ерөнхийлөн заасан тодорхой хэм хэмжээнүүдийг тусгайлан зааж өгсөн хууль тогтоомжууд, тэдгээрийг нэмэлт 2 хэсэгт хуваадаг байна. Үүнд:

а) Заах хэм хэмжээтэй буюу эрх зүйн тодорхой бусад салбартай холбоотой үйл ажиллагааг зохицуулах бүх нөхцөл үндэслэлийг эрүүгийн хуулиндаа заасан боловч тэрхүү үндсэн үйл ажиллагааг нь өөр салбар зохицуулдаг хуультай.

б) Хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг шууд эрүүгийн хуулиндаа гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалд тооцохоор болгож заасан хууль тогтоомж (Украин, Казакстан, Литва) гэж ангилж болох талтай юм.

Гэвч энэхүү үйл ажиллагаанууд нь нилээд учир дутагдалтай мэт санагдана. Ялангуяа дээр онцлон дурьдсан тодорхой нөхцөл байдлуудыг тогтоохын тулд эрүүгийн

²¹ Малиновсой, А.А. Сравнительное правоведение в сфере уголовного права. / А.А.Малиновский, М, 2002, 145-р тал /

хуулиас өөр, бусад салбарын хууль тогтоомжид хамааруулахад хүрч байгааг зайлшгүй анхаарах шаардлагатай мэт санагдана.

3.Хууль ёсны эрхээ хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг зохицуулдаг ерөнхий журам, нэн ялангуяа тусгай хэм хэмжээнүүдийг шууд заасан хууль тогтоомжууд гэж хувааж үзэж болох юм. Гэхдээ энэхүү тусгай хэм хэмжээнүүдийг дагалдаад тэдгээр нөхцөл байдлын ерөнхий үндэслэл хэр хэмжээг нэмэгдэл, тусгай хуулиар зохицуулдаг байна. Жишээлвэл: (АНУ) Ийнхүү хууль ёсны эрхээ хэрэгжүүлснийг гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал болох талаар олон улсын хэмжээнд хэрхэн авч үздгийг тоймлон дурьдав.

ГЭМ ХОР, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

О.Отгонтуяа



ХСИС-ийн Эрх зүй нийгмийн ухааны сургуулийн, ЭЗОТ-ийн ахлах багш, цагдаагийн ахлах дэслэгч, хууль зүйн магистр

Монгол Улсын Үндсэн хуулийн 16.14-т зааснаар “Монгол улсын хууль олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй”²²... хэмээн хуульчилан тогтоосон билээ.

Энэхүү заалт нь хувь хүн өөрт учирсан эдийн болон эдийн бус гэм хорыг шаардах эрхийн баталгаа болж Үндсэн хуульд тунхагласан билээ. Гэвч өнөөдөр *эдийн бус гэм хор* хэмээх ойлголтын хамрах хүрээ хэт явцуу байгаа, түүнчлэн эдийн бус гэм хорыг шүүх шийдвэрлэхдээ тодорхой үнэлэн тогтоох шалгуур байхгүй байгаа учир өнөөдөр шүүгч өөрийн үзэмжээр шийдвэрлэн, эдийн бус гэм хорыг бүрэн гүйцэд арилгаж чадахгүй, аливаа хэрэг маргааныг зөрүүтэй шийдвэрлэж байгаа бөгөөд энэ тал дээр эрх зүйн зохицуулалт дутмаг байгаа нь учир энэхүү сэдвийг сонгон авч бичихийг оролдлоо.

Эдийн бус гэм хорыг зохицуулсан хууль тогтоомжууд болон онолын ном зохиолуудад эдийн бус гэм хорыг нэршлийн хувьд олон янзаар нэрлэж байна.

О.Жамбалдорж “Иргэний эрх зүй”²³ хэмээх бүтээлд эдийн бус гэм хорыг эд хөрөнгийн бус эрх гэж нэрлэж байгаа бол Д.Наранчимэг²⁴ “Иргэний эрх зүйн зарим асуудал” хэмээх сурах бичигт материаллаг бус гэм хор хэмээн харин Т.Мөнхжаргал, Н.Туяа зэрэг эрдэмтдийн “Иргэний эрх зүй” хэмээх ном зохиолд эдийн бус гэм хор хэмээх нэр томъёог дагнан хэрэглэж байна. Харин иргэний хуулийн 230, 511 зүйлүүдэд эдийн бус гэм хор хэмээх нэршлээр явж байгаа бол, Зохиогчийн эрхийн тухай хуулийн 8 зүйлд “Эд хөрөнгийн бус амины эрх” гэсэн гарчигтай байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 42, 43 зүйл, 391.1, 391.2 зэрэг заалтуудад эдийн бус хохирол гэсэн нэршлээр хуульчилсан хэрнээ 391.3 –д сэтгэл санааны гэм хор хэмээх нэршлээр хэрэглэсэн байна.

Ийнхүү дээрх бүх эрдэмтдийн иргэний эрх зүйн ном сурах бичигт болон хууль тогтоомжуудаас харахад манай улсад эдийн бус гэм хорыг нэршлийн хувьд маш олон

²²Төрийн мэдээлэл, Үндсэн хууль, 1992 он, №1

²³О.Жамбалдорж, Ж.Амарсайхан, Ж.Ариунзаяа, Монгол Улсын Иргэний эрх зүй (I, Пдэвтэр), УБ, 2006

²⁴Д.Наранчимэг, Иргэний эрх зүйн үндсэн асуудал, УБ, 1999

янзаар хэрэглэж байна. Гэвч эдгээр нэр томъёо нь агуулгын хувьд ялгаатай бус нэг агуулгаар илэрхийлэгдэж байна.

Эдийн бус гэм хорын тухай өнөөгийн эрх зүйн зохицуулалтыг авч үзэхээс өмнө монголын эртний хууль цаазын бичгүүдэд эдийн бус гэм хорыг зохицуулж байсан эсэх талаар авч үзье. Манай улсад эдийн бус гэм хорыг иргэний болон эрүүгийн журмаар шийдвэрлэдэг ба эртний хууль цаазын бичгээр илүүтэй эдийн бус гэм хорыг эрүүгийн журмаар торгох байдлаар их шийдвэрлэдэг байсан байна.

Эртний түүх цаазын бичгүүдээс үзвэл: Монгол Ойрадын хууль: *Уг хуульд гүтгэх, доромжлох гэмт хэргийн төрлүүдийг тусгаж эдгээрт ял оноохдоо хохирсон талд нь торгуулийн тодорхой хэсгийг олгохоор зохицуулсан байна.*²⁵

Халх журам хууль: “Гүжгээр худал уг айлтгаваас ноёдыг бол тэмээ тэргүүлэн долоон есөөр торго. Үүний таван есийг санд, хоёр есийг гүжирдүүлэгчид өг. Тайж тавнангууд бол тэмээ тэргүүлэн таван ес, үүний гурван ес бүхэл болоод есийг хагас дөрвийг санд, нэг бүхэл ес болоод есийн хагс тавыг гүжирдүүлэгчид өг.

Ноёдыг харц хүн гүжирдвээс нэг тэмээ тэргүүлэн долоо ест, үүний таван ес нь санд, хоёр есийг ноёнд өг”²⁶ зэргээр нэр төр, алдар хүндийг сэргээж эдийн бус гэм хорыг арилгаж байсан байна.

Дээрхээс үзвэл Монголын эртний хууль цаазын түүхэнд эдийн бус гэм хорыг үнэлж үзэж гэм хорыг таван хошуу мал зэргийг өгөж гэм хорыг барагдуулж хохирогч буюу /одоогоор нэхэмжлэгчийн/ эдийн бус гэм хор амссан этгээдийн эрх ашгийг хамгаалж, харин эдийн бус гэм хор учруулагчийг торгох байдлаар цээрлэл үзүүлж дахин энэ мэт үйлдэл хийхээс урьдчилан сэргийлдэг байжээ. Эндээс дүгнэхэд эдийн бус гэм хорыг барагдуулах түүнийг хуульчилсан ойлголт нь шинээр гарч ирсэн ойлголт биш монголын хууль цаазын түүхэнд зохицуулж байсан байна.

Харин тэгвэл олон улсын эрх зүйн зохицуулалтад:

Хүний эрхийн түгээмэл тунхаглалд: 1948 оны 12 дугаар сарын 10 ны өдөр НҮБ-ын Ерөнхий аsembleйгаас баталсан “Хүний эрхийн түгээмэл тунхаглалд” хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг олон улсын төвшинд хамгаалах эрх зүйн тулгуур суурь болсон юм

Өдгөө олон улс үүнийг сэтгэл санаанд учирсан гэм хорд хамруулан хуульчилж, хамрах хүрээг нь өргөн байдлаар тодорхойлж эрх зүйн хамгаалалт хийсэн байна.

Эдийн бус гэм хорыг арилгуулах, хохирлоо нөхөн төлүүлэх эрхийг манай орны хувьд иргэний хууль, эрүүгийн хууль, ЭБШХ-иар нарийвчлан зохицуулсан байна.

2002 онд батлагдсан *Иргэний хуулийн 21-р зүйлд:* Иргэний нэр ,нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах заалт батлагдан оржээ. Үүнд иргэний нэрийг хууль бусаар ашиглахыг хориглосон байна. “Иргэний нэр төр алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотлож чадахгүй бол эрх нь зөрчигдсөн этгээдийн шаардлагаар уг мэдээг тараасан хэлбэр, хэрэгсэл эсвэл өөр хэлбэр хэрэглэх няцаах үүрэг хүлээнэ” гэж заажээ.

Мөн гэм хор учруулсны хариуцлага хүлээх үндэслэлийг нь зааж өгөхдөө *ИХ-ийн 497 дугаар зүйлийн 497.1-т* “бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр алдар хүнд ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл эс үйлдэхгүйгээр гэм хор учруулсан этгээдэд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй” гэж хуульчилсан байна. Мөн *хуулийн 511 дүгээр зүйлийн 511.1-т* “бусдын нэр төр алдар хүнд ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй бол эд хөрөнгийн хохирол арилгасныг үл харгалзан эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ.” гэж тус тус заасан байна. Түүнчлэн нас барсан этгээдийн нэр төр, алдар хүндийг

²⁵Т.Алтангэрэл. Монгол Ойрадын их цааз, түүний судалгаа, УБ, 1988

²⁶С.Жалан- Аажав. Халх Журам, 31-33 дах тал, 1995 он

гутаасан эсвэл түүний хувийн нууцтай холбоотой мэдээг өвлөгчийн зөвшөөрөлгүйгээр олон нийтэд тараасан бол хариуцлага хүлээлгэх заалтууд оржээ.

Харин Эрүүгийн хуулийн 110, 111 зүйлүүдээр хүний нэр төрийг гүтгэсэн доромжилсон тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлийг суулгаж өгсөн байна.

Харин ЭБШХ-иар гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус гэм хорыг иргэний журмаар хэрхэн нэхэмжлэх заалтуудыг суулгаж өгсөн байна.

ЭБШХ-ийн 43 зүйлд: “Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн, түүнийгээ нөхөн төлүүлэх буюу сэргээлгэхээр шаардлага тавьж байгаа иргэн, хуулийн этгээдийг иргэний нэхэмжлэгч гэнэ”.

ЭБШХ-ийн 391.1 зүйлд: “Эдийн бус хохирлыг иргэний хуульд заасан журмын дагуу нөхөн төлнө”.

ЭБШХ 391.2 зүйлд: “Эд хөрөнгийн бус хохирлын хэмжээг хэргийн нөхцөл байдлыг харгалзан иргэнээр журмаар тодорхойлно”.

ЭБШХ 391.3 зүйлд: “Сэтгэл санаанд учирсан хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг ИХШХШ тухай хуульд заасан журмаар барагдууна. зэрэг заалтуудаар эдийн бус гэм хорыг зохицуулж байна”.

Зөвхөн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан тохиолдолд л эдийн бус гэм хор учирна гэж иргэний хуулийн зүйл заалтын өмнөх хэсгүүдэд дурдсан болно.

Тэгвэл бусад орнуудын иргэний хуульд эдийн бус гэм хорын хамрах хүрээг хэрхэн авч үзсэн байдгийг сонирхоё.

ОХУ-ын хууль тогтоомжид эд хөрөнгийн бус хохирлыг дотор нь

1. Бие махь бодийн хохирлоос үүссэн эдийн бус гэм хор

2. Ёс суртахууны хохирлоос үүссэн эдийн бус гэм хор

Ёс суртахууны хохирлыг биеийн юмуу, сэтгэл санааны зовлон гэж үздэг өөрөөр хэлбэл сэтгэл санааны хариу илрэл юм. Ёс суртахууны хохиролд хүний нэр төр алдар хүнд, ажил хэргийг гутаасан болон сэтгэл зүйн хохирлыг хамааруулан ойлгодог байна.²⁷

Англо-Саксоны эрх зүй бүхий орнуудын хувьд нилээд олон төрөлд үзсэн байдаг. Үүнд:

1. Хүний амь нас, эрүүл мэндэд халдаснаас үүссэн эдийн бус гэм хор

2. Хүний нэр төр алдар хүнд ажил хэргийн нэр хүндэд халдснаас үүссэн эдийн бус гэм хор

3. Хүний эрх, эрх чөлөө халдашгүй байдалд халдаснаас үүссэн эдийн бус гэм хор

4. Зохиогчын эрх зөрчигдснөөс үүссэн эдийн бус гэм хор

5. Хэрэглэгчдийн эрх ашгийг зөрчсөн, бусад эд хөрөнгийн эрх зөрчигдснөөс үүдсэн эдийн бус гэм хор

6. Иргэдийн хөдөлмөрлөх эрх зөрчигдснөөс үүдсэн эдийн бус гэм хор гэх мэтээр ангилан авч үзэж байна.

Германы Улсын Иргэний хуулийн 847²⁸ зүйлд “Бие эрүүл мэндэд гэм хор учирсан, түүнчлэн эрх чөлөөг нь зөрчсөн тохиолдолд хохирсон этгээд учирсан эд хөрөнгийн бус шинжтэй гэм хорыг зохих хэмжээний мөнгөөр нөхөн арилгуулахаар шаардах эрхтэй хэмээн ерөнхий байдлаар зааж өгсөн байна.

Америкийн эрх зүй :

1. Санаатай буюу илт бүдүүлэг болгоомжгүйгээс сэтгэл санааны гэм хор учруулах

²⁷Т.И.Илларионовой, Б.М.Гонгало,В.А.Плетнева “Гражданское право” учебник для вузов Часть первая. ,2003. М стр- 264

²⁸Civil code of Germany.

2. Энгийн болгоомжгүйгээс эдийн бус гэм хор учруулах гэж ангилдаг.

Ийнхүү эдийн бус гэм хорыг хуулиараа нэгэн адил зохицуулсан орны эдийн бус гэм хорын зохицуулалтыг өөрийн орныхтой харьцуулан үзэхэд манай орны хувьд эдийн бус гэм хорын хамрах хүрээ хэт явцуу байгаа нь харагдаж байна.

Ийнхүү эдийн бус гэм хорын хамрах хүрээг нарийвчлан зааж өгөөгүйгээс учирсан эдийн бус гэм хорыг мөнгөөр шаардах эрх нь үгүйсгэгдэж байна. Учир нь Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.1-т “эдийн бус гэм хорыг гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө” хэмээн заасан байдаг.

Манай улсын хувьд иргэний хуульд эдийн бус гэм хорыг бүрэлдэн бий болох хүчин зүйлээс нь хамааруулж:

1. Бодит хохирлоос үүссэн эдийн гэм хор

2. Хүний нэр төр алдар хүнд ажил хэргийн нэр хүндэд халдснаас үүссэн эдийн бус гэм хор

3. Гэмт хэргийн улмаас үүссэн эдийн бус гэм хор гэж ангилан авч үзэх нь зүйн хэрэг гэж үзэж байна.

Бодит хохирлоос үүссэн эдийн бус гэм хор гэдэгт Иргэний эрх зүй дэх өмчийн болон, үүргийн харилцааны улмаас үүссэн эдийн бус гэм хорыг ойлгож болно.

Эдийн бус гэм хор нь субъектын хувьд дамжмал байдлаар буюу гуравдагч этгээдэд үүсэх боломжтой байна.

Гэтэл манай Иргэний хуульд эдийн бус гэм хор учирсан тохиолдолд шүүхэд зөвхөн өөрийн сэтгэл санаанд учирсан хохирлыг л нэхэмжлэх эрхтэй байдаг.

Энэ нь дамжмал буюу гуравдагч этгээдэд учирсан эдийн бус гэм хорыг орхигдуулж болох талтай байдаг.

Үүнээс үндэслэн эдийн бус гэм хорыг шаардах субъектээр нь:

➤ Эдийн бус гэм хор биечлэн учирсан этгээд

➤ Эдийн бус гэм хор учирсан гуравдагч этгээд гэж ангилж болно.

Манай Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 511.2-т зүйлд “Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй бол эд хөрөнгийн хохирол арилгасныг үл харгалзан эд хөрөнгийн бус гэм хорыг мөнгөн буюу бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ” хэмээн Иргэний хуульд зааж өгсөн байна.

Дээрхээс харахад манай иргэний хуульд хариуцагч тал нь гэм буруугүйгээ нотолж чадахгүй бол нэхэмжлэгчид эдийн бус хохирлыг мөнгөн хэлбэрээр барагдуулах үүрэгтэй болох нь харагдаж байна.

Эдийн бус хохирлыг мөнгөөр нарийвчлан тооцох боломжгүйгээс гадна хохирлын хэмжээг хуульд эмийн жор шиг тодорхой зааж өгөх аргагүй байна.

Учир нь тухайн этгээдийн эрхэд халдсаны улмаас хүн хүнд эдийн бус гэм хор хэргийн нөхцөл байдалтай уялдан янз бүр үүсдэгтэй холбоотой юм. Энэ асуудал нь монгол төдийгүй дэлхий нийтийн өмнө тулгамдсан асуудал болоод байна.

Гэвч нэгэнт бусдад хохирол учруулсан бол түүнийг нөхөн төлөх тухай иргэний эрх зүйн зарчмыг удирдлага болгон эдийн бус хохирлыг арилгах нь зүйн хэрэг юм. Хохирлын хэмжээг нь шүүх тогтоож хохирол учруулагчаас гаргуулах ёстой.

Иргэний хуульд эдийн бус гэм хорыг шүүхээс үнэлэх заалт байхгүй ба шинэ хуулиар энэ төрлийн хохирлын хэмжээг шүүх тогтоох буюу өөрийн дотоод итгэл үнэмшлээр шийдэх болсноор шүүгч бүр өөрийн үнэлэмжээр янз бүрийн шийдвэр гаргаж байна.

Гэхдээ шүүхээс эдийн бус гэм хорыг барагдуулахдаа харгалзан үзэх хэдэн үндэслэлийг Иргэний хуульд зааж өгсөн байна²⁹.

²⁹Иргэний хуулийн 511.2 зүйл. “Эдийн бус гэм хорыг арилгах хэмжээг мэдээ тараасан арга хэрэгсэл, тархсан хірээ, хохирогчийн сэтгэл санаанд учирсан їр дагавар зэргийг харгалзан нэхэмжлэгчийн

Шүүхээс гэм хорыг барагдуулахдаа:

- Гэм хор тархсан хүрээ
- Тараасан арга хэрэгсэл
- Хохирогчийн сэтгэл санааны байдлыг үнэлж үздэг.

Дээрхи хүснэгтээр харуулсан зүйлсийг харгалзан үзэж шүүхээс гэм хорыг барагдуулж байгаа практик байна.

Хүний нэр төр, алдар хүндийг гутаасан тохиолдолд шүүхээс нэхэмжлэлийг хангахдаа тараасан арга хэрэгсэл, тархсан хүрээг тогтоож түүгээр эдийн бус гэм хорыг үнэлэх нь учир дутагдалтай байна³⁰.

Хүний нэр төрийг гутаасан мэдээг сонин сэтгүүлээр тараасан тохиодолд нэхэмжлэгчийн хохирлыг барагдуулахдаа сонин сэтгүүлээр тархсан хэмжээг тухайн хувилагдаж буй сонин сэтгүүлийн нэг бүрийн үнийн дүнгээр үржүүлээд гэм хорыг барагдуулж байгаа тохиолдол шүүхийн практикт нэг бус гарч байна.

Ийнхүү эдийн бус гэм хорыг тараасан арга хэрэгсэл, тархсан байдлыг нь шууд харгалзан гэм хорыг барагдуулах нь оновчтой бус эдийн бус гэм хорыг бодитой үнэлэх зохицуулалт биш гэж үзэж байна.

Мөн эдийн бус гэм хорыг арилгах тогтсон шалгуур байхгүй хохирлын хэмжээг шүүгч тогтоох болсноор шүүгч бүр өөрийн үнэлэмжээр шийдвэр гаргаж байна³¹.

ОХУ-д нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлж буй аргачлалыг авч үзвэл: ОХУ-ын Иргэний хуулийн 151, 1099 дэх заалтын дагуу нөхөн төлөлтийн хэмжээг шүүхээс дан ганц тогтоодог. Хуулиар “хохиролын нэгж”- ийн мөнгөн эквивалентийг тогтоохгүйгээр энэ асуудлын шийдвэрийг шүүхийн мэдэлд үлдээдэг.

Шүүхийн заавал харгалзан мөрдөх чанарын хэд хэдэн хэмжүүрийг хуулинд зааж өгсөн байдаг.³²

- Биеийн болон сэтгэл санааны зоволтын шинж ба хэр хэмжээ
- Хохирол учруулагчийн гэм буруугийн хэр хэмжээ
- Ёс суртахууны хохирол Учирсан нөхцөл байдал
- Бусад анхаарал татах нөхцөлүүд орно.

Эдгээрээс дараах санал, зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

1. Манай оронд эдийн бус гэм хор нь материаллаг бус эрх ашгийг зөрчсөний хүрээнд үүсдэг хэмээх ойлголт байна. Тэгвэл **Эдийн бус гэм хор** гэдэг ойлголт нь зөвхөн материаллаг бус эрх ашгийг зөрчсөн хүрээнд ч бус материаллаг гэм хорын хүрээнд ч үүсэж болдог болох нь харагдаж байна.

Үүнтэй холбоотойгоор эдийн бус гэм хор нь зөвхөн иргэний хуулийн 8.1.5-д заасны дагуу гэм хорын үндсэн дээр биш бусад иргэний эрх зүйн харилцаа үүсэх үндэслэлтэй хамт үүсэж болно. Жишээ нь: Иргэний хуулийн 8.1.1 хэлцлийн үндсэн дээр, 8.1.4 оюуны бүтээл туурвих зэрэг харилцаа дээр үүсэх боломжтой байна.

2. Эдийн бус гэм хорын хувьд нэр томъёоны хувьд хууль тогтоомжуудад харилцан адилгүй өөр өөрөөр нэрлэж хэрэглэж байна. Энэхүү нэр томъёоны асуудлыг нэг мөр ойлгохын тулд аль нэг нэршлийг нь дагнан хэрэглэх шаардлагатай байна.

3. Эдийн бус гэм хор нь гуравдаг этгээдэд үүсэх боломжтой байна. Тиймээс гуравдагч этгээд өөрт учирсан хохирлоо нэхэмжлэх эрх зүйн үндсийг нь хуульчилж өгөх хэрэгтэй.

4. Мөн манай шүүхийн практикт эдийн бус гэм хорыг барагдуулахад баримтлах тогтсон жишиг шалгуур байхгүй тул шүүгч хэрэг маргааныг өөрийн үзэмжээр

шаардлагын хүрээнд мөнгөөр тооцож тогтоох бөгөөд мэдээ тараасан уг хэлбэр болон бусад аргаар няцаалт хийхийг гэм хор учруулсан этгээдэд үүрэг болгоно.

³⁰Хавсралт 1

³¹Хавсралт 2

³²А.М. Эрделевский Моральный вред и компенсация за страдания .М.1997.г

шийдвэрлэх хандлага их байна. Энэ нь эдийн бус гэм хорыг бодитойгоор үнэлэхэд сөрөг нөлөөүзүүлэх талтай юм.

5. Хохирогчийн сэтгэл санааны байдлыг тогтоохдоо эмнэлгийн байгууллагаар сэтгэл санаанд хор уршиг учирсан сэтгэцэт өөрчлөлт орсон эсэхэд дүн шинжилгээ хийлгэж түүнийг харгалзан үздэг байх нт зүйтэй болов уу.

6. Эдийн бус гэм хорыг арилгахад мэдээ тараасан арга хэрэгсэл, тархсан хүрээг тогтоох төдийлөн ач холбогдолтой бус гэж үзэж байна. Учир нь энэ нь эдийн бус гэм хорыг бодитой үнэлэх шалгуур болж өгч чадахгүй байна.

7. Эдийн бус гэм хорын нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлохдоо хэрэг бүрийн тухайд шүүгч тухайн хүний зөрчигдсөн баялгийн ерөнхий үнэлгээ, хууль зөрчигчийн гэм буруугийн хэмжээ, эрх зүйн зөрчлийн үр дагаврын хэмжээ, худал мэдээлэл тарагдсан хүрээ, бие эрхтний гэмтлийн хэмжээ, нас барсан хүн болон нэхэмжлэгчийн төрлийн холбоо, талуудын материаллаг байдал зэргийг харгалзан үзэх нь зүйтэй юм.

Хавсралт №1

Сүхбаатар дүүргийн шүүхийн 2011 оны 452 тоот шийдвэр:

Иргэн О Сүхбаатар дүүргийн шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ миний биеийг “М” сонины 2010 оны... т, улсын заан О Өмнөговьд алтны дээрэм хийжээ гарчигтай нийтлэлд миний зургийг тавьж, улсын заан О чиргүүл чирсэн 4 камаз маркын хүнд даацын машинтай очиж, алтны судал дээрэмдэж 8 тэвш дүүртэл ачиж аваад хот руу явсан. Гэх мэтээр бичсэн. Энэ нийтлэл нь Үндсэн хууль, Эрүүгийн хууль, Иргэний хуулийг зөрчиж бодит байдалтай нийцэхгүй гүтгэн доромжилсон худал мэдээлэл болжээ. Тус сонин 8 хоногт нэг удаа гардаг бөгөөд нэг удаагийн хэвлэлээр 23 мянган хувь борлуулдаг. Мөн гадаадад байгаа монголчууд интернетээр олж уншдаг. Иймд нэр төр сэргээлгэж, өөрч учирсан сэтгэл санааны болон бизнесийн хохирлоо 5 сая төгрөгөөр үнэлж нэхэмжилж байна гэжээ.

Сүхбаатар дүүргийн шүүхээс нэр төр гутаагдсаныг сэргээлгэж, мэдээ тараасан арга хэлбэрээр няцаалт хийлгүүлэхийг шаардсан нэхэмжлэл үндэслэлтэй байна. Харин эдийн бус гэм хорыг арилгуулахдаа, хавтаст хэргийн 17-19 дүгээр хуудсанд авагдсан “М” сонины тухайн дугаарын хэвлэлтийн болон захиалагчийн тоо, хэвлэлтэнд зарцуулсан зардал, тархсан хүрээ зэрэг байдлуудыг харгалзан үзэж нэхэмжлэлийн шаардлагын үнийн дүнгийн 10 хувьтай тэнцэх хэмжээгээр тооцож, хариуцагчаас гаргуулах нь зүйтэй гэж үзээд Иргэний хуулийн 21.2, 511 зүйлийн 2 т заасныг баримтлан М сонины 2004 оны ... дахь дугаарын 1 ба 5 нүүрэнд нийтлэгдсэн заан О Өмнөговьд алтны дээрэм хийжээ” гарчигтай мэдээнд нэхэмжлэгч О –ийн нэр төр гутаагдсаныг сэргээж, өөрийн сониноор дамжуулж дээрх мэдээнд няцаалт хийхийг “М” Сонины эрхлэгч Э-д даалгаж мөн хуулийн 497.1, 511.1 зааснаар 500 мянган төгрөг гаргуулж О-д олгож нэхэмжлэлийн шаардлагын үлдсэн хэсэг болох 4 сая 500 мянган төгрөгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

Хавсралт №2

Улсын дээд шүүхийн 2008 оны 54 тоот тогтоол:

“С” ХХК-ийн өмгөөлөгч Батсүх Сүхбаатар дүүргийн шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ нэхэмжлэгч байгууллагын эрх ашгийг хамгаалж шүүх хуралдаанд оролцож байна. Шүүхэд гаргаж буй нэхэмжлэлийн шаардлагыг дэмжинэ. “Ө” Сонины 2007 оны 7 сарын..... – рт бичигдсэн “ тэд баяр наадмаар нэгийгээ юу ч болоогүй юм шиг төхөөрч суужээ.гарчигтай нийтлэл нь “С” компанийн ажил хэргийн нэр хүндийг нь гутаасан бөгөөд бизнесийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлсэн байна. “С” ХХК нь мах махан бүтээгдэхүүн, хагас бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг юм.

Уг нийтлэл гарснаас хойш байгууллагын ажиллагсадтай болон үйлчлүүлэгчдийн хооронд эвгүй байдал бий болсон. Тухайлбал тус компанийн байранд ажлын өрөө түрээслэхээр гэрээ байгуулсан газар нь энэ мэдээллээс болж гэрээгээ цуцлахыг хүртэл

шаардаж байсан. “Ө” сонины удирдлагад залруулга хийж өгөх талаар удаа дараа хүсэлт тавьсан боловч хүлээж аваагүй тул манай байгууллага шүүхэд нэхэмжлэл гаргаж байна.

Гэтэл шүүхэд хэрэг шалгагдах явцад хариуцагч нэхэмжлэгчийн өргөдлийг хүлээн авсан боловч хуулинд заасан хугацааны дотор хариу тайлбартаа гарагж өгөөгүй, хуралдаанд ирээгүй байх тул ИХШХШТХ-ийн 72 дугаар зүйлийн 72.3 – т заасны дагуу нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөнд тооцож хариуцагчийг эзгүйд хэргийг хянан шийдвэрлэж өгөхийг хүсье гэжээ.

Сүхбаатар дүүргийн шүүх нэхэмжлэлийг хянан үзээд Иргэний хуулийн 27 дугаар зүйлийн 27.6 21 дүгээр зүйлийн 21.2, “С” ХХК-ийн ажил хэргийн нэр хүндийг сэргээж, хариуцагч нь өөрийн “Ө” сонины 2003 оны дугаарын “тэд баяр наадмаар нэгийгээ юуч болоогүй юм шиг төхөөрч суужээ” гэх гарчиг бүхий нийтлэлийн нэхэмжлэгчтэй холбоотой хэсэгт өөрийн сонингоор дамжуулан няцаалт хийхийг “Ө” сонины газраас 5 сая төгрөг гаргуулж ”С” ХХК-д олгон шийдвэрлэжээ.

Давж заалдах шатны шүүхээс 1 сая төгрөг гаргуулж “С” ХХК-д олгохоор шийдвэрлэжээ.

УДШ хянан үзээд Иргэний Хуулийн 27 дугаар зүйлийн 27.6, 21 дүгээр зүйлийн 21.2, “С” ХХК-ийн ажил хэргийн хүндийг сэргээж, хариуцагч нь “Н” сонины гарчиг бүхий нийтлэлийн нэхэмжлэгчтэй холбоотой хэсэгт өөрийн сонингоор дамжуулан няцаалт хийхийг “Ө” сонины газарт үүрэг болгож Иргэний хуулийн 497 зүйлийн 497.1, 511 дүгээр зүйлийн 511.1 –д заасныг баримтлан “Ө” сонины газраас 5 сая төгрөг гаргуулж “С” ХХК –д олгон шийдвэрлэжээ.

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ЖАГСААЛ ЦУГЛААН, НИЙТИЙН ЭМХ ЗАМБАРААГҮЙ БАЙДАЛ БИЙ БОЛСОН ҮЕД ОЛОН ХҮНД НӨЛӨӨЛӨХ ТУСГАЙ ХЭРЭГСЛИЙГ ХЭРЭГЛЭХ ҮНДЭСЛЭЛ ЖУРАМ, АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ



Ш.Чулуун

ХСИС-ийн ЦС-ийн ЦЭЗТ-ийн ахлах багш, цагдаагийн хошууч, докторант

Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүрэг бүхий хууль

сахиулах байгууллага юм.³³

Цагдаагийн алба хаагч болон үүргээ биелүүлэх явцад өөрийн болон бусад хүмүүсийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд эрсдэл учруулах аюултай тулгарч байдаг. Ийм үед цагдаагийн алба хаагч нь хуулинд заасан үндэслэл нэгэнт бий болсон нөхцөлд албаны тусгай хэрэгсэл хэрэглэх зайлшгүй шаардлага гардаг байна.

Цагдаагийн байгууллага, алба хаагч нь үйл ажилагаандаа албаны тусгай хэрэгсэл хэрэглэхдээхүний эрхийн талаар тусгасан Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон дотоодын хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлнэ.

Тухайлбал: Хүний эрхийн түгээмэл тунхаглал³⁴, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт³⁵, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг

³³ Цагдаагийн албаны тухай хуулийн 3-р зүйлийн 3.1 дэх хэсэг

³⁴ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 217/A/III/ тогтоолоор 1946.12.10-ны өдөр батлагдсан.

бусаар буюу нэр төрийг доромжилон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенц³⁶, Монгол Улсын “Үндсэн хууль”³⁷ зэрэг баримт бичгүүдэд тунхагласан хүний эрхийн талаар тодорхой мэдлэгтэй байх зайлшгүй шаардлагатай юм.

Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болсон үед түүнийг албадан тараах болон хууль бусаар зохион байгуулж байгаа жагсаал цуглааныг эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр албадан тараах үедээ олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх эрхтэй байна.

Хоёр ба түүнээс дээш хүнд нэгэн зэрэг хэрэглэх боломжтой хэрэгслийг олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл гэх ба үүнд дараах хэрэгсэл хамаарна гэжээ.³⁸ Үүнд:

1/ Олон хүнд нэг зэрэг нөлөөлөх нулимс асгаруулагч

Хоёр ба түүнээс дээш хүнд нэгэн зэрэг нөлөөлөх хамрын самсаа болон нулимсны булчирхайг цочроож нулимс ихээр гоожуулах хий, шингэн төлөв байдалтай бодис /Гар бөмбөг, сум, утаа, шүршүүр хэлбэртэй байж болно/

2/ Олон хүнд нэг зэрэг нөлөөлөх амьсгал боогдуулагч

Хоёр ба түүнээс дээш хүнд нэгэн зэрэг нөлөөлөх амьсгалын замын эрхтнээр дамжин уушгинд хүрч ханиалгах, амьсгал, хоолой боох үйлчлэл үзүүлэх зориулалт бүхий шингэн болон хийн төлөв байдалтай бодис

3/ Усан хөөрөг

Усыг өндөр даралтаар хүчтэй цацах төхөөрөмж

Усан хөөрөгт тээврийн хэрэгслийг олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны даргын тушаалаар томилогдсон дараах 5 хүний бүрэлдэхүүнтэй баг ажиллуулна.³⁹

- Багийн ахлагч: Шуурхай удирдлагын штабын даргын шийдвэр, тусгай хэрэгсэл хэрэглэх бүлгийн даргын удирдлагад ажиллаж, багийн үйл ажиллагааг удирдана.
- Усан хөөрөгч: усан хөөргийн төхөөрөмжийн бэлэн байдал, ашиглалтыг хариуцна.
- Оператор: дуу, дүрс бичлэгийн төхөөрөмжийн бэлэн байдал, ашиглалтыг хариуцна.
- Техникч: нулимс асгаруулагч, будагч бодис, усаар цэнэглэх, усны хоолойг холбох, салгах болон нөөц жолоочийн үүрэг гүйцэтгэнэ.
- Механик-жолооч: машины техникийн аюулгүй ажиллагааг ханган ажиллана гэж тус тус заасан байна.

4/ Утаан хөшиг үүсгэгч

Үзэгдэх орчныг хязгаарлах зорилгоор утаан хөшиг үүсгэх бодис /Гар бөмбөг, сум, утаа, шүршүүр хэлбэртэй байж болно.

Цагдаагийн байгууллага, алба хаагч нь нийтийн хамарсан эмх замбараагүй байдал бий болсон үед гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилтыг хангах ажлын хүрээнд шаардлагатай тохиолдолд олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх эрхтэй байна.

Олныг хамарсан үймээн самуун, эвдэн бусниулах, галдан шатаах, эд хөрөнгө устгах, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис хэрэглэх буюу төрийн төлөөлөгчийг

³⁵Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1966.12.16-ны 2200А(XXI)тоот тогтоолоор баталж, 1976.03.23-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

³⁶Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 57-р чуулганы 2002.12.18-ны өдрийн А/RES/57/199 дүгээр тогтоолоор баталж 2006.06.22-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

³⁷1992.01.13-ны өдөр баталсан 6 бүлэг 70 зүйлтэй хууль юм.

³⁸Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 19-р зүйлийн 19.4 дэх хэсэг

³⁹Хууль зүйн сайдын 2014.07.10-ны өдрийн А/126 тоот тушаалын 2-р хавсралт “Тусгай хэрэгсэл биеийн хүч хэрэглэх заавар”-ын 2.5 дахь хэсгийн 2.5.1 дэх заалт

зэвсэглэн эсэргүүцэх үйл ажиллагаа нөхцөл байдлыг нийтийг хамарсан эмх замбараагүй байдал гэнэ⁴⁰ гэжээ.

Цагдаагийн албан хаагч албан үүргээ биелүүлэх үед нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэх, эвдэн бусниулах, галдан шатаах, эд хөрөнгө устгах, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис хэрэглэх буюу төрийн төлөөлөгчийг зэвсэглэн эсэргүүцэх зэргээр бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх, ийм үйлдлийг таслан зогсоох үүднээс хүч хэрэглэхээс бусад хэлбэрээр эсэргүйцлийг зогсоох боломжгүй тохиолдолд хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг зохих журмын дагуу тухайн нөхцөл байдалд ялгамжтай хэрэглэдэг байна.

Нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үед олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг хэрэглэхийн өмнө нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагын үнэлгээ хийж бодит үндэслэл байгаа эсэхийг нарийн тодорхойлно.

Мөн түүнчлэн хүрээлэн байгаа орчин, эрсдэл, хэрэглэсний дараа гарч болох үр дагаварыг тооцоолон төлөвлөгөө гарган ажиллана.

Жагсаал цуглааныг албадан тараах, нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, нийтийг хамарсан арга хэмжээний хамгаалалтын үед цагдаагийн төв байгууллагын даргын шийдвэрээр байгуулсан шуурхай удирдлагын штаб (цаашид “Удирдлагын штаб” гэнэ)-ын даргын зөвшөөрөлгүй галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэхийг хориглоно.

Олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үед цагдаагийн байгууллага, алба хаагч нь ажиллахдаа дараах үйл ажиллагаандаа дараах зарчмыг удирдлага болгон баримтлан ажилласан байх шаардлагатай. Үүнд:

Түгээмэл зарчмууд

➤ **Тайван замаар буюу хүч хэрэглэхгүйгээр асуудлыг шийдвэрлэх зарчим**

Цагдаагийн байгууллага, алба хаагч нь жагсаал, цуглааны үед ажиллахдаа жагсагчдын эсрэг аль болох хүч хэрэглэхгүй байх, асуудлыг эв зүйгээр зохицуулах зорилготой байгаагаа үйл ажиллагаагаараа илэрхийлж байх хэрэгтэй.

Цагдаагийн байгууллага, алба хаагч нь бололцоотой бүх тохиолдолд галт зэвсэг, олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх тухайгаа урьдчилан сануулах ба тухайн нөхцөл байдалд хамгийн бага хохирол учруулахыг эрмэлзэнэ⁴¹.

Энэ нь жагсаал, цуглааныг зохион байгуулагч, эсхүл тэдний төлөөлөгчтэй гэрээ хэлэлцээр хийх, сануулга бичиг тараах, чанга яригчаар анхааруулах гэх мэт хэлбэртэй байна.

➤ **Хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн хүч хэрэглэх зарчим**

Хуулиар зөвшөөрөгдсөн хүч, хэрэгсэл гэдэг нь гагцхүү хуулиар баталж хүлээн зөвшөөрсөн тусгай хэрэгслийг үндэслэл бүхий нөхцөлд хэрэглэнэ. Өөрөөр хэлбэл алба хаагч нь дотоодын хууль тогтоомж, тушаал, заавруудыг сайтар судалсан байх ба хуулиар зөвшөөрөгдөөгүй тусгай хэрэгсэл ашиглаж болохгүй юм⁴².

Жишээ нь: Хуулинд тодорхой заасан нулимс асгаруулагчаас өөр төрлийн химийн бодис бусад олон хүнд нөлөөлөх бодис хэрэглэхийг хориглоно.

➤ **Бусад арга, хэлбэрээр эсэргүйцлийг таслан зогсоох боломжгүй тохиолдолд хүч хэрэглэх зарчим**

Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал нь энгийн арга хэрэгслээр зогсоох боломжгүй болсон буюу тайван замаар тараах боломжгүй, үр дүнгүй болох нь тодорхой болсон үед тухайн нөхцөл байдал, эсэргүйцэлд тохирсон тусгай хэрэгсэл

⁴⁰Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 2010 оны 04 дүгээр сарын 02 –ны өдрийн 173 тоот тушаалын 2-р хавсралтын 414.2 дэх заалт

⁴¹Хууль зүйн сайдын 2014.07.10-ны өдрийн А/126 тоот тушаалын 2-р хавсралт “Тусгай хэрэгсэл биеийн хүч хэрэглэх заавар”-ын 2.2 дахь хэсгийн 2.2.3 дахь заалт

⁴²НҮБ-ын Хүч болон галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмууд 1990 он 2 дугаар зүйл

хэрэглэнэ. Түүнчлэн цагдаагийн байгууллага нь хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд ноцтой хохирол учрахаар байвал тусгай хэрэгслийг хэрэглэж болно.

➤ **Тусгай хэрэгслийг ялгамжтай хэрэглэх**

Тусгай хэрэгсэл хэрэглэх шийдвэр гаргаж байгаа эрх бүхий албан тушаалтан нь шийдвэр гаргахдаа жагсаал, цуглаанд оролцогчдын зорилго, нас, хүйс, ямар хүмүүс байгаа зэргээс хамаарч тусгай хэрэгслийг ялгамжтай байдлаар хэрэглэнэ. Энэ нь мөн тухай этгээдийн гаргаж байгаа үйлдэлд тохирсон түүнд чиглэсэн байхыг хэлнэ.

Цагдаагийн алба хаагч болон бусад хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй байдлаар болон галт зэвсэг хэрэглэж довтолсон, эсэргүүцсэн, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болсон, бүлэглэн довтолсон хүмүүсийг дотор нь ялгах боломжгүйгээс бусад тохиолдолд өндөр настай, илэрхий насанд хүрээгүй, жирэмсэн, тахир дутуу болох нь мэдэгдэж байгаа хүмүүст тусгай хэрэгсэл хэрэглэхийг хориглох ба шаардлагатай үед мэх хэрэглэж болно⁴³.

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэхээс өмнө дараах арга хэмжээг авна.

○ **Анхааруулга өгөх**

Нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, нийгмийн хэв журмыг бүлэглэн зөрчиж байгааг таслан зогсоох, жагсаал, цуглааныг албадан тараах шийдвэрийг биелүүлэх, байгууллага, иргэдийн мэдэлд байгаа барилга байгууламж, орон байрыг эзлэн авсан, гудамж, замын хөдөлгөөнийг бүслэн хаасныг чөлөөлөх тохиолдолд олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэхийн өмнө урьдчилан анхааруулна.

Урьдчилан анхааруулахдаа тодорхой хугацаа зааж, чанга яригчаар зарлах зэрэг боломжтой бүх аргыг хэрэглэнэ.

Урьдчилан анхааруулснаас хойш заасан хугацаанд үйлдлээ зогсоогоогүй бол тусгай хэрэгсэл хэрэглэнэ.

○ **Эсэргүйцлээ зогсоох хугацаа өгөх**

Цагдаагийн байгууллага, алба хаагч нь анхааруулга өгсөний дараа тэдэнд сайн дураараа тарж явах бололцоо олгоно. Энэ нь уг жагсаалыг сонирхогч иргэд, хөндлөнгийн хүмүүс тусгай хэрэгслийн нөлөөнд өртөхөөс сэргийлнэ.

Цагдаагийн байгууллага, алба хаагч нь олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэхдээ анхааруулга өгөхөөс гадна тэдгээр жагсаалд оролцогчид, сонирхогчдыг чөлөөтэй тарж явах бололцоог олгож гарах, явах гарцыг нээсэн байна.

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх үед дараах нөхцөл байдлыг хангаж хэрэгжүүлэн ажиллана.Үүнд:

○ **Хамгийн бага хохирол учруулахыг эрмэлзэх**

Тусгай хэрэгсэл хэрэглэж байгаа зорилго нь тухайн эсэргүйцлийг няцаах, хяналтандаа авах, таслан зогсооход чиглэгдсэн байдаг тул аль болох бага хор уршиг учруулах. Эсэргүүцэл зогссон үед дахин хэрэглэхгүй байх

○ **Хүний амь нас, нэр хүндэд хүндэтгэлтэй хандаж илүү их хохирол учруулахгүй байх⁴⁴**

Хэдийгээр тухайн эсэргүүцэгч этгээд чулуу, мод, шил, төмөр шидсэн бусдын амь нас эрүүл мэнд, эд хөрөнгөнд халдсан ч гэсэн түүнийг барьсан тохиолдолд иргэдийн урд гаргасан үйлдэлд өширхөх маягаар зодох, дэглэх үйлдэл хийж болохгүй.

Түүнчлэн эмх замбараагүй байдалд оролцоогүй энгийн буюу хөндлөнгийн хүмүүсийн аюулгүй байдлыг хангаж ажиллах хэрэгтэй. Шүүхээр гэм буруутай нь тогтоогдоогүй үед хэнийг ч гэм буруутайд тооцож болохгүй гэсэн зарчмыг баримтлах.

⁴³Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 2010 оны 04 дүгээр сарын 02 –ны өдрийн 173 тоот тушаалын 1-р хавсралтын 233.7.1 дэх заалт

⁴⁴НҮБ-ын Хүч болон галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмууд 1990 он 5 /б/ дугаар зүйл

- **Онцгой байдал болон бусад шаардлагатай байгууллагуудтай ажиллах арга хэмжээ авах**

Энэ нь нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үед гарч болох эрсдлүүдийг тооцож Засаг дарга, Онцгой байдал, Тагнуул, Эмнэлэг, Шүүхийн шийдвэр биелүүлэх, Прокурор, Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах талаар төлөвлөгөөтэй, урьдчилан дадлага сургууль хийсэн байхыг хэлнэ.

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэсний дараа дараах арга хэмжээг авна. Үүнд:

- **Эмнэлгийн туслалцааг гэмтэж бэртсэн хүн бүрт яаралтай үзүүлж шаардлагатай арга хэмжээ авах /өмнө үйлдсэн үйлдлээс үл хамааран/**

Тухайн этгээдийн жагсаал, цуглаан дээр гаргасан авир байдлыг үл харгалзах ба хохирсон хэнд ч болов туслах /цагдаа, үймээн гаргагч, жагсагч, жирийн иргэн, сонирхогч г.м/. Тусламж шаардлагатай хүнд газар дээр нь анхны тусламж үзүүлж, эмнэлгийн байгууллагад хүргэх арга хэмжээг цаг алдалгүй авах, хордсон хүн амьтан гал түймэр гарах эх үүсвэр байгаа эсэхийг шалгаж холбогдох арга хэмжээ авах, иргэдэд зөвлөгөө өгөх⁴⁵

- **Бэртэж гэмтсэн хүнийн ар гэрийхэн болон ойр дотны хүмүүст нэн даруй мэдэгдэх⁴⁶**

Жагсаал, цуглаанд оролцогчид болон иргэд нь хэдийгээр хууль бус үйлдэл хийж хэрцгий авирласан байлаа тусгай хэрэгслийн нөлөөлөлд өртөж гэмтэж бэртсэн бол цагдаагийн байгууллагаас уг этгээдийн хэн болохыг тогтооож, ар гэрийнхнийх нь хаяг, утасны дугаарыг тодруулан түүний ар гэр, хамаатан садан, найз нөхдийн аль нэгэнд яаралтай мэдэгдэх арга хэмжээ авна. Уг хүний талаар ямар шийдвэр гарч хаана байгааг нь мөн дуулгана.

- **Илтгэх хуудас бэлдэж удирдлагад танилцуулах**

Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэсэн үндэслэл, явц, үр дүн, хүний эрүүл мэндэд гарсан өөрчлөлт, эмнэлгийн тусламж үзүүлэх арга хэмжээ авсан тухай дэлгэрэнгүй илтгэх хуудсыг нэн даруй бичиж шууд захирах даргад, шууд захирах дарга нь дээд шатны байгууллагын даргад танилцуулна.

Өөрөөр хэлбэл цагдаагийн төв байгууллагын даргад шуурхай танилцуулж энэ тухай илтгэх хуудас бичих.⁴⁷

Анхны тусламж үзүүлэх, бие хамгаалах хэрэгслийг ашиглах алба хаагч нь тусгай хэрэгсэл ашиглах, олон нийттэй харилцах, зөрчилдөөн шийдвэрлэх, сэтгэлийн хөдөлгөөнөө дарж сурах чадвараа сайжруулах сургалтанд хамрагдсан байх, бамбай хамгаалалтын хантааз, хамгаалалтын малгай, шууд үхэлд хүргэдэггүй/аминд халгүй/ зэвсэг хэрэглэж, эзэмшиж сурах. Өөрийн мэдэлд байх тусгай хэрэгслийг аюулгүй болгоомжтой авч явах.

Бүх төрлийн тусгай хэрэгслийн ашиглалтын албаны бэлэн байдалд цагдаагийн төв байгууллагын хэв журам хамгаалах алба хяналт тавьж цагдаагийн байгууллагын дарга тус байгууллагад байгаа бүх төрлийн тусгай хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын бэлэн байдлыг хариуцах алба хаагчийг томилж, үйл ажиллагаанд нь хяналт тавина.

- **Бэртэж гэмтэгсдэд тусламж үзүүлэх:**

Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэх явцдаа галт зэвсэг, тусгай хэрэгслийг бусдад хэрэглэсэн тохиолдолд наад захын эмнэлгийн анхны тусламж үзүүлэх шаардлагатай. Ер нь ямар ч осол, аюул тохиолдсон үед анхны тусламжийг зөв,

⁴⁵Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 19-р зүйлийн 19.11 дахь хэсгийн 19.11.1, 19.11.2 дахь заалт

⁴⁶НҮБ-ын Хүч болон галт зэвсэг хэрэглэх үндсэн зарчмууд, 1990 он 5 дугаар зүйл

⁴⁷Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 19-р зүйлийн 19.12 дахь заалт

тодорхой дэс дараалалтайгаар үзүүлэх явдал нь цагдаагийн ажилтны мэдлэг, ур чадварын нэг үзүүлэлт юм.

Аливаа осол гэмтэл, гэнэтийн биеийн хямрал, өвчин эмгэгийн үед эмнэлгийн тусламж иртэл, гарын доорх материалыг ашиглан, өөртөө болон нөхөртөө үзүүлэх тусламжийг анхны тусламж гэнэ.⁴⁸

Өөрөөр хэлбэл эмнэлгийн мэргэжлийн бус жирийн ард иргэдийн өөртөө болон нөхөртөө үзүүлж байгаа тусламжийг анхны тусламж гэж нэрлэх ба үүнийг эмнэлгийн мэргэжлийн түвшинд үзүүлж байгаа анхны тусламжаас ялгаж ойлгох хэрэгтэй юм.

Анхны тусламжийг зөв үзүүлснээр:

- Амь насыг аврах
- Осол гэмтлээс шалтгаалсан бусад хүндрэлүүдээс сэргийлэх
- Эдгэрэлтийг түргэсгэх
- Эмчилгээний зардлыг бууулах
- Хөдөлмөрийн чадвар алдалтын хугацааг богиносгох зэрэг эерэг үр дагаврыг бий болгодог байна.

Дүгнэлт

Цагдаагийн байгууллага, алба хаагч нь жагсаал цуглаан, нийтийн эмх замбараагүй байдал бий болсон үед олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг хэрэглэхдээ хүний эрхийн талаар тусгасан хууль тогтоомж ялангуяа Монгол Улсын нэгдэн орсон Нэгдсэн Үндэстний Байгууллагын олон улсын гэрээ, конвенцийн холбогдох заалтыг албаны үйл ажиллагаандаа ягштал мөрдөж ажиллах шаардлагатай байна.

Ингэснээр нэг талаас цагдаагийн байгууллага нь олон улсад хүлээн зөвшөөрсөн жишиг стандартыг баримтлан хүчийг зөв тохируулан хэрэглэх, нөгөө талаас хүний эрхийг хангаж ажиллах таатай нөхцлийг бүрдүүлэх юм.

ЦАГДААГИЙН ХЭСГИЙН БАЙЦААГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТУЛГАРЧ БУЙ ЗАРИМ ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛИЙГ ШИНЖЭХҮЙ НЬ



Б.Баянмөнх

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн ЦЭЗТ-ийн
дэд профессор, докторант цагдаагийн хошууч

Өнөөдөр хүний эрхийг дээдэлсэн иргэншсэн нийгмийг цогцлоохын тулд төр, засаг, иргэн бүхнээрээ хичээн ажиллаж байна.

1990-ээд оноос улс орон маань зорьж явсан чиг зүгээ гэнэт огцом өөрчлөн олон нам бүхий, төр төвтэй, ардчилал, хүний эрх, хувийн өмчийн эдийн засаг, зах зээлийг шүтсэн шинэ нийгмийн тогтолцоонд хөл тавьсан нь эерэг, сөрөг олон үр дагавар авч ирсэн.⁴⁹

НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссар Мэри Робинсон “Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүндэтгэх явдал нь НҮБ-ын өмнөө тавьсан зорилго, чиг үүргийн цөм нь бөгөөд НҮБ-ын дүрмийн гол зорилтын нэг байдаг..... Өнгөрсөн 50 гаруй билийн хугацаанд хүний эрхийг хамгаалах олон улсын хууль тогтоомж, жишиг стандартыг тогтоох талаар багагүй амжилт олсон хэдий ч түүнийг дэлхий дахинд өдөр алгасалгүй гарсаар

⁴⁸Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код- 207 “Осол гэмтлийн үед анхны тусламж үзүүлэх журам”-ийн 207.2 дахь хэсэг

⁴⁹ Л.Билгээ. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн ажлын арга зүй. УБ. 2005. 7 дахь тал

байгаа хүний эрхийн ноцтой зөрчлүүд, түгшүүрт бодит байдал бүдэгрүүлж байна”⁵⁰ хэмээн хэлсэн байдаг.

Хүн төрөлхтний төр ёс, хууль цаазын олон зуун жилийн түүхэн хөгжлийн явцад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгт нөлөөлөх аргууд, тухайлбал: хүмүүжлийн, хүмүүсийн амьдрахуйн хэрэгцээний хангамжийг дээшлүүлэх, нийгмийн хяналтын, нийгэмд аюултай этгээдийг тусгаарлах, өөрийгөө хамгаалах гэсэн аргууд боловсрогдож өнөөг хүртэл хэрэгжиж ирсэн байна.

Орчин үеийн хандлагаар бид хүний оршин тогтнох үнэт зүйлсийг хамгаалах ёстой гэж үздэг. Байгалаас хүнд заяасан хүний жам ёсны эрх, эрх чөлөө бий. Гэтэл үүсмэл эрх, өөрөөр хэлбэл бусад хүмүүстэй хамтран аж төрөх, амьдрах, хөдөлмөрлөхөд үүссэн ардчилалын ч юм уу, харилцан хамаарлын үед бий болсон эрх, эрх чөлөө хүний төрөлхийн, заяагдмал, жам ёсны эрхийг хөндөх нь цөөнгүй.

Хүний төрөлх эрхийг албан ёсоор олон улсын хүний эрхин хууль тогтоомжоор тодорхойлдог. Хүний эрхийг хамгаалах, хөхүүлэн дэмжих, эдлэх явдлыг баталгаажуулах нь төр, улсын хүлээх гол үүрэг учраас хувь хүмүүсийн эрхийг хангах үүрэг төрд оногддог.

Нутаг дэвсгэрийнхээ харъяаллын хүрээнд эрх нь зөрчигдсөн хүнд эрхийг нь сэргээх, мөн түүнчлэн эрх зөрчихтэй тэмцэх замаар хүний эрхийг хамгаалах явдлыг баталгаажуулах идэвхитэй арга хэмжээ авах нь тухайн улсын хүлээх үүргийн нэг юм.⁵¹

Тэгвэл манайд эрх нь зөрчигдсөн хүнд эрхийг нь сэргээх, мөн түүнчлэн эрх зөрчихтэй тэмцэх, гэмт хэрэг, зөрчлийг гарахаас нь урьдчилан сэргийлэхэд гол анхаарлаа хандуулж чадахгүй, харин гарсаны дараа нь хойноос нь хөөцөлдөж, илрүүлж, хариуцлага хүлээлгэдэг өвөрмөц “гуравдагч загвар” манайд төлөвших хандлагатай байна.

Тухайлбал гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёстой хүмүүс маань урьдчилан сэргийлэхээс илүү харин тэдгээрийг гаргасны дараа нь торгох, шийтгэхийг урьтал болгодог өвөрмөц тогтолцоо тогтчихоод байна.

Манай улсад хүний эрхийг хангах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх тогтолцоо байдаг хэдий ч төвлөрсөн бодлого, удирдлага дутмаг, тухайн үйл ажиллагаанд тавих хяналт сул, эрх хэмжээ, хүлээх хариуцлага тодорхой бус байгаа нь бодит үнэн юм.

1990 онд нийгмийн тогтолцоо бүхэлдээ өөрчлөгдөж, шинэ Үндсэн хууль батлагдан гарсанаар түүнийг дагаад олон үйл явдал дагаж өрнөсөн юм.

Тухайлбал, Цагдан сэргийлэх байгууллагыг “Цагдаагийн байгууллага” болгон өөрчлөн байгуулсан нь зөвхөн нэр төдийгүй, гүйцэтгэх үндсэн зорилт, чиг үүрэг, эдлэх эрхийг боловсронгуй болгосны дээр өмнөх тогтолцооны үеийн зарим үүргээсээ татгалзаж эхэлсэн нь Цагдаагийн байгууллагын бүтэц, тогтолцоо, чиг үүргийг шинэчлэн боловсруулах шаардлага зүй ёсоор гарч ирсэн юм.

Цагдаагийн байгууллагын ажлын ачаалал, ажилтны гүйцэтгэх үүрэг, эрх мэдлийн зөв хувиарлалт, албад хоорондын уялдаа холбоо, зааг ялгаа, хүлээх хариуцлага ямагт тодорхой шинжлэх ухааны үндэслэлтэй баймааж нь зохион байгуулалтын бүтэц оновчтой болно.⁵²

Нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын анхдагч нэгж нь цагдаагийн хэсэг юм. Цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх, гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулахад хэсгийн байцаагч онцгой чухал үүрэгтэй байдаг.⁵³

Тэдгээр нь хүн ам, олон түмэнтэй хамгийн ойр дөт байж, дүүрэг, баг, хороо зэрэг засаг захиргааны нэгж, тодорхой объект хариуцан ажилладаг.

⁵⁰ Хүний эрх. НҮБ-ын ажилтнуудад зориулсан гарын авлага. УБ. 2003. 9 дэх тал

⁵¹ Хүний эрх. НҮБ-ын ажилтнуудад зориулсан гарын авлага. УБ. 2003. 3-5 дахь тал

⁵² Ж.Долгорсүрэн “Монгол Улсын цагдаагийн эрх зүй” УБ., 2004 он.

⁵³ Цагдаагийн алба хаагчийн ёс зүй, үйл ажиллагааны орчин, түүний шинэтгэл. УБ. 2013. 142 дэх тал

Оршин суугчид, хэсгийн байцаагчийн ажлын үр чадвар, үр дүнгээрээ цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг бүхэлд нь үнэлж дүгнэх нь цөөнгүй, нөгөө талаар тэдгээр нь хүн ам, хамт олон, иргэдийг цагдаагийн байгууллагатай холбогч албан тушаалтан бөгөөд Нийтийн хэв журам хамгаалах газарт харьяалагдана.

Цагдаагийн байгууллагын Нийтийн хэв журам хамгалах газар Монгол Улсын Үндсэн Хууль⁵⁴, бусад хууль тогтоомжийн актыг амьдралд хэрэгжүүлэх, нийтийн хэв журам сахиулах, хууль ёсыг бэхжүүлэх үйл хэрэгт захиргааны үйл ажиллагааны бусад төрөлтэй харьцуулбал тэргүүлэх байр эзэлж хуулиар хүлээсэн олон үүрэг гүйцэтгэж, үлэмж хэмжээний хүч хэрэгслийг өөртөө нэгтгэсэн байдгаараа ихээхэн онцлогтой газар юм.

Нийтийн хэв журам хамгаалах газарт харьяалагдаж, ард иргэдтэй хамгийн ойр дотно ажилладаг алба хаагчид бол хэсгийн байцаагч бөгөөд тэдний үйл ажиллагаанаас шалтгаалан цагдаагийн нэр хүнд ард иргэдийн дунд өсч, буурах нэг үндэс болж өгдөг.

Цагдаагийн хэсгийн байцаагчийн ажлын амжилтанд хүрэх нөхцөл нь хариуцсан хэсгийнхээ өөрчлөгдөж буй нөхцөл байдлаа өдөр тутам мэдэрч үнэлэх, өдөр тутмын ажлыг төлөвлөж, ажлын цагаа үр ашигтай зарцуулах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаандаа шинэлэг, дэвшилтэд болон тухайн нөхцөл байдалд тохиромжтой тактикийн арга барилыг сонгож хэрэглэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд шинжлэх ухаан, техникийн ололтыг өргөнөөр нэвтрүүлэх, хамтран ажиллах зүй зохистой орчинг бүрдүүлэх явдал юм.

Өнөөдөр хэсгийн байцаагч нь өөрийн хариуцсан сум, хорооны онцлогт тохирсон өөр өөрийн арга барилаа боловсруулан ажиллаж байгаа ч хариуцсан нутаг дэвсгэрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг бүх талаас нь судалгаа, тоо мэдээнээс мэдэж, тасралтгүй үргэжлүүлэн судалж, оршин суугч, иргэдийнхээ хөдөлгөөнийг байнга хянаж, судалгаагаа байнга баяжуулж байх ёстой ч тэр бүр хүрсэн түвшинд ажиллаж чадахгүй байна.

Хэсгийн байцаагч өөрийн хариуцдаг нутаг дэвсгэрт байнга оршин суудаг иргэдтэйгээ ойр дөт байж, тэдэнд тус нэмэр болохоос гадна тэдэнд үйлчилж, үйлчилсэнийхээ хэрээр ард иргэдээсээ итгэл хүлээж, тэднээр туслалцуулж, хамтран ажиллах нь чухал асуудал болоод байна. Хариуцсан нутаг дэвсгэрийнхээ иргэдийн итгэлийг хүлээж чадсан хэсгийн байцаагч нь ард иргэдээсээ байнгын мэдээллээр хангагдахын зэрэгцээ нутаг орноо сайн мэдэрснээр ажил үйлчилгээ явуулах таатай орчныг бүрдүүлж чадна.

Өнөөдөр хэсгийн байцаагч засаг захиргааны тодорхой нэгж хариуцан хэв журам сахиулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа боловч хөнгөн гэмт хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулах, захиргааны хяналтын олон талт үйл ажиллагааг биечлэн гүйцэтгэхээс гадна цаг үеийн болон өөр бусад ажилд оролцдоггоос хариуцсан хорооныхоо нутаг дэвсгэр дээрээ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг тасралтгүй явуулах иргэд, оршин суугчдын гүнд нь орж ажиллах, судалгаа бүртгэл хийх, объектын судалгаандаа баяжилт хийх, мэдээлэл цуглуулах боломж хязгаарлагдмал байна.

Өнөөдөр хэсгийн байцаагчийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам сахиулах ажлын арга барил шинэчлэгдэхгүй, удирдлага, зохион байгуулалтын оновчгүй хэлбэрт баригдан алдаа дутагдал гарч, ажлын үр нөлөө төдийлөн дээшлэхгүй байна.

Өнөөдөр гэмт хэргийг гарсан хойно нь хөрөнгө мөнгө, хүч хэрэгсэл, цаг хугацаа зарцуулан байж түүнийг илрүүлэх, шийдвэрлэхдээ биш, харин гарахаас нь өмнө аль болох урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, эрх зүйн зөрчил гарч болох нөхцөл байдлуудыг арилгахад чиглэгдсэн арга хэмжээг иж бүрэн цогцолбороор нь явуулах нь өнөөгийн

⁵⁴ Төрийн мэдээлэл. 1992. №1

цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны шинэчлэлийн үндсэн тулгуур чиглэл нь байх болно.⁵⁵

Түүнчлэн хэсгийн байцаагч бүр хариуцсан хороо, нутаг дэвсгэртээ гэмт хэрэг, захиргааны зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хэв журам сахиулах чиглэлээр хийж буй ажил нь бодит байдал дээр удирдлага, зохион байгуулалт муутай, нэг хэвийн байдлаар явагддаг учраас өнөөгийн нийгэм тэднээс шинэлэг олон санаа сэдэж, олон зүйл хийж ажиллахыг шаардаж буйг үндэслэн, практик үйл ажиллагааны ололт, дутагдалд дүн шинжилгээ хийж, тавьсан зорилтыг ханган биелүүлж, ирээдүй хэтийн зорилгодоо хүрэх зарим арга замыг судлан тодорхойлоход дэмжлэг үзүүлэх нь чухал байна.

Хэсгийн байцаагчдын хариуцсан нутаг дэвсгэр дээрээ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн тодорхой арга хэмжээнүүдийг түлхүү зохион байгуулах, аж ахуйн нэгж, байгууллагуудад камер, дохиолол хамгаалалтын систем суурилуулах ажлыг зохион байгуулах, тэднийг байнгын харуул хамгаалалттай болгох, сонор сэрэмжийг нь дээшлүүлэх, заавар, зөвлөлгөө өгөх, хяналт шалгалт хийх ажил нь тогтмолжоогүйгээс гэмт хэрэг, зөрчлийн тоо буурахгүй байна.

Саяхан бидний явуулсан нийслэлийн Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн цагдаагийн хэлтсийн хэсгийн байцаагч нарын дунд хэсэгчилсэн хийсэн “Фокус”⁵⁶ ярилцлагын судалгааны дүнгээс харахад хэсгийн байцаагчдын 70-аас илүү хувь нь байнга илүү цагаар ажилладаг тэр дундаа 7 хоногт дунджаар 60-аас дээш цагаар ажилладаг, амралтын өдрүүдэд мөн ажилладаг, төлөвлөгөөт бус олон нийтийн ажилд татагдан оролцдог, маш олон шат дамжлагаас үүрэг, даалгавар өгөгддөг зэрэг маш олон хүндрэлүүдийг тоочсоноос харахад хэсгийн байцаагчдын үйл ажиллагаа нь төлөвшөөгүй, байнгын өөрчлөлтийн дунд явагддаг болохыг харуулж байна.

Мөн 2007 оны Нийслэлийн цагдаагийн газрын даргын Б/19 тоот тушаалаар “Хэсгийн байцаагч, хорооны цагдаагийн ажлын цагийн хуваарь”-ийг баталсан нь мөн л “Тухайн нутаг дэвсгэрийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын улмаас цагдаагийн байгууллагын даргын шийдвэрээр уртасгасан цагаар ажиллаж болно. Энэ тохиолдолд боломжтой өдөр тэр хугацаагаар нөхөн амруулна” гэсэн хэсгийн байцаагчийн ажлын зааврын заалтын хүрээнд хийсэн зохицуулалт мөн бөгөөд харамсалтай нь уртасгасан цагаар ажиллуулсны төлөө нөхөн амрах талаарх заалтыг хэрэгжүүлж байгаа дарга алга, хэрэгжүүлэх боломж ч хомс юм.

Хэсгийн байцаагч нь ердийн ажлын өдрийн ажиллах хугацааны 70-аас доошгүй хувийг тухайн хариуцсан нутаг дэвсгэр дэх хүн амын амгалан тайван амьдрах нөхцлийг бүрдүүлэх, иргэд, олон нийт цагдаагийн байгууллагын харилцан хамтын ажиллагааг сайжруулах, гэмт хэрэг, зөрчил үйлдэж болзошгүй хүмүүсийг илрүүлж, хяналтад авах, захиргааны хяналтад байгаа хүмүүстэй ажиллахад зарцуулахаар зааварт заажээ.

Гэвч хэсгийн байцаагчид нь цагдаагийн байгууллагын захиргааны үүргийн олон талт ажиллагааг биечлэн гүйцэтгэхээс гадна цаг үеийн болон өөр бусад ажилд дайчлагддагаас хариуцсан хорооныхоо нутаг дэвсгэр дээр гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг тасралтгүй явуулах, иргэд, оршин суугчдын дунд ил тод ажиллах, судалгаа бүртгэл хийж, хяналт тавих ажил өнөөгийн шаардлагын хэмжээнд хүрээгүй зэрэг зохион байгуулалтын дутагдлууд байсаар байна.

Тухайлбал “Хэсгийн байцаагчийн хийж гүйцэтгэж байгаа ажил үүрэг өөр албан тушаалын алба хаагчийн ажил үүрэгтэй давхцдаг уу?” гэсэн асуултанд дийлэнхи нь буюу 18 буюу 60 % хувь нь тийм ээ давхцдаг гэсэн нь энэ асуудлыг анхааралдаа авч,

⁵⁵ Цагдаагийн алба хаагчийн ёс зүй, үйл ажиллагааны орчин, түүний шинэтгэл. УБ. 2013. 142 дэх тал

⁵⁶ Фокус бүлэг Нарийвчилсан судалгааны сэдвээр мэдээлэл цуглуулахад чиглэсэн албан ёсны бус энгийн хэлбэрээр ярилцлага өрнүүлж буй цөөн тооны хүмүүсийн бүлгийг хэлнэ. Судалгааны зорилго, хамрах хүрээтэй уялдан хүмүүсийн тоог харилцан адилгүй тогтоодог.

ажил үүргийн харъяалалд дахин судалгаа хийх шаардлага гарч байна гэсэн дүгнэлтийг хийж байна.

Судалгаанд хамрагдсан хэсгийн байцаагч нарын өгсөн хариултыг тус бүрээр авч үзвэл

Тийм- 18 буюу 60 хувь,

Үгүй- 5 буюу 16,9 хувь,

Заримдаа- 7 буюу 27,1 хувь тус тус хариу өгсөн байна. Үүнийг графикаар үзүүлбэл,



Судалгаанд хамрагдсан хэсгийн байцаагч нараас “Төв болон харьяа цагдаагийн газар, хэлтэс, чиг үүргийн тасаг, хэсгээс ирж буй үүргүүд давхцах, нэг төрлийн үүрэг чиглэл олон газраас зэрэг ирэх тохиолдол хир их байдаг вэ?” гэсэн асуултанд:

Их –25 буюу 83,3хувь

Заримдаа – 3 буюу 10.1

Ирдэггүй – 2 буюу 6,6 хувь гэсэн хариу өгсөн байна. Графикаар үзүүлбэл:



Энэ нь шат дамжлага ихтэй, чиг үүргийн газар, хэлтсүүдийн хоорондын ажлын уялдаа холбоо муутай байгаагийн илрэл гэж үзэж болох юм.

Судалгаагаа бид илүү тодорхой болгож, үйл ажиллагааны чиглэлийн давхардалыг илрүүлэх зорилгоор “Ямар төрлийн үүрэг чиглэлүүд давхцаж ирдэг вэ?” асуултыг тавихад алба хаагчид илүү идэвхитэй хариулж байлаа. Тухайлбал:

- Төрийн өндөр хэмжээний зочин төлөөлөгчдийн хамгаалалтын үед хамгаалалтад ажиллах талаар
- ЦЕГ-ын дарга, тэргүүн дэд дарга нараас нийт бие бүрэлдэхүүнд өгсөн 1 агуулга бүхий үүрэг даалгаварууд доошоогоо маш задарч олон үүрэг чиглэл, даалгавар болж давхцаж ирдэг
- Хорихоос өөр төрлийн ял шийтгэгдсэн этгээдүүдэд хяналт тавих чиглэлээр Худалдаа үйлчилгээний байгууллагуудад хяналт тавих чиглэлээр алба хаагч
- Барилга угсралтын ажилд хяналт тавих чиглэлээр

- Орон тоо, автомашин, техник хэрэгсэл дутмаг байхад гэмт хэрэг зөрчлийг бууруулах чиглэлээр үүрэг даалгаврууд их ирж байна

Бидний хэсгийн байцаагч нартай ярилцлага хийж байх явцад 1 хэсгийн байцаагч “Дээрээс биднийг ард иргэдтэй ойрхон бай гээд байдаг боловч бодит байдал дээр тэс өөр байдаг. Бидний нэр дээр цохогдсон өргөдөлөө яах уу, ард иргэдийн саналыг сонс, боловсон харьц гээд байдаг. Одоо энэ хэсгийн байцаагч нарыг ард иргэдтэй ойрхон байлгахын тулд захиргааны хяналт, өргөдөлийг багасгах хэрэгтэй байна. Тэгж байж хэсгийн байцаагч бид нар ард иргэдтэй ойрхон байна. Одоо би хорооныхоо хүний бүх өргөдөлийг шалгана. Түүнд маш их хугацаа орно. Тэгээд бидэнд иргэдтэй ажиллах хугацаа бараг гардаггүй гэхэд худлаа болохгүй.

Түүнээс гадна бидний ар гэрийнхэн бидний хийдэг ажлыг ойлгож мэдэрдэггүйгээс маш их дургүйцдэг. Үүнийг холбогдох удирдлагад мэдрүүлж, ажил үүргийн хувиарыг дахин цэгцэлж өгмөөр байна”⁵⁷ гэсэн байна.

Мөн “Эдгээр давхардаж ирж байгаа үүргүүдийг хэрэгжүүлэхэд ямар бэрхшээл тулгардаг вэ?” гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан хэсгийн байцаагч нар дараах байдлаар хариулт өгсөн байна. Тухайлбал:

- Үндсэн үүрэгт ажлаас гадна удирдлагаас ирүүлсэн үүрэг чиглэлийн хариуг хүргүүлэхэд цаг зав, цаас ихээр зарцуулагддаг
- Хамгаалалтад ажиллахад Олон нийтийн аюулгүй байдлыг хангах газар, Нийтийн хэв журам хамгаалах газруудаас давхардуулан шалгаж дарамт учруулдаг
- Худалдаа үйлчилгээний журам сахиулах төрийн тусгай чиг үүргийн мэргэжлийн хяналтын байгууллага байсаар байтал тэдний ажлыг үндсэн үүргийнхээ хажуугаар гүйцэтгэдэг
- Барилга утсралтын чиглэлээр хяналт тавих үүрэг их ирдэг болсон. Энэ нь бидний ажил үүрэгт огт хамааралгүй гэдгийг удирдлагад танилцуулмаар байна.
- Хорихоос өөр төрлийн ял шийтгэгдсэн этгээдэд хяналт тавих ажил нь хуулиар ШШГА-д шилжсэн боловч өнөөг хүртэл гүйцэтгэсээр байгаа нь ачааллыг улам нэмэгдүүлж байна.
- Удирдах дээд газар, хэлтсээс ирсэн үүргүүдийг гүйцэтгэх явцад иргэд үйлчлэх цагдаагийн үндсэн үүрэг орхигдож иргэд хохирдог гэх мэт хариултуудыг нийтлэг байдлаар өгсөн байна.

Хэсгийн байцаагч нарын үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлтэй холбоотойгоор 30 хэсгийн байцаагчдын дунд явуулсан “Фокус”⁵⁸ ярилцлагын судалгааны дүнгээс харахад судалгаанд хамрагдсын 50-иас илүү хувь нь хэт олон төрлийн үйл ажиллагаа явуулдаг, ажлын ачаалал их, байнга илүү цагаар ажилладаг, 60 хувь нь ажлын ихэнхи цагийг өргөдөл, гомдол, эрүүгийн хэрэг шалгахад, 12 хувь нь зөрчил гаргасан хүнийг шүүхээр баривчлуулахад, 12 хувь нь байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхөөр орж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил явуулахад, 16 хувь нь эргүүлд гарахад гэсэн судалгааны дүн гарч байна.

Үүнээс гадна хэсгийн байцаагчийг айл өрхөөр явахад иргэд илт дургүйцдэг, гэртээ оруулдаггүй, нохой нь сул байдаг, өдрийн цагаар хүнгүй байдаг, үндсэн үүрэгтэй холбогдолгүй маш олон төрлийн судалгааг хийхийг шаарддаг, нэхдэг, түүнчлэн орой болгон шахуу нутаг дэвсгэр дээрээ үйл ажиллагаа явуулдаг баар, ресторануудын үйл ажиллагаанд давхар хяналт тавих, эргүүл хийх гэх мэт олон тооны хүндрэлүүдийг дурджээ.

⁵⁷ 2014 оны 11 сард хэсгийн байцаагч нартай хийсэн “Фокус” ярилцлагаас хэсэгчилэн авав.

⁵⁸ Фокус бүлэг Нарийвчилсан судалгааны сэдвээр мэдээлэл цуглуулахад чиглэсэн албан ёсны бус энгийн хэлбэрээр ярилцлага өрнүүлж буй цөөн тооны хүмүүсийн бүлгийг хэлнэ. Судалгааны зорилго, хамрах хүрээтэй уялдан хүмүүсийн тоог харилцан адилгүй тогтоодог.

Энэ бүх хүндрэл бэрхшээл нь хэсгийн байцаагчаас хэт олон төрлийн ажилд самгардах байдлыг үүсгэж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндсэн үүргээ хэрэгжүүлэх ажлын үр нөлөөг сулруулахад тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаа гэж дүгнэж байна.

СОГТУУРАХ, МАНСУУРАХ ДОНТОЙ ЭТГЭЭДИЙГ АЛБАДАН ЭМНЭЧИЛГЭЭНД ХАМРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ



Г.Бямбадорж

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн,
ЦЭЗТ-ийн багш,цагдаагийн ахмад

Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зэрэг хуулиар хүлээсэн олон төрлийн үүрэг гүйцэтгэдэг бөгөөд нийтийн хэв журмыг сахиулах ажлын нэг гол хэсэг нь архидаан согтуурах, мансуурах донтой этгээдийг албадан эмчилгээнд хамруулах үйл ажиллагаа юм.

Архидаан согтуурахтай тэмцэх ажлын хүрээнд энэхүү ажлыг эрчимжүүлж албадан эмчилгээнд өргөн хамруулах нь олон нийтийг архидаан согтуурах явдлаас ангижруулах боловч энэ нь түүнийг эмчилж байгаа эмнэлгээний арга барил, эмчлүүлж байгаа хүнээс үр дүн нь ихээхэн хамааралтай.

Манай улс архи согтууруулах ундаа хэрэглэх байдлаараа Азийн орнуудийн дунд дээгүүрт бичигдэж, нэг хүнд ноогдох архи согтууруулах ундааны хэмжээ дэлхий дундажаас хэд дахин илүү, архи согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдан борлуулж байгаа цэг салбарууд хэт олширсон зэрэг нь архидаан согтуурах явдал өсөн нэмэгдэх шалтгаан болж байгаа учир архидалттай хийх тэмцлийг сайжруулах хэрэгтэй байна.

Архинд донтох өвчтэй этгээд нь архинд донтох өвчтэй гэдгээ өөрсдөө танин мэдэх, өөртөө шүүмжлэлтэй хандах чадвараа алддагаас өөрсдийгөө архичин биш гэж үнэлдэг.

Тэд өөрсдийгөө архинд донтох өвчингүй эргүүл хүмүүс гэж тооцдогөөс архинаас гарах сайн дурийн эмчилгээнээс зайлсхийх явдал элбэг гардаг.

Зарим тохиолдолд сайн дурийн эмчилгээнд хамрагдсан боловч уух ёстой эмийг уухгүй нуух, хаях эмнэлэгийг ажилчидыг хуурч мэхлэх хүчээр бөөлжиж эмээ буцаан гаргах, тэрч бүү хэл мэс заслаар суулгасан эспералийг ухаж идээлүүлэх процесс үүсгэн гаргах, хийсэн эмчилгээний үр дүнг саармагжуулах, эмчилгээний дэглэм зөрчих зэрэг зохисгүй явдлуудыг гаргадаг байна.

Эмчилгээ хийлгэхийг чин сэтгэлээсээ хүсдэггүй давтан эмчлүүлэгчидийн зарим нь бусад архинд донтогч болон ард иргэдийн дунд албадан эмчилгээний эсрэг ухуулаг суртал явуулах зэргээр эмнэлэгийн үйлчилгээний ажилд сөрөг нөлөө үзүүлж байгааг анхаарах хэрэгтэй. Тухайлбал: Ард иргэдийн дунд архины албадан эмчилгээнд хамрагдсан хүн улам архинд ордог архинаас гарах нь бүү хэл бүр ч гүнзгий архинд ордог гэсэн яриа дэлгэрсэн нь дээрхтэй холбоотой юм.

Иймд ард иргэдийн дунд зөв ойлголт өгөх үүднээс цагдаагийн байгууллага тэр дундаа олон нийттэй харилцах хэлтэс, түүний алба хаагч нар архины албадан эмчилгээний үр дүнгийн талаар бүх төрлийн хэвлэл мэдээлэлийн хэрэгсэлээр ухуулан таниулах ажил зохиох хэрэгтэй.

Архидаан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Архинд донтох өвчтэй болсон этгээдийн өөрийн санаачилагаар эмнэлэгийн байгууллагад хандаж сайн дурын үндсэн дээр эмчлүүлэх хүсэлт гаргасан тохиолдолд түүнд өрдийн журмаар эмчилгээ үйлчилгээ үзүүлэх тухай заасан байна.

Мөн зүйлийн 2 дахь хэсэгт архинд донтох өвчтэй нь эмнэлэгийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон боловч сайн дураар эмчлүүлэхээс зайлсхийсэн этгээдийг шүүхийн шийдвэрээр албадан эмчлэхтэй холбогдсон харилцааг согтуурах мансуурах донтой өвчтэй хүмүүсийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуулиар зохицуулна гэж архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд заажээ.

Захиргааны хариуцлагын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Согтуурах, мансуурах донтой, түүнчлэн сэтгэхүйн өвчтэй буюу биеийн байцаалт тодорхойгүй этгээд зөрчил гаргасан бол тэдгээрийг цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтан 72 цаг хүртэл хугацаагаар албадан саатуулж болно”, 2 дахь хэсэгт “Цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтан энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаанд албадан саатуулагдсан согтуурах, мансуурах донтой болон сэтгэцийн өвчтэй этгээдийн талаар эмнэлэгийн дүгнэлт гаргуулах, албадан эмчлүүлэх тухай материалыг бүрдүүлж холбогдох байгууллагад шилжүүлнэ” гэсэн заалтууд нь архидан согтуурах мансуурах донтой этгээдүүдтэй тэмцэхэд ач холбогдолтой заалт болсон юм.

Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх үндэслэлийг заажээ.

4.1.Өвчтэй нь эмнэлэгийн дүгнэлтээр тогтоогдсон нийгмийн хэв журмыг зөрчсөн

4.2.Сайн дураар эмчлүүлэхээс зайлсхийсэн.

4.3.Эмчлүүлсний дараа согтууруулах ундаа, мансууруулах бодис дахин хэрэглэсэн этгээдийг шүүхийн шийдвэрийн дагуу албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газарт албадан эмчилнэ гэж заасан байна⁵⁹.

Дээрх үндэслэлийн агуулгыг нь авч үзвэл:

1. Архидан согтуурах, мансуурах донтой этгээд нь архидан согтуурах, мансуурах донтой болох нь эмнэлэгийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон байх явдал бөгөөд, эмнэлэгийн байгууллагын дүгнэлтээр тухайн этгээд архинд донтох өвчтэй нь тогтоогдоогүй байхад түүнийг албадан эмчилгээнд хамруулж болохгүй.

Нийтийн хэв журам зөрчсөн архи согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэдэг хүмүүсийг албадан эмчилгээнд хамруулж болохгүй харин архидан согтуурах, мансуурах донтой этгээд нь нийтийн хэв журам зөрчсөн тохиолдолд албадан эмчилгээнд хамруулна.

2.Архидан согтуурах мансуурах донтой этгээд нь өөрийн хүсэлтээр сайн дураараа эмчлүүлэхээс зайлсхийсэн бол түүнийг гэр бүлийн гишүүн, засаг дарга, цагдаагийн байгууллагын хүсэлтээр албадан эмчлэх үндэслэл болно.

3.Архидан согтуурах, мансуурах донтой этгээд нь архины сайн дурын болон албадан эмчилгээнд хамрагдсаны дараа, дахин архи согтууруулах ундаа хэрэглэсэн байвал түүнийг албадан эмчилгээнд хамруулах үндэслэл болно гэж ойлгох нь зүйтэй.

4.Албадан эмчлэх үйл ажиллагаа нь тодорхой хэмжээгээр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлаж байгаа учир тухайн этгээд нь архинд донтох өвчтэй болох нь эмнэлэгийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон байсан ч албадан эмчилгээнд хамруулж болохгүй, эмчилгээнд хамруулах эсэхийг шүүх шийдвэрлэх ба шүүхийн шийдвэр гараагүй байхад тухайн этгээдийг албадан эмчилгээнд хамруулж болохгүй.

Архидан согтуурах, мансуурах донтой этгээдийг албадан эмчилгээнд хамруулахад бүрдүүлэх материалыг энэ хуулийн 6-р зүйлд зааж өгсөн ба сум, баг, хорооны засаг дарга, цагдаагийн байгууллага нь согтуурах буюу мансуурах донтой этгээдэд холбогдох дор дурьдсан материалыг бүрдүүлж шүүхэд хүсэлт тавьж шийдвэрлүүлнэ. Үүнд:

➤ Тухайн этгээдийг албадан эмчлүүлэх тухай зохих байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хүсэлт

⁵⁹ СМДЭЗЖАЭАХТХ.

➤ Сум баг, хорооны засаг дарга, цагдаагийн байгууллагын тодорхойлолт, тухайн этгээд согтуурах, мансуурах донтой, өвчтэй болсон тухай эмнэлэгийн дүгнэлт зэргийг бүрдүүлж өгөх тухай заасан бөгөөд мөн хуулийн 6-р зүйлийн 2-д шүүх шаардлагатай гэж үзвэл дээр дурьдсанаас бусад материалыг шаардан авч болно гэж заасан байна.

Согтуурах, мансуурах донтой этгээдийг албадан эмчлүүлэх асуудлыг шийдвэрлэж байгаа шүүхийн өнөөгийн практикийг судлан үзвэл дээр дурьдсан бичиг баримтыг бүрдүүлэн шүүхэд шилжүүлэн өгч шийдвэрлүүлж байгаа боловч зарим тохиолдолд цагдаагийн байгууллагаас шилжүүлсэн материалын бүрдүүлэлт дутуу гэсэн шалтгаанаар шүүх энэ асуудлыг хэлэлцэхгүй орхих, мөн уг хуулийн 6.2-д заасан шүүх шаардлагатай гэж үзвэл дээр дурьдсанаас бусад материалыг шаардан авч болно гэсэн заалтыг баримтлах бодлого барьж байгаа нь нэг талаас хархад бидний хийсэн ажил гологдолтой байгааг харуулж байна.

Нөгөө талаас шүүх хүний эрхийг хангах, хууль тогтоомж зөрчихгүйн үүднээс хангалттай нотлох баримт цуглуулж түүндээ үндэслэн архидан согтуурах, мансуурах донтой этгээдийг албадан эмчлэх шийдвэр гаргах, эс гаргааа шийдэж байна гэж үзэж болох юм.

Ийм учраас согтуурах мансуурах донтой этгээдийг албадан эмчилгээнд хамруулах материал бүрдүүлэхэд ажлын дутагдал гаргахгүйн тулд дараах материалыг бүрдүүлж материалыг шүүхэд шилжүүлэхийг та бүхэнд зөвлөж байна. Үүнд:

1.Тухайн этгээдийг албадан эмчилгээнд явуулж өгөхийг хүссэн иргэн, байгууллага, албан тушаалтны гомдол, мэдээлэл, хүсэлт.

2.Согтуурах, мансуурах донтой этгээдийн иргэний үнэмлэх, хэрэв иргэний үнэмлэхгүй бол иргэний бүртгэл мэдээллийн албанаас авсан лавлагаа.

3.Согтуурах, мансуурах донтой этгээдийн эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын дэвтэр.

4.Согтуурах, мансуурах донтой этгээдийн цээж зураг 3%.

5.Согтуурах, мансуурах донтой этгээдийн гарын дардас папилон санд оруулсан байх

6.Согтуурах, мансуурах донтой этгээдийн удаа дараа эрүүлжүүлэгдэж байсан тухай эрүүлжүүлэх байрны дарга, эмчийн тодорхойлолт.

7.Тухайн этгээдийг архидан согтуурах, мансуурах донтой болохыг нотолсон эмнэлэгийн дүгнэлт.

8.Оршин суугаа газрын засаг даргын тодорхойлолт.

9.Согтуурах, мансуурах донтой этгээдийг архины албадан эмчилгээнд хамруулахыг хүссэн баг, хорооны засаг даргын хүсэлт, согтуурах, мансуурах донтой этгээдийн оршин суугаа газрын хэсгийн байцаагчийн тодорхойлолт.

10.Тухайн этгээдийг согтуурах, мансуурах донтой болохыг нь нотолсон бусад хүмүүсээс авсан тайлбар.

11.Согтуурах, мансуурах донтой этгээдийн урьд өмнө нь гаргаж байсан зөрчлийн талаарх материал рапорт, мэдээллийн дэвтэрийн хуулбар, арга хэмжээ авагдаж байсан бол шийтгэвэр, торгуулийн тасалбарын хуулбар г.м.

12.Согтуурах, мансуурах донтой этгээдийг албадан эмчилгээнд хамруулахыг хүссэн цагдаагийн газар, хэлтсийн даргын хүсэлт

13.Согтуурах, мансуурах донтой этгээдийг албадан эмчилгээнд хамруулахад цагдаагийн газар, хэлтсийг төлөөлж шүүх хуралд оролцох алба хаагчийг улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлж өгөхийг хүссэн газар, хэлтсийн даргын хүсэлт.

14.Согтуурах, мансуурах донтой этгээдийг албадан эмчилгээнд хамруулахад цагдаагийн газар, хэлтсийг иргэний шүүх хуралд төлөөлж оролцох алба хаагчийг томилсон хуудас гэх мэт материалуудыг бүрдүүлж болно.

Мөн дээр дурьдсан материалуудыг бүрдүүлснээр согтууруулах ундаа хэрэглэдэг хүмүүсийг хомроглон албадан эмчилгээнд явуулах, тооны хойноос хөөцөлдөхөөс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой юм.

Согтуурах мансуурах донтой этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөрлүүлэх тухай хуулийн 8-р зүйлд: Албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын харьяалалыг тогтоохдоо: Албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяанд байх бөгөөд түүний мэргэжлийн удирдлагыг Эрүүл мэндийн нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцхаар заасан байна.

Одоогийн үйл ажиллагаа явуулж байгаа албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газарт стандартын дагуу бол нэг удаа 100 хүн хүлээн авч эмчилгээ хийх хүчин чадалтай байдаг боловч одоогоор дундажаар нэг удаа 200 гаруй хүн эмчлүүлж байна.

Ийм учраас эмчлүүлэгч нэг бүртэй ойр ажиллах эмчилгээг улам чанаржуулах нөхцөл бололцоог хангах үүднээс уг газрыг өргөжүүлж, эмч, ажилтан, алба хаагчидын орон тоог нэмэгдүүлэх, тэдгээрийг нарийн мэргэжилийн төрөл бүрийн сургалтанд хамруулах шаардлагатай байна.

Нөгөө талаар уг газрын улсын төсөв дутагдалтай байгаа нь албадан эмчилгээний үр дүнд сөргөөр нөлөөлөх нэг шалтгаан болж байгааг анхаарч үзэх цаг нэгэнт болжээ.

Албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай шүүхийн шийдвэр гарсаны дараа тухайн этгээдийг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газарт цагдаагийн байгууллага хүргэнэ.

Цагдаагийн байгууллага тухайн хүнийг албадан эмчлэх, хөдөлмөрлүүлэх газарт дор дурьдсан бичиг баримтын хамт хүлээлгэж өгнө. Үүнд:

- Шүүхийн шийдвэр.
- Тухайн этгээдийг архидаан согтуурах, мансуурах донтой, өвчтэй болохыг нотолсон эмнэлэгийн байгууллагын дүгнэлт.
- Эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын дэвтэр⁶⁰.
- Цээж зураг 2%.
- Папилон системд оруулсан тухайн хүний зурагтай, гарын дардасны хуулбар.

Албадан эмчилгээ нь тухайн өвчтэй этгээд албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын эмч нарын зөвөлгөөнөөс эдгэрсэн тухай дүгнэлт гаргаж шүүхэд хандсан тохиолдолд шүүхээс эмчилгээний хугацааг дуусгавар болно.

Албадан эмчилгээнд гарсан зардлыг нь эмчлүүлэгчээр төлүүлэхийн тулд албадан хөдөлмөр хийлгэх нь цаашид нийтийн хэв журмын зөрчил үргэлжлүүлэн гаргахгүй байлгах, согтуурах, мансуурах явдлыг албадан зогсоодгоороо нийгэм, хувь хүнд чухал нөлөө бүхий албадлага юм.

Архидаан согтуурах, мансуурах донтой этгээдийг албадан эмчилгээнд хамруулах нь дараах ач холбогдолтой байдаг.

- Хорооны нутаг дэвсгэрт архидаан согтуурсан тухай дуудлага мэдээлэл багасана.
- Гэмт хэрэг, зөрчил буурна.
- Хорооны нутаг дэвсгэрт амгалан тайван байдал бий болно.
- Хэв журмын болон эрүүгийн нөхцөл байдал илааршина.
- Архаг архичидын тоо багасана.
- Архидаан согтуурдаг этгээдүүдийн гэр бүлийн гишүүдийн амгалан тайван байдал бий болно.
- Архидаан согтуурах мансуурах донтой этгээдийг албадан эмчилгээнд хамруулснаар бусад хүмүүст нөлөөлөл үзүүлэх ач холбогдолтой.
- Архидаан согтуурах, мансуурах донтой этгээдийн хувьд эдийн засгийн нэмнэлт бий болж, мөнгө санхүүгээ өөр хэрэгтэй зүйлд зарцуулна.
- Архидаан согтуурах, мансуурах донтой этгээдийг гэмт хэрэг, зөрчилд

холбогдохоос урьдчилан сэргийлнэ. (Жишээ нь: Эд зүйлээ дээрэмдүүлэх, булаалгах, зодуулах, осгох, хөл, гараа хөлдөөх) зэрэг аюулаас аврагдана.

- Архидан согтуурах, мансуурах донтой этгээд хорт зуршилаасаа сална.
- Архидан согтуурах, мансуурах донтой этгээд хорт зуршилаасаа салснаар нийгэмд төлөвшсөн бие хүн болох зэрэг ач холбогдолтой байна.

Согтуурах, мансуурах донтой этгээдийг албадан эмчлэх үйл ажиллгаанд сөргөөр нөлөөлж байгаа бас нэг зүйл бол албадан эмчилгээнд хамрагдах гэж байгаа этгээд нь архаг хууч, суурь өвчтэй байх явдал юм. Архаг хууч суурь өвчтэй гэх шалтгаанаар албадан эмчилгээнд хамрагдахгүй үлдэх тохиолдол их гардаг.

Улсын хэмжээнд бүртгэлтэй архинд донтох өвчтэй хүмүүсийн 60 орчим хувь нь зүрх судас, хоол боловсруулах эрхтний, тархи мэдрэлийн системийн архаг суурь өвчтэй байдаг ажээ.

Иймд эдгээр архаг хууч, суурь өвчтэй хүмүүсийг албадан эмчлэх газарт уг өвчнийг нь эмчлээд дараа нь албадан эмчлэх, албадан хөдөлмөрлүүлэх асуудлыг цогц байдлаар шийдвэрлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Манай орны нийгэм эдийн засаг, нийгмийн сөрөг үзэгдэл болох ядуурал, ажилгүйдэл, архидан согтуурах нь гэмт хэрэг, зөрчлийн үндсэн шалгаан болоод зогсохгүй иргэдийн эрүүл энх, тав тухтай ажиллаж амьдрах, сурч боловсроход нь бэрхшээл учруулж улмаар бидний ирээдүй болсон өсвөр үеийнхийг хүртэл энэ сөрөг нөлөөнд автах нөхцөл байдлыг буй болгож байгааг анхаарах цаг нэгэнт болжээ.

Архидан согтуурах мансуурах донтой этгээдийг албадан эмчилгээнд хамруулах тухай шүүгчийн шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн биелүүлэх бөгөөд СМДӨАЭАХТХуулийн 6-р зүйлд “Албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай шүүхийн шийдвэр гарах хүртэл тухайн этгээдийг саатуулах, шүүхийн шийдвэр гарсан дараа албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газарт хүргэх ажиллагааг цагдаагийн байгууллага гүйцэтгэнэ” гэж заасан бөгөөд уг зүйлд хүргэж өгөх зардалыг хаанаас хэн гаргах нь тодорхойгүй, мөн түүнчлэн эмчилгээ дуусч тухайн этгээдийг буцаах зардлыг хэрхэх тухай огт заагаагүй нь практик байгууллагуудад түүний ажилтан алба хаагч нарт хүндрэл учруулж байна.

Албадан эмчилгээ хийлгэх газар хүргэж өгч байгаа байдлыг нь судлан үзвэл ерөнхийдөө цагдаагийн алба хаагч хувийн зардлаараа тухайн этгээдийг хүргэж өгч байна.

Ийм учраас энэ хуульд нэмэлт өөрчлөлт оруулан хүргэж өгөх, буцаах зардлыг хаанаас хэн гаргах тухай зааж өгөх шаардлагатай.

Согтуурч, мансуурсан этгээдүүдийг архинд донтох өвчтэй эсэхийг тогтооход “Эрүүл мэндийн яамны сайд, Цагдаагийн ерөнхий газрын даргын хамтарсан А/142/ 332 тоот тушаалын 3-р хавсралтаар баталсан маягтыг ашиглана.

ГЭМТ ХЭРГИЙН ГАЗРЫН ЗУРАГ



Д.Нямбат

ЦЕГ-ын Судалгаан төвийн ахлах
мэргэжилтэн, цагдаагийн хошууч

Хэргийн газрын зураг нь гурван хэмжээст зураг болж хөгжтөлөө 8000 гаруй жилийг замнажээ⁶¹. Хүмүүс анх газрын зургийг хад чулуу, агуйн хананд зурж эхлээд улмаар мал, амьтны ширийг ашиглан зурж хүрээлэн буй орчиноо таньдаг байлаа. Газрын зурагт аливаа газар орны уул, гол мөрөн, төмөр зам, онгоцны буудал, гудамж, талбайн нэрс, барилга байгууламжийг дүрсэлж харуулахаас гаднаулс орнуудын хил хязгаарыг хооронд нь заагласан байдаг тул ач холбогдлыг нь үнэлж баршгүй юм. Газрын зургийн хөгжил дэлхийн түүхийг харуулдаг хэмээн эрдэмтэд үздэг.

Дэлхийн улс орнуудын цагдаагийн байгууллагууд гэмт хэргийн илрүүлэлт, түүнээс урьдчилан сэргийлэх ажилд гэмт хэргийн газрын зургийг ашиглаж эхлээд удаж байна. Тухайлбал өнгөрсөн зууны эхээр өрнөдийн улсуудын цагдаагийн байгууллагууд хариуцсан нутаг дэвсгэрийнхээ цаасан газрын зураг дээр үйлдэгдсэн гэмт хэргийг, түүний төрөл зүйлээр нь ялган өнгө өнгийн туг хатган нэвтрүүлж эхэлсэн. Тэд ийм тэмдэглэгээ хийсэн газрын зурагт тулгуурлан эрүү, хэв журмын нөхцөл байдлыг тодорхойлох задлан шинжилгээ хийн, улмаар ирээдүйд хийх ажлынхаа төсөөллийг авдаг байлаа.

Харин өнөөдрийн газрын зураг нь газар зүйн мэдээллийн шинжлэх ухааны ололтоор сая хүний гар утас, таблет, компьютерийн дэлгэцэнд багтаж, маш нарийвчлалтай харуулдаг болсон. Энэхүү технологийн дэвшлийг олон улс орны цагдаагийн байгууллагууд амжилттай ашиглаж байна.

Гэмт хэргийн газрын зураг гэдэг нь хамгийн энгийнээр өгүүлбэл гэмт хэргийн үйлдэгдсэн байршлыг газрын зурагт тэмдэглэж буй үйлдэл юм. Нарийвчилж хэлбэл гэмт хэргийн бүртгэлийг үйлдэгдсэн газартай нь уялдуулан байршуулж буй газар зүйн болон криминологийн шинжлэх ухааны мэдээллийн системийг хэлнэ. Нэг үгээр гав, галт зэвсэг, гар чийдэн гэх мэт цагдаагийн алба хаагч нарт өдөр бүр хэрэглэгддэг хэрэгсэлтэй адил гэмт хэргийн газрын зураг нь тэдний гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн багаж болон хөгжиж байна.

ГЭМТ ХЭРГИЙН ГАЗРЫН ЗУРАГ

Түүх эргэн сөхвөл гэмт хэргийн газрын зургийн үндсэн санаа 1800-аад оны дунд үед Францын сэтгэл судлаач Андре Гейри, Адолф Кютлет нарын гэмт хэргийг гаралтыг бүртгэхээр оролдсон ажлынх нь үр дүнгээс эхлэлтэй.

Улмаар 1900 оны эхээр Чикагогийн их сургуулийн сэтгэл зүйч, нийгмийн ухааны эрдэмтэн, багш нар гэмт хэргийн газрын зургийг өнөөгийн түвшинд хүргэхэд их нэмэр болсон гэдэг. Тэдгээр эрдэмтдийг “Чикагогийн сургуулийн баг” гэж ч алдаршуулан нэрлэдэг. Тиймдээ ч энэхүү аргыг Иллинойс мужийн цагдаагийн газрууд 1926 оноос хүн амины гэмт хэргийг газрын зурагт “зүү” хатган бүртгэж ажилдаа анх нэвтрүүлсэн юм.

“Давтагдах хөдөлгөөний онол”⁶²(Routine activity theory) нь гэмт хэргийн газрын зургийн суурь үндэслэлийг тодорхойлсон байдаг. Гэмт хэргийн тухай энэ онол нь 1950-иад оны дунд үеэс Амос Хавлеу-гээр дамжаад 1979 онд Лавренс Кохен болон Маркус

61 Uri Friedman (2013) “12 Maps That Changed the” нийтлэл

World <http://www.theatlantic.com/international/archive/2013/12/12-maps-that-changed-the-world/282666/>

62 Nicholas Branic (2015). Routine Activity Theory, University of California, Irvine

Фалсон нарын хамтын бүтээлээс эхлэлтэйбөгөөд криминологийн шинжлэх ухааны нэгэн онол болон хөгжсөөр байгаа.

Онолын гол санааг маш товчхоноор өгүүлбэл гэмт үйл явдлыг хүрээлэн буй орчинтой холбож тайлбарлах арга юм. Өөрөөр хэлбэл гэмт хэрэг, зөрчил үйлдэх эрсдэлтэй, эсхүл аль хэдийнээ үйлдсэн иргэний зан авир, эцэг эхийн удамшил, хувь хүний боловсрол, хүмүүжлээс шалтгаалж гэмт хэрэг үйлдэгдэж буй эсэхийг судалдаг бусад онолоос ялгаатай.Тодруулбал“ямар төрлийн гэмт хэрэг хаана хэдэн цагт үйлдэгдээд байна”? асуултад хариулт өгнө.

Жишээ нь иргэн А-гийн дэлгүүр өглөө 10 цагт онгойж орой 23 цагт хаах тогтсон цагийн хуваартай. Гэтэл өнгөрсөн жилүүдэд уг дэлгүүр удаа дараа хулгайн халдлагад өртөж. Ингээд дэлгүүрийн байршил дээр хулгайн гэмт хэргийг илтгэсэн цэнхэр өнгийн хэд хэдэн “зүү” хатгагджээ. Зүүг харсан цагдаагийн алба хаагч төвөггүйгээр дүн шинжилгээ хийж дэлгүүрийн орчимд гэрэлтүүлэг, манаач, камер, давхар хаалга, цонхны төмөр хаалт, цагийн хуваарийг өөрчлөх үү зэрэг дахин хулгай гаргахгүйн тулд цаашид ямар арга хэмжээг авах, юу хийх шаардлагатай вэ? гэдэг хариултыг олно. Үүнээс улбаалж цагдаагийн явган болон машинт эргүүлийн чиглэл, хуваарь, алба хаагчийн тоо ч мөн өөрчлөгдөж байх болно.Төрийнболон төрийн бус байгууллага, иргэд юу хийж болох, хоорондоо хэрхэн хамтарч ажиллаж байх зэрэгт чиглэл болно.

“Давтагдах хөдөлгөөний онол”-ын үндэслэлээр “гэмт хэргийн газрын зураг” хэмээх аргыг цагдаагийн байгууллагууд хот, суурин газар гэлтгүй орон нутагт бүртгэгдэж байгаа гэмт хэргийг бууруулах зорилгоор өргөнөөр ашиглаж байна. Тухайлбал,Австрали, Бразил, Канад, Энэтхэг, Япон, Норвеги, Их Британи зэрэг олон орны цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үндсэн үүрэгтээ ашиглаж байгаа бол АНУ-д 1998 оны байдлаар хууль сахиулах байгууллагуудын 75% нь ажилдаа нэвтрүүлсэн тухай мэдээ байна63.

Тэд 1990-ээд оноос гэмт хэргийн цахим газрын зургийг компьютерийн тусламжтайгаарүүсгэн ашиглаж эхэлсэн бөгөөд түүнээс хойшзарим хотууд тодорхой төрлийн гэмт хэргийн түвшинг 20% хүртэл бууруулжээ.

ГЭМТ ХЭРГИЙН ГАЗРЫН ЗУРГИЙГ НЭВТРҮҮЛЭХ ШААРДЛАГА

Манай улсад гэмт хэргийн гаралт жил бүр өссөөр байна. Цагдаагийн байгууллагад 2013 онд 25362 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд оныхоос 3273 хэргээр буюу 14.8 хувиар их байна64. Үүний 15419 буюу талаас илүү нь нийслэлд үйлдэгджээ. Харин өнгөрсөн жилд 27318 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 17144 нь нийслэлийн дүүргүүдийн цагдаагийн хэлтэст бүртгэгджээ. Нийслэл, орон нутгийн гэмт хэргийн гаралтыг хооронднь харьцуулбал дийлэнх гэмт хэрэг нь Улаанбаатар хотод үйлдэгдэж байна.

Захиргааны зөрчлийн хувьд 2013 онд 777793, харин 2014 онд 681222 улсын хэмжээнд бүртгэгдсэн бөгөөд зөрчлийн тоо түрүү жилд өмнөх жилийнхээсбага зэрэг буурсан боловч дийлэнх нь мөн л нийслэлд бүртгэгджээ.

Үүнээс гадна цагдаагийн байгууллагад бүртгэгдээгүй гэмт хэрэг, зөрчлүүд бий бөгөөдзарим нэгшалтгаан, нөхцлөөс дурдвал хохирогч цагдаагийн байгууллагад хандаагүй, хандсан ч гомдол, мэдээллийг бүрэн гүйцэт шалгадаггүй,хохирлын хэмжээг дарж эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалздаг, дуудлага өгсөн иргэний нууцлалыг хадгалдаггүй, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг дутуу хийдэг гэх мэт

63 Robinson (2006). “Crime mapping” нийтлэлийн 323 хуудас. The encyclopedia of Police Science номны Здахь хэвлэлт,

64ЦЕГ (2013) “Монгол улс дахь гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал” номны 7 дугаар хуудас

ажлын алдаануудад анхаарч ажиллах тухай цагдаагийн төв байгууллагын даргаасалба хаагч нарт 2015 онд өгсөн үүрэгтээ дурдсан байна⁶⁵.

Сүүлийн үед бүртгэгдсэн болон бүртгэгдээгүй захиргааны зөрчил, гэмт хэрэг болонтэдгээрийг үйлдсэн хүний талаарх мэдээ олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, интернет орчинд тун хурдан тарж байна. Энэхүү мэдээлэл үнэн эсэхээс үл шалтгаалан нийгэмд айдас түгшүүр бий болгодогбөгөөд үүнийг дагаад иргэд стресст орж бухимдан Хууль тогтоох, Гүйцэтгэх, Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах, нутаг дэвсгэр, засаг захиргааны байгууллагын удирдлагаа шүүмжлэх, ялангуяа цагдаагийн байгууллагад үл итгэх хандлага үүсэх, аюулгүй орчинд амьдарч байгаадаа эргэлзэх зэрэг маш олон сөрөг нөлөөллийг үүсгэдэг нь тогтоогдсон билээ.

Эндээс дүгнэхэд эрүү, захиргааны нөхцөл байдал жил ирэх бүр өссөн, цагдаагийн алба хаагч нарын гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх уламжлалт арга барилыг өөрчлөх, нийгэмд үүссэн айдас, түгшүүрийг багасгах, арилгах нь гэмт хэргийн газрын зураг аргыг нэвтрүүлэх зүй ёсны шаардлага байх болно.

ГЭМТ ХЭРГИЙН ГАЗРЫН ЗУРГИЙН АЧ ХОЛБОГДОЛ

Иргэд ямар ч шалтгаангүйгээр айж алхах нь утгагүй юм. Монгол Улсын иргэд цаашилбал гадаадын жуулчдыг гэмт хэргийн хохирогч болохоос сэргийлэх шилдэг аргын нэг бол гэмт хэргийн газрын зураг үйлдэх билээ. Энэ нь гэмт хэргийг газрын зурагт тэмдэглэх энгийн нэг арга мэт боловч өргөн утгаар нь авч үзвэл “аюулгүй байдлыг хангахгүйгээр тэнд хүүхэд сайн сурах, хүчирхийллийг халах, эрүүл амьдрах тухай ойлголт байхгүй⁶⁶” гэдгийг санах хэрэгтэй.

Гэмт хэргийн газрын зургийг нэвтрүүлэх нь олон төрлийн ач холбогдолтой.

Үүнд:

1. Гэмт хэргийн зураглалыг нэвтрүүлснээр тухайн хорооны нутаг дэвсгэрийн нэг хэсэгт нь гэмт хэрэг гарч байдаг бол нөгөө хэсэгт нь гардаггүй учрыг олох болно. Жишээ нь: Баянгол дүүргийн 1-р хорооны нутаг дэвсгэрийн яг аль хэсэгт, ямар цагт, ямар төрлийн гэмт хэрэг, зөрчил илүүтэй үйлдэгдээд буй нь тодорхой болох юм;
2. Гэмт хэргийн бүртгэлийг байршилтай нь уялдуулснаарсургуулийн орчимд юмуу, байрны орцонд уу, дэлгүүрийн ард талд уу, граж олонтой газар үйлдэгдсэн үү, хулгайд өртсөн машин дохиололтой байсан уу зэрэг олон олон эзэнгүй асуултын хариуг өгөх “ой санамж” нь байх болно. Өөрөөр хэлбэл одоо байгаа гэмт хэргийн статистик мэдээ хэргийн тоог л илэрхийлэхээс гарсан нөхцлийг илэрхийлдэггүй байдлыг өөрчлөх юм;
3. Энэ “ой санамж” нь хэвлэл мэдээлэл, зурагт, Facebook, twitter-ээс ирэх мэдээллээс илүү бодитой байх тул иргэд итгэлтэй нь аргагүй бүрэнхийд гэрлүүгээ алхаж чаддаг болно. Гэгээ тасрангуут яаран сандран гүйдэг хүүхдүүд цөөрөх болно. Нэг үгээр мэдээлэл бодит болсноор тухайн хот, дүүргийн талаарх таагүй ойлголт өөрчлөгдөх, хиймлээр үүссэн гэмт хэрэг, гэмт этгээдийн талаарх айдас нь алга болно;
4. Цагдаагийн байгууллагаас үе үе хэрэгжүүлдэг хүн хүч, бензин тос шаардсан олон олон нэгдсэн арга хэмжээнүүд цөөрөх болно. Тэд гэмт хэргийн газрын зургийг ашигласнаар цагдаагийн байгууллага хаана хүчээ төвлөрүүлэх, ямар цаг хугацаанд эргүүл ажиллах уу гэдгээ үр дүнтэй болгон өөрчилж чадна;
5. Гэмт хэргийн түвшинг 20% хүртэлх хэмжээнд бууруулах боломжтой. Мөн зөрчлийн гаралтыг бууруулж, урьдчилан сэргийлнэ. Жишээ нь: АНУ-н Нью Йорк хотын цагдаагийн газар CompStat компьютерийн програмыг ашигласнаар хулгай, дээрэм, хүн амь, танхай, машины эд ангийн хулгай зэрэг гэмт хэргийн

65Цагдаагийн Ерөнхий Газрын 2015 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн “Үүрэг ажлын чиглэл хүргүүлэх тухай” 2/15 дугаартай тоот. Эхний нүүрний 5 дахь цогцолбор

66 Anne Milgram (2014). “Smart Statistic” илтгэл, TED.

гаралтыг 1994 оноос 2009 оны хооронд 64% бууруулсан бөгөөд холбооны хэмжээнд 19.4% багасгасан байна⁶⁷;

6. Нийслэлийн иргэд болон цагдаагийн алба хаагч нар тухайн газарт яагаад гэмт этгээд тэр газрыг сонгож гэмт хэрэг үйлдэж буй шалтгааныг, ямар иргэд хохирогч болж, эсхүл халдлагад өртөлгүй зүгээр өнгөрөөд буйг мэдэх болно;
7. Эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал ямархуу байгааг дүгнэх боломжийг бий болгох тул Засгийн газар, нийслэлийн удирдлагаас гэмт хэрэгт өртөөд буй эмзэг цэгүүд дээр юу хийж болох, хэрхэн байдлыг өөрчлөх юм зэрэг асуудлаар шийдвэр гаргахад нь шинжлэх ухааны үндэслэлтэй, судалгаанд үндэслэсэн луужин нь болдог зэрэг олон зэрэг үр дүн авчрах ач холбогдолтой.

Гэмт хэргийн газрыг зургийг ашигласны ач холбогдлыг нэгтгэн дүгнэвэл гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлыг, удирдлагын шийдвэр, одоо хэрэгжүүлж буй арга хэмжээ, ажиллагаануудад **дүн шинжилгээ** хийх бааз нь болно.

ГЭМТ ХЭРГИЙН ГАЗРЫН ЗУРАГ НЭВТРҮҮЛЭХ АРГА ЗАМ

ШШГЕГ, ГЕГ, УТЕГ, Болор толь бичиг, Монос зэрэг хэдэн арван байгууллага өөр өөрийн онцлогтой аппликайшн ашиглаж байна. Тэр ч бүү хэл шумуул үргээх аппликайшн бүтээгдсэнийг иргэд ашиглаж байна.

ХЗЯ-ны төрийн нарийн бичгийн даргын тушаалаар 2013 онд “гэмт хэргийн цахим зураглал”-ыг практикт нэвтрүүлэхээр ХСИС, ЦЕГ, МУИС зэрэг байгууллагын төлөөллийг багтаасан ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.


Гэмт хэргийн газрын зургийг Six Sigma, TQM, COMPSTAT зэрэг софтвер програм ашиглаж болохоос гадна гар утас, таблетны **аппликайшн** ашиглах нь түгээмэл болж байна. Учир нь энэ аппликайшныг бүтээхэд тийм ч өндөр зардал гардаггүй.

Жишээ нь Улаанбаатарт буй манай улсын зарим компанийн үнийн санал 5 сая орчим төгрөг байна. Аппликайшнтай зэрэгцээд цахим хуудсыг ажиллуулж цугт нь баяжуулаад явах боломжтой. Цахим хаяг хийх зах зээлийн үнэ нь 500.0-2 сая төгрөгийн хооронд байна. Интернетийн (host service fee) жилийн хураамж 80-100\$ орчим үнэтэй. Нийт 5.7-7 сая төгрөгийн зарцуулна.


Нэгэнт бий болгосон аппликайшныг цагдаагийн алба хаагчид, хүсвэл иргэд үнэ төлбөргүй татаж авна. Жишээ нь АНУ-д бүх муж, хотын цагдаагийн газруудыг багтаасан, дунд нь ашиглагддаг, иргэд нь бас суулгах боломжтой үнэ төлбөргүй “Crime Mapping” аппликайшныг ашигладаг. Мөн тэндэхийн иргэд оршин суугаа газрынхаа эсхүл жуулчлахаар төлөвлөсөн хотынхоо нэрийг оруулахад хэзээ, аль гудамжинд, ямар төрлийн гэмт хэрэг үйлдэгдэж байсан тухай мэдэх болно. Үүнээсөөрсдийнхөө эд хөрөнгө болон амь насаа хамгаалах, юунд анхаарал болгоомжтой хандах вэ гэдгээ дүгнэж байдаг.

Дээр дурдсан аппликайшн болон цахим хуудсын цэс, агуулгаас санаа авч ижил төрлийн боловч Монгол үсэг, заавартай аппликайшн болон цахим хуудсыг ажиллуулна. Үүнд:

⁶⁷Public Engines (2015) Does the CompStat Model Really Reduce Crime?
<http://www.publicengines.com/solutions/compstat.php>



Зураг 1: Гэмт хэргийн төрлүүд




Зураг 2: Календарын сонголт

Зураг 1 нь гэмт хэргийн төрлүүдийг харуулж байна. Тухайлбал улбар шар өнгөөр түймрийг, улаанаар танхай, хараар хулгай, шараар нийгмийн амгалан тайван байдал алдагдуулсан, үзмэн ягаан өнгөөр хар тамхи болон согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ хүч хэрэглэсэн, бүдэг ногооноор замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийг, ногооноор залилан, тод улаанаар хүн амины, цэнхэрээр дээрэм, завсрын бүдэг цэнхэр өнгөөр хүчингийн, чернилэн ягаанаар галт зэвсэг ашиглаж үйлдсэн гэмт хэргүүдийг тус тус ялгаж өгнө.



Зураг 3 Цагдаагийн байгууллагууд




Зураг 4: Гишүүнчлэл

Зураг 2-ын хувьд тухайн газар нутгийн гэмт хэргийн гаралтыг долоо хоногоор уу, сарын хугацаатай юу эсхүл бүтэн жилээр нь харах уу гэдгээ сонгож буй цонхыг харуулж байна. Жишээ нь 2011 оны 6 дугаар сарын 10-наас 2011 оны долдугаар сарын 17-ны хооронд үйлдэгдсэн гэмт хэргийг харахаар тааруулж болно.

Зураг 3-ын хувьд цагаан толгойн үсгийн дарааллаар цагдаагийн байгууллагуудыг доош нь жагсаасан байгааг харуулж байна. Манай улсын хувьд Баянгол дүүргийн Цагдаагийн Ихэлтэс гэсэн сонголтыг дарахад тэр байгууллагын хариуцсан нутаг дэвсгэртухайлбал III, IV-р хорооллын газрын зураг дээр үйлдэгдсэнхэргүүд өнгө өнгөөрөөр ялгагдан харагдах болно.

Зураг 4 нь хэрвээ хэрэглэгч бүртгэлтэй бол утсанд нь шинээр тэмдэглэгдсэн гэмт хэргийн мэдээлэл сэрэмжлүүлэг болж ирэх боломжийг нээнэ. Мессеж гэсэн үг. Гэхдээ ингэж мэдээлэл авч байх эсэх нь хэрэглэгчийн шийдвэр байх болно.

Зураг 5: Тодорхой нутаг дэвсгэрт бүртгэгдсэн гэмт хэргийг өнгөөр харуулав.



Энэ дундаас аль нэг дүрсийг дарж ямар утгатай мэдээлэл болохыг харах боломжтой. Жишээ нь чернилен ягаан өнгө нь машины хулгайг илтгэнэ. Дээр нь дарахад зургийн дотор харагдаж байгаа цагаан өнгийн хүснэгт гарч ирэн дараах мэдээллийг өгнө.

Үүнд: Эрүүгийн хэргийн дугаар (151408855), хэрэг үйлдэгдсэн он сар өдөр, цагийг (3/4/2015, 11:30 PM), хэрэг үйлдэгдсэн гудамжны нэрбуйуу өргөн чөлөөний нэр (10700 ROSE AV), ингээд хамгийн доод талд нь хэргийн товч утга (хохирлын хэмжээ)зэргийг багтаасан.68

Дээрх “CrimeMapping.com” болон “Crime map” аппликайшн нь хувийн хэвшлийн компаниас хохирогч нарын дунд явуулсан судалгаа, цагдаагийн байгууллагын рапорт, ажиглалт, ярилцлага зэрэгсудалгааны аргуудыг ашиглан төсвөөс санхүүжин мэдээллээ баяжуулдаг.

Манай улсын хувьд хоёр сонголт бий. Хувийн хэвшлийн байгууллага эсхүл цагдаагийн байгууллагад хариуцуулан хийлгэх боломжтой.

1. **Хаана:** нийслэл хотод дийлэнх гэмт хэрэг нь үйлдэгддэг учраас хотын дүүргүүдийн цагдаагийн хэлтсүүдийг түшиглэн хэрэгжүүлэх нь зүйтэй.
 2. **Хэн:** хувийн хэвшил юмуу цагдаагийн байгууллагын аль нь ч байлаа гэсэн баяжуулалт хийх нь тийм ч төвөгтэй бус. Тухайлбал мэдээлэл-судалгааны тоо бүртгэгч, мэдээлэл-судалгааны ахлах байцаагч нар гэмт хэргийн бүртгэлийг цахимжуулан, баяжуулаад явна. Харин хувийн хэвшлийн байгууллагыг түшиглэн хийвэл цагдаагийн байгууллагаас өглөө бүр гаргадаг хоногийн нөхцөл байдлын мэдээг (цагдаагийн рапорт) ашиглан хэрэгжүүлнэ.
 3. **Мэдээлэл оруулах:** Гэмт хэргийн тэмдэглэгээг өдөр бүр шинэчилнэ.
 4. **Хэрхэн:** компьютерийн програм, гар утас таблет-нд зориулсан аппликайшныг энэ төрлийн үйл ажиллагаа явуулдаг хувь хүн, компаниар хийлгэнэ. (21-30 хоног)
 5. **Хугацаа:** хэрэгжүүлж эхлэхэднийтдээ 1-2 сарын хугацаа шаардана.
 6. **Төсөв:** аппликайшн болон цахим хуудас хийх зардлыг нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, ЦЕГ, Улаанбаатар хотын цагдаагийн газар зэрэг байгууллагын төсвөөс гаргах боломжтой.
 7. **Үр дүн:** Энэ ажлын үр дүнг ЦЕГ-ын Судалгааны төв жил бүрийн эцэст тайлагнана.
- ТӨГСГӨЛД НЬ**

Иргэд учирч болох эрсдлийг тооцоолоогүйн улмаас гэмт хэргийн хохирогч болж болох боловч, газар зүйн хувьд буюу тэр орчинд амьдардаг гэдгээрээ эсхүл дэлгүүр ажиллуулдаг гэдгээс хамаарч гэмт хэргийн хохирогч болж буй нь байж боломгүй үзэгдэл юм.

Шинжлэх ухааны үндэслэлтэй, олон улсын туршлагаар баталгаажсан, орчин үеийн технологи боловч зардал багатай бүтээгдэх, 24/7 хоног тасралтгүй ажиллагаатай, бодитой үр дүн гарахуйц гэмт хэргийн газрын зургийн ашиглах аргыг нийслэл хотод хэрэгжүүлэх нь зүйтэй гэдгийг энэ нийтлэлээр харууллаа.

ЯЛТАНГ НИЙГЭМШҮҮЛЭХ НЬ ГЭМТ ХЭРГЭЭС УРДЬЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА МӨН



Д.Булган

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн
ЦЭЗТ-ийн багш, цагдаагийн ахмад

Хорих ял эдлээд суллагдсан, хорихоос өөр төрлийн ял эдэлж буй этгээдийг нийгэмшүүлэх ажлыг олон улсын жишигт нийцүүлэн Монгол Улсын нөхцөлд тохиромжтой

байдлаар хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

“Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”, “Цагдаагийн албаны тухай хуулийн дагаж мөрдөх журмын тухай хууль”-д зааснаар хуулийн шинэтгэл хийгдэж, **хүн төвтэй нийгэмшлийг бэхжүүлж**, гэмт хэрэг, хэв журмын зөрчил гаргасан этгээдийг нийгэмшүүлэх, дахин гэмт хэрэг, зөрчил гаргахгүй байх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхойлов. Үүнтэй холбоотойгоор “Ялтныг нийгэмшүүлэх хөтөлбөр⁶⁹”, “Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны заавар⁷⁰”, “Хорих ял эдлээд суллагдсан зарим хүнд захиргааны хяналт тогтоох⁷¹” зэрэг эрх зүйн дэд акт, дүрэм журмыг гаргасан нь бүхэлдээ нийгэмшүүлэхэд чиглэгдэв.

Ийнхүү цагдаагийн байгууллагаас тавьж буй захиргааны хяналт, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хийгдэж буй нийгэмшүүлэх ажлын зорилго нь гэмт хэрэг, хэв журмын зөрчил гаргаж буй этгээдийг нийгэмшүүлэх, дахин гэмт хэрэг, хэв журмын зөрчил гаргахгүй байх явдал бөгөөд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх шилдэг арга гэж хэлж болохоор байна.

“Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай Монгол Улсын хууль”-ийн 15 дугаар зүйлийн 1-д захиргааны хяналтын зорилго нь ...“дахин гэмт хэрэг үйлдэх, нийгмийн хэв журам зөрчихөөс урьдчилан сэргийлэх ” явдал гэж тодорхойлоод дараахь гэмт хэрэгт 5-аас дээш жил хорих ял эдэлсэн, эсхүл түүнийг давтан үйлдсэн хүн хорих ял эдлээд суллагдсан бол захиргааны хяналт тогтооно⁷²” гэж заасан юм.

Цагдаагийн байгууллагаас хорих ял эдлээд суллагдсан зарим хүнд захиргааны хяналт тогтоож байгаа бөгөөд “Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль”-ийн 14 дүгээр зүйлд “Хорих ял эдлээд суллагдсан, тэнсэн харгалзсан, ял эдлүүлэхийг хойшлуулсан зарим хүнд захиргааны хяналт тавихаар

⁶⁹ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2009 оны 198 тоот тушаалаар баталсан “Ялтныг нийгэмшүүлэх ажлын хөтөлбөр”

⁷⁰ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаал 2010 оны А/107 дугаар тушаал. Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын заавар.

⁷¹ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. Код 601 Хорих ял эдлээд суллагдсан зарим хүнд захиргааны хяналт тогтоох.

⁷² Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль. 1997 он. ТМ-98 №1

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг шинэчлэн баталж, мөрдөх хүртэл хугацаанд цагдаагийн байгууллага үргэлжлүүлэн гүйцэтгэнэ” гэж заасан нь өнөөгийн байдлаар энэ хяналтын арга хэмжээг цагдаагийн байгууллага явуулж байна.

Харин хорих болон хорихоос өөр төрлийн ял эдэлж буй этгээдэд нийгэмшүүлэх чиглэлээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага ажиллаж буйг хэлэх хэрэгтэй.

Монгол Улсад гэмт хэрэг, хэв журмын зөрчил гаргасан этгээдийг сайн дурын үндсэн дээр нийгэмшүүлэх ажилд төрийн бус байгууллагууд илүү идэвхитэй тодорхой чиглэлээр хэрэгжүүлж эхэлсэн нь практикаас харагдна. Нөгөө талаар албан ёсны сайн дурын байгууллага, хөтөлбөр, эрх зүйн зохицуулалтыг улам сайжруулах шаардлагатай нь ажиглагдана.

Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албадын хэмжээнд хоригдогсдыг нийгэмшүүлэх чиглэлээр орон нутаг дахь болон төрийн, төрийн бус байгууллагатай албан ёсны хамтын ажиллагааны гэрээ байгуулж ажиллаж байна. Жишээлбэл: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тогтоол гүйцэтгэх газар, “Жавзандамба хутагт” төвтэй хамтран ажиллах талаар гэрээ байгуулсан бөгөөд хоригдогсдод ардын уламжлалт зан үйлийн зөв төлөвшил, ухамсар бий болгоход чиглэсэн арга хэмжээг хамтран хэрэгжүүлэх, энэ чиглээрхи орчныг бий болгоход дэмжлэг үзүүлэхээр ажиллаж байна.

Гэхдээ эдгээр төрийн бус байгууллага нь гэмт хэрэг, зөрчил гаргасан этгээдийг хариуцан нийгэмшүүлэх үйл ажиллагааг бүхэлд нь бус зөвхөн өөрийн үйл ажиллагаанд хамаарах хэсгээр туслалцаа үзүүлэн ажиллаж байна.

Дээр дурьдсан байгууллагаас гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэх ажлыг албан ёсоор шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, цагдаагийн байгууллага хариуцан явуулж байна. Өөрөөр хэлбэл гэмт хэрэг хийсэн этгээдийг шүүхийн шийдвэрээр ял эдэлж буй хугацаанд нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, харин ялаас суллагдахад нь цагдаагийн байгууллага хяналтанд авч, туслах буюу нийгэмшүүлэх үйл ажиллагаа хийгдэж байна.

Нэг. Цагдаагийн байгууллагаас хийгдэж буй захиргааны хяналтын талаархи өнөөгийн байдал. Цагдаагийн байгууллагаас хорих ял эдлээд суллагдсан зарим хүнд захиргааны хяналт тавьж буй нь захиргааны урьдчилан сэргийлэх албадлагын дотор онцгой байр эзэлнэ.

Хорих ял эдлээд суллагдсан бүх хүнд биш, Монгол Улсын эрүүгийн хуульд заасан тодорхой төрлийн гэмт хэрэг үйлдэх хорих ялаар шийтгэгдээд суллагдсан зарим хүнд энэ хяналтыг тогтооно.

Хорих ял эдлээд суллагдсан зарим хүнд захиргааны хяналт тогтоох нь тухайн хүнийг засарч хүмүүжихэд нөлөө үзүүлж, дахин гэмт хэрэг үйлдэж, нийгмийн хэв журам зөрчихөөс урьдчилан сэргийлэхэд чиглэнэ.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 177 дугаар зүйл “Зандалчлах”, 188 дугаар зүйл “Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, хар тамхи, мансууруулах буюу хордуулах, цацраг идэвхт, тэсэрч дэлбэрэх бодисыг хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлэх”, 179 дүгээр зүйл “Нийтийн эмх замбараагүй байдал бий болгох”, 91 дүгээр зүйл “Хүнийг санаатай алах”, 96 дугаар зүйл “Хүний биед хүнд гэмтэл санаатай учруулах”, 124 дүгээр зүйл “Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах”, 126 дугаар зүйл “Хүчиндэх”, 125 дугаар зүйл “Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах”, 145 дугаар зүйл “Бусдын эд хөрөнгийг хулгайлах”, 147 дугаар зүйл “Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх”, 148 дугаар зүйл “Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах”, 181 дүгээр зүйл “Танхайрах”, 192 дугаар зүйл “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах”-д заасан гэмт хэрэгт 5-аас дээш жил хорих ял эдэлсэн, эсхүл түүнийг давтан үйлдсэн хүн хорих ял эдэлж суллагдсан бол захиргааны хяналт

тогтооно⁷³.

Цагдаагийн байгууллагаас захиргааны хяналтыг тавих нэг хэлбэр нь тухайн этгээдэд зөвлөгөө өгч, уул хяналт тогтоогдсон хүнтэй олж мэдсэн мэдээлэл, түүний талаархи тодорхойлолтондоо түшиглэн ярилцлага хийх явдал юм.

Ярилцлагыг тухайн этгээдэд цагдаагийн ажилтан миний амьдрал ахуйд үнэхээр санаа тавьж туслахыг хүсч байгаа юм байна, энэ захиргааны хяналт нь намайг гэмт хэрэг, хэв журмын зөрчил үйлдэхгүй болгоход туслах юм гэж итгэн үнэмшүүлэх өнгө аясаар хийх нь зүйтэй.

Ийнхүү зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх явцдаа уг хүний хувийн байдал, тухайлбал, түүний зан төлөв, соёл боловсролын түвшин, үзэл бодол, амьдралын сонирхол, тухайн нөхцөл байдлаа үнэлэн цэгнэх чадвар, цаашид юуг анхаарах, яаж илүү нөлөөлж болох зэргийг тодруулан мэдэж боломжтой юм.

Нөгөө талаар захиргааны хяналт тогтоогдсоноор миний оршин суугаа газар гэр орондоо болон ажил дээрээ биеэ хэрхэн авч яваа, хийж байгаа сайн, муу зүйлийг цагдаагийн байгууллага мэдэж байна гэсэн ойлголт төрүүлэхүйцээр хяналт тавих, ярилцлага явуулах нь илүү үр дүнд хүрэхийг үгүйсэхгүй.

Үүнээс гадна нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын төлөөлөгч, байцаагч, хэв журмын болон урьдчилан сэргийлэх албаны ажилтан, эргүүл, харуулын цагдаа хэн нь ч болов хариуцсан газартаа оршин суугаа захиргааны хяналтанд байгаа хүнээ мэддэг, тэдний гэр бүл, ойр дотны хүмүүс, төрөл төрөгсөдтэй нь уулзаж ярилцдаг, ажиллах, амьдрахад нь хуульд заасан дэмжлэг үзүүлдэг, буруу муугаар нөлөөлж буй хүчин зүйлийг арилгах, уруу татах хүнээс нь салгахад нийгэм, хамт олны хүч бололцоог дайчлан ашиглаж байх нь захиргааны энэ хяналтын үр нөлөөг дээшлүүлэхэд сайнаар нөлөөлнө.

Нийгмийн болон гэмт хэргээс урдчилан сэргийлэх эдгээр арга хэмжээ нь хяналт тогтоогдсон хүнийг хүмүүжүүлэхэд чиглэгдэхээс бус, түүний нэр хүндийг гутаах, эрх, эрх чөлөөг нь байнгын хязгаарлагдмал мэт байлгах, албадлагаар айлган сүрдүүлэхтэй ямар ч холбоогүй болохыг тэдгээрт сайтар ойлгуулбал зохилтой.

Захиргааны хяналт тогтоогдсон хугацаанд засрал хүмүүжлээ олоогүй, цаашид захиргааны хяналтыг үргэлжүүлэх шаардлагатай гэж үзвэл уул хяналтын хугацааг нь хуульд зааснаар 6 сараас 1 жил хүртэл хугацаагаар сунгаж болно. Харин нийт хугацаа нь уг этгээдийн ял шийтгэлгүйд тооцох хуулийн хугацаанаас хэтэрч болохгүй.

Одоогийн байдлаар цагдаагийн байгууллагад хорих ял эдлээд суллагдсан захиргааны хяналт тавигдаж буй этгээдийн тоон мэдээг 3 жилээр нь авч үзвэл 2012 онд 2573, 2013 онд 4067, 2014 оны 10 сарын байдлаар 3045 этгээд хяналтанд байгаа ажээ.

Хоёр. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ялтанг нийгэмшүүлэх ажиллагаа. “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль⁷⁴”-д “тогтоол гүйцэтгэх газрын чиг үүрэг”-ийн хүрээнд “Баривчлах, хорих ял эдлүүлэх талаар хорих байгууллага дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ” гэж заагаад 8.2.3-д “ялтанд хүмүүжлийн нөлөө үзүүлэх”, 123 дугаар зүйл “Хүмүүжлийн ажил”, 124 дүгээр зүйл “Хүмүүжлийн ажлын хэлбэр, зохион байгуулалт”, 125 дугаар зүйл “Хорих анги дахь сургалт”, гэж заасан нь хорих ял эдэлж байгаа этгээдийг нийгэмшүүлэхтэй шууд холбоотой юм.

Мөн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хорих ял эдэлж буй этгээдийг нийгэмшүүлэхдээ “Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын заавар”-ыг дагаж баримтлан үйл ажиллагаагаа явуулж байна.

Энэхүү зааврын зорилго нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харъяа Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албанд ял эдэлж байгаа ялтан болон цагдан хоригдож байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээг

⁷³ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. Код 601. Хорих ял эдлээд суллагдсан зарим хүнд захиргааны хяналт тогтоох.

⁷⁴ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 8 дугаар зүйл. ТМ-2002 №8

тодорхой түвшинд хүргэх замаар хоригдогч нийгэмших, тэдгээрт нийгэм, сэтгэл зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх тогтолцоог бий болгоход оршино.

Хорих ангид үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээ нь дараах чиглэлээр явуулдаг.

- Ял эдлэх болон хоригдох явцад тулгарч буй нийгэм, сэтгэл зүйн болон орчны хүчин зүйлээс шалтгаалсан бэрхшээлийг даван туулахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх

- Нөхцөл байдалд үнэлгээ хийж, тэдгээрийг чадваржуулах, хувь хүний давуу тал, нөөц боломжийг нээн хөгжүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах

- Сөрөг зан үйл, хандлагыг өөрчлөхөд чиглэгдсэн нийгмийн ажлын нөлөөлөл үзүүлэх

- Өөрийгөө чадавхижуулах баг, төрийн бус байгууллагын оролцоог хангах

- Хуулиар хориглоогүй эрхийг хангах

- Нийгэмд суллагдан гарахад нь бэлтгэх, нийгмийн харилцаанд ороход сэтгэл зүйн болон эрх зүйн дэмжлэг үзүүлэх гэх мэт.

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрүүгийн хуульд нийт 225 үйлдлийг гэмт хэрэгт тооцсон байдаг бөгөөд үүнийг үндсэн, хүндэрүүлэх, онцлон хүндэрүүлэх байдлаар задалбал 449 үйлдлийг гэмт хэрэгт тооцож ял оногдуулж байгаа бөгөөд үүний 330 зүйлд хорих ялыг үндсэн ялын чанартай оногдуулахаар заасан. Эндээс харахад хорих ялыг илүү хэрэглэж байна гэж үзэж болно. Тухайлбал УДШ-ийн 2010-2012 статистик судалгаагаар нийт гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийн 75-77 хувьд нь хорих ял оногдуулсан нь харагдана.

Мөн хорихоос өөр төрлийн ялтай буюу торгох ялтай 60 гаруй, эд хөрөнгө хураах ялтай 130, албадан ажил хийлгэх ялтай 50, тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах ялтай 570 иргэн байна. Нийт 800 орчим иргэн хорихоос өөр ял эдэлж байна.

Одоогийн байдлаар 3515 хүн давтан ял эдэлж шийтгүүлсэн ба эдгээрийн 51 хувь нь 2-11 удаа хоригдсон, давтан гэмт хэрэг үйлдэгчдийн 1001 буюу 31.1 хувь нь хулгай, 675 буюу 21 хувь нь санаатайгаар бусдын амь насыг хохироосон, 366 хүн бусдын эд хөрөнгийг дээрэмдсэн гэх зүйл ангиар ял эдэлж байна. Давтан гэмт хэрэг үйлдэгчдийн хувьд хугацаанаас өмнө суллагдах, тэнсэн харгалзах ял авах, магадланд орох, дэглэм бууруулах боломж үгүй, оноосон ялыг биечлэн эдэлж байж суллагддаг аж. Мөн Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс хийсэн судлагаанд 2000-2009 оны гэмт хэрэгт урьд шүүхээр ял шийтгэгдсэн этгээдийн дахин гэмт хэрэг үйлдсэн талаархи тоон судлагааг авч үзжээ. Энэ нь Монгол Улсад гэмт хэрэг үйлдсэн нийт хүмүүсийн 10 хувийг эзэлдэг талаар дурьджээ⁷⁵.

Тиймээс ял эдэлж буй хоригдлуудыг нийгэмшүүлэх, тэднийг эргэн шоронд орохгүй байх тал дээр нь онцгой анхаарах нь зүйн хэрэг болов уу.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь суллагдах ялтныг нийгэмшүүлэх чиглэлээр ажлын байраар хангах зорилгоор Хөдөлмөрийн газартай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний үндсэн дээр хорих анги, шийдвэр гүйцэтгэх албадуудад хөдөлмөрийн газрын мэргэжилтнүүдтэй хамтран “Ажил мэргэжлийг хэрхэн сонгох” сэдвээр сургалт, зөвлөгөөг зохион байгуулж байна. Суллагдсан ялтныг хүлээн авч эрх чөлөөт амьдралд бэлтгэх зорилгоор:

- Иргэний бичиг баримтжуулах
- Ажлын байраар хангах
- Суллагдахаас 6 сарын өмнө судалгаанд авч, чөлөөт нийгэмд гарахад нь бэлтгэх төлөвлөгөө гарган мэргэжлийн болон бусад сургалтанд хамруулах

⁷⁵ Шоронгоос суллагдсан хүмүүст нийгэмд дассан зохицоход дэмжлэг үзүүлэх бодлого боловсруулах нь. Хууль зүйн үндэсний хүрээлэн. Судалгааны тайлан. (2010-2011)

- Суллагдаад бие даан амьдрах чадвар эзэмшүүлэх, хууль сахин биелүүлэгч, зөв хандлагатай иргэн болгон төлөвшүүлэх ажлыг эрчимжүүлэх, сургалт, нөлөөллийн ажлыг орон нутаг дахь засаг захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулах ажил хийгдэж байна.

Ялтныг хөдөлмөрлүүлэх хүрээнд: Хорих ял эдлэгсдийг хөдөлмөрлүүлэх, тэднийг ажлын байрын нэмэгдүүлэх асуудал тус байгууллагын шийдвэрлэвэл зохих арга хэмжээний нэг юм. Ялтныг хөдөлмөрлүүлэн, гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх чиглэлээр 2012 оны эцсийн байдлаар төлбөртөй нийт 2834 ялтан 91.237.922.2 мянган төгрөгний төлбөр төлөхөөс 490 ялтан 4.425.166.8 мянган төгрөгийн төлбөр төлөн, 2344 ялтны 86.812.755.4 мянган төгрөгний төлбөр төлөгдөөгүй байна.

Иймээс ялтныг ажлын байраар хангах асуудлыг тодорхой үе шаттайгаар шинэ шатанд гарган, гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх ажиллагааг эрчимжүүлэх, хорих байгууллагын дотоодын үйлдвэрлэлийн үйл ажиллагааг өргөжүүлэх асуудал чухлаар тавигдаж байна.

Гурав. Ялтанг нийгэмшүүлэх талаархи олон улсын туршлага. Сүүлийн жилүүдэд олон нийтийн дунд нийгэмшүүлэх асуудал маш их анхаарал хандуулсан сэдэв болж байна. Тухайлбал “Олон улсын засан хүмүүжүүлэх, хорих байгууллагын холбоо”-ны (International Corrections and Prisons Association) 15 дугаар бага хуралдаанаар “Энгийн амьдралын тухай бодох” буюу “**Thinking Outside the Cell**” гэсэн сэдвээр зохион байгуулжээ.

Мөн 2014 оны 16 дугаар бага хурлаар “Ялтанг нийгэмшүүлэх: Зорилгыг өөрчлөх” буюу “**From incarceration to Reintegration: Change with a Purpose**” зэрэг асуудлуудыг дэвшүүлэн гаргаж хэлэлцүүлжээ⁷⁶.

Гадаадын зарим улс оронд тухайлбал Япон улсад 48,000 “Сайн дурын харгалзах ажилтан” буюу “Volunteer Probation Officer” ажилладаг ажээ. 2014 онд Япон улсад энэ чиглэлээр Азийн болон бусад улс орнуудын сайн дурын нийгэмшүүлэх ажилтныгууд залт зохион байгуулагдсан.

Мөн БНСУ-д сайн дурын харгалзах, хүмүүжүүлэх ажилтны хууль ёсны нэр нь одоогоор “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сайн дурын хорооны гишүүн” буюу “**a member of Crime Prevention Volunteer Committee**”⁷⁷ гэж нэрэлдэг байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сайн дурын хорооны чиг үүрэг нь гэмт хэрэг, хэв журмын зөрчил гаргасан этгээдийг батлан дааж, тухайн этгээдийг нийгэмшүүлэх чиглэлээр тусламж, дэмжлэг үзүүлдэг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, явдал юм.

Дээр дурдсанчлан сайн дурын ажилтны гол зорилго нь гэмт хэрэгтэнд дэмжлэг үзүүлэх явдал бөгөөд удирдаж хяналтандаа байлгаж, санаа тавих, өөрөөр хэлбэл энгийн амьдралд нь эргэн оруулах, нийгэмшүүлэх явдал юм.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сайн дурын зөвлөлийн гишүүдэд дараахь шаардлага, шалгуур хангасан иргэнийг 3 жилийн хугацаатай томилдог байна.

1. Тэдний зан чанар, ёс зүй нь нийгэмд найдвартай хүмүүс
2. Нийгмийн үйлчилгээний төлөө тууштай хандах хандлагатай хүмүүс
3. эрүүл, идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг хүмүүс
- 4 Засгийн газрын албан ёсны ажилд авахад тэнцэх хүмүүс

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сайн дурын зөвлөлийн гишүүд дараахь үйл ажиллагааг явуулна.

1. гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийг татан оролцуулах

⁷⁶ <http://www.icpa.ca/news-icpa/>

⁷⁷ The volunteer probation officer system in korea. Woo Sik Chung.
http://www.unafei.or.jp/english/pdf/RS_No61/No61_19VE_Chung2.pdf

2. гэмт хэрэг, хэв журмын зөрчил гаргасан этгээдэд зөвлөгөө өгөх
3. ажлын байрны олдоц, санхүүгийн тусламж, гэмт хэрэгтэнд туслалцаа үзүүлэх
4. Хууль зүйн яамнаас зохицуулдаг холбогдох бусад асуудлыг дагаж мөрдөх гэх мэт үйл ажиллагааг нийгэмшүүлэх ажлын хүрээнд хийгддэг.

Дөрөв. Ялтанг нийгэмшүүлэх цаашдын чиг хандлагыг тодорхойлох нь.

Монгол Улсад дээр дурьдсан байгууллагуудын үйл ажиллагаанаас өөр гэмт хэрэг, зөрчил гаргасан этгээдийг нийгэмшүүлэх чиглэлээр албан ёсны, системтэй хийгдэж буй үйл ажиллагаа төдийлөн практикт харагдахгүй байна.

Монгол Улсад УИХ-аас 1998 онд эрх зүйн шинэчлэлийн стратеги бодлогын баримт бичиг батлагдаад нэлээд олон жил өнгөрөөд байна. Энэ хугацаанд манай улс нийгмийн хөгжлөөсөө хамаараад эрх зүйн зарим шинэтгэл хийгдсэн ч бүрэн хангалттай биш бөгөөд энэхүү баримт бичгийг шинэчлэх шаардлагатайг нийгэм харуулж байна.

Засгийн газрийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт хууль зүйн бодлогыг шинжлэх ухааны үндэстэй, хүний эрх, эрх зүйт ёсны зарчимд нийцүүлэх механизмыг бий болгохоор заасан ба уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд эрх зүйн шинэтгэлийн баримт бичиг боловсруулах зорилт тавьсан нь биелэлээ олж эхэлжээ.

Засгийн газраас хууль зүйн салбарт 2012-2013 онд шүүх, шүүгч, хуульчийн эрх зүйн байдлыг сайжруулсан хуулиудыг УИХ-аар батлуулсан. Харин одоо хууль сахиулагчдийн эрх, үүрэг, харилцан уялдааг тодруулсан зохицуулалт, зохион байгуулалтын талаархи хуулийн төсөл хийгдэж хэлэлцэгдэхээр бэлэн болсон байна.

Хууль зүйн цогц бодлогын хүрээнд шинээр боловсруулах болон шинэчлэн найруулах хуулийн төслүүд: “Хууль сахиулах үйл ажиллагааны тухай”, “Гэмт хэрэг хянан шийдвэрлэх тухай”, “захиргааны зөрчлийн тухай”, “Гэмт хэргийн тухай”, “Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай”, “Мөрдөх албаны тухай”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай”, “Хилийн тухай” гэх мэт хуулиудад шинээр боловсруулах болон нэмэлт өөрчлөлт оруулахаар тусгагджээ.

Эдгээрээс үзэхэд Монгол Улсад сайн дурын харгалзах ажилтан буюу “Volunteer probation Officer”-ийг бий болгох боломжтой бөгөөд эдгээр эрх зүйн зохицуулалтай уялдуулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, цагдаагийн байгууллага хамтран гэмт хэрэг, хэв журмын зөрчил гаргасан этгээдийг нийгэмшүүлэх ажлыг хийх бололцоотой гэж судлаач бивэр үзэж байна.

Жишээлбэл шинэчлэн найруулсан “Цагдаагийн албаны тухай хууль⁷⁸”-д “олон нийтийн цагдаагийн ажилтан” гэсэн нэр томъёог оруулж, гэмт хэрэг, хэв журмын зөрчилтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах сайн дурын иргэдийг бий болгож цагдаагийн байгууллагатай хамтран ажиллуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгосон юм.

“Цагдаагийн албаны тухай хууль”-д заасан олон нийтийн цагдаагийн ажилтны эрх зүйн байдлыг нарийвчлан, “Олон нийтийн цагдаагийн ажилтны дүрэм⁷⁹”-ийг ЦЕГ-ын даргын тушаалаар баталж мөрдүүлэв. Энэхүү дүрмээр олон нийтийн цагдаагийн ажилтан цагдаагийн байгууллагатай харилцан гэрээ байгуулж үйл ажиллагаагаа явуулна.

Эцэст нь дүгнэн хэлэхэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай хамтран сайн дурын олон нийтийн хүмүүжүүлэх ажилтанг ажиллуулж болохоор харагдана. Харин тэгэхийн тулд “Сайн дурын харгалзах (засан хүмүүжүүлэх) ажилтан” буюу “Volunteer Probation Officer”-тэй холбоотой харилцааг зохицуулах хууль, хууль тогтоомж, хөтөлбөрийг батлуулан ажиллаж болох юм.

⁷⁸ Цагдаагийн албаны тухай хууль. 2013 он. ТМ 2013, №29

⁷⁹ “Олон нийтийн цагдаагийн ажилтны дүрэм”. ЦЕГ-ын даргын 2014 оны тушаал.

ТУСГАЙ БЭЛТГЭЛТЭЙ БҮЛГИЙН МЭРГЭН БУУДАГЧ, ТҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ



Д.Мөнхжаргал
ХСИС-ийн ЦС-ийн Галын бэлтгэл тусгай тактикийн
тэнхимийн багш магистр,
цагдаагийн ахмад

Хууль сахиулах байгууллагын мэргэн бууч нь цэргийн тусгай хүчний үүсэн байгуулагдсанаас эхлэлтэй. “Снайпер” буюу мэргэн буудагч гэдэг нь английн snipe буюу сараалжин шувуу гэдэг үгнээс гаралтай. Сараалжин шувуу нь маш хурдан нисдэг, мөн нислэгийн шугам нь урьдчилж хэлэхийн аргагүй ер бусын байдаг тул анчдын хувьд тун ч хэцүү олз байв.

Жирийн буугаар сараалжин шувууг буудаж чадсан ямар ч англи хүнийг тун ч оновчтой буудагч хэмээн тооцдог байлаа. “Сараалжин шувууны буудлага” нь сүүлдээ спорт маягийн төрөл болон өргөжив. 18-р зууны дунд үед энэ төрлийн спортын нэр нь товчлогдож snipe shooting гэдэг урт нэр нь товчхоноор sniping гэж нэрлэгдэх болжээ.

19-р зууны сүүлээр энэхүү нэр томъёо нь өдөр тутмын үгийн санд нэвтэрч маш оновчтой бууддаг спортын төрлийг заадаг болов. 19-р зууны дунд үе хүртэл ихэнх буунууд нь гулгамтай иштэй байсан нь хол, оновчтой буудах боломжийг хааж байлаа. Буудлагын спортын хамгийн түгээмэл хэлбэр мушкетын байг оновчтой онох хамгийн хол зай нь 80 бээр буюу 73.2 метр байлаа.

Мушкет бууг үйлдвэрлэх болсон гол хөшүүрэг нь дахин цэнэглэхэд хурдан, мөн ойрхон зайнд галтай бууддаг боломжтой явдал билээ. Хэдийгээр мухар буунуудыг 16-р зуунд хэрэглэх болсон ч тэднийг үйлдвэрлэхэд их урт хугацаа шаарддаг, өндөр өртөгтэй байжээ.

Анчны буунуудыг анх Английн иргэний дайны /1642-1648/ үеэс байлдааны зориулалтаар хэрэглэж эхэлсэн. Мэргэн буудагчид холын зайнаас дайсны армийн офицеруудыг хөнөөдөг болов. 1643 оны гуравдугаар сард Личфилд хотын бослогын үеэр Брук гүнгийн армийн даргыг холоос буудсан явдал олныг донсолгов.

Сүмийн дээвэр дээр харуулд гарч байсан төгөлдөр хуурч, цэрэг Жон Дайот ангийн урт буугаа тэврэн манаанд гарч байжээ. Гүнг нуувчнаас дөнгөж цухуйхад тэр анаж байгаад буудаж орхисон аж. Дайот гүнгийн зүүн нүдэнд нь оносон байна.

Тэр үеийн жишгээр 150 бээр /137.2 метр/-ийн зайнаас гөлгөр иштэй урт ангийн буунаас буудсан явдал нь дээд зэргийн гайхамшигтай явдалд тооцогдож байв. Аж үйлдвэрийн хувьсгалын эхэн үеэс бууны үйлдвэрлэл ихэд дэлгэрсэн ч 18-р зууны сүүл хүртэл Европын тэргүүний армиудын хурандаа нар “Буу бол дайныг хийхэд тийм ч үр ашигтай зэвсэг биш” гэж үзэж байв.

Британийн эзэнт гүрэн хийгээд Хойд Америкийн колончлогчдын хооронд дайны мөргөлдөөн эхлэхэд нөхцөл байдал бүрмөсөн өөрчлөгджээ.

АНУ-ын эхэн үеийн түүхэнд Европоос ирж суурьшигчид болон уугуул Индианчуудын хооронд тэмцэл зөрчилдөөн байсан бөгөөд Европчуудын хувьд Индианчууд үндэстэн биш гэсэн ойлголттой байжээ.

Тэд үнэндээ өвөг дээдсээс уламжлагдан ирсэн газар нутаг дээр тархан суурьшсан жижиг овог аймгуудын төлөөлөл байжээ. Тэдгээр овог аймгууд хоорондоо ан хийх газар нутгийн төлөө эсвэл өөрсдийн эзэмшлийн эд баялагт газар нутгаа хамгаалахын төлөө тулалддаг байсан байна.

Индианчуудын тактик нь зарим талаараа отох урхи тавих, агнах, ажиглах зэргийг үйлдлийг багтаасан тэдний ан хийх тактиктэй төстэй байжээ. Индианчуудын

хувьд том хэмжээний тулааны бүлэг арми болон зохион байгуулалтад орно гэдэг энгийн хэрэг биш байлаа.

Индианчууд шургах дайрах эсрэг үйлдэл ирэхээс өмнө бултахдаа авьяастай хүмүүс байжээ. Мөн тэд арга заль ихтэй өнгөлөн далдлах ур чадвар сайтай мөн газар нутаг, байгалийн зүй тогтолыг маш сайн ашигладаг байсан байна.

Тэдний арга техник нь эртний америкчуудын агнаж бас эрхэмлэдэг байсан ан амьтнаас үүсэлтэй зодолдох ур чадвартай зарим талаараа төстэй байв.

АНУ-ын Колонийн үйл явцын үр дүнгээр буу зэвсгийн дарханчууд олноор бий болсон бөгөөд тэд маш эвтэйхэн зэвсэг бүтээсэн нь тухайн цаг үедээ шинжлэх ухаан техникийн орчин үеийн зэвсэг болж чаджээ.

Дайчин удирдагчид Британы цэргийг туйлдуулахдаа иргэний мэргэн буучдын түргэн шуурхай дайралтыг хэрэглэсэн байна.

Үүнээс хойш АНУ болон Европд мэргэн буудагчдын хөгжил анчдын хүрээнд явагдаж ирсэн ба тэдгээр нь мэргэн буудагчийн винтов буу болон тэдгээрийг эзэмшигчдийг боловсронгуй болгож бэлдэж ирсээр дэлхийн томоохон дайнуудад чухал үүрэг гүйцэтгэж ирсэн. Тухайлбал: Дэлхийн I дүгээр дайн, Орос Финландийн дайн, дэлхийн II дугаар дайн, Солонгосын дайн зэрэгт мэргэн буудагчдыг маш өргөнөөр ашиглаж байсан ба энэ л үед тухайн цаг үеийн шилдэг мэргэн буудагчид төрөн гарж ирсэн билээ.

Вьетнамын дайнд АНУ-ын тусгай анги нэгтгэлд мэргэн буудагчдыг тусгайлан бэлдэн оролцуулж байсан ба тэдгээрийн гүйцэтгэх үүргийн дийлэнх нь явган цэргийн эсрэг үйл ажиллагаа нь явагдаж байсан.

Дэлхийд алдартай мэргэн буудагчийн винтов болох СВД нь Вьетнамын дайн, Афганистаны дайн (1979-1989), Иракийн дайн, Югославын дайн, Чеченийн 1, 2-р дайн, Карабахын зэвсэгт мөргөлдөөн, Гүрж-Абхазын зэвсэгт мөргөлдөөн зэрэг томоохон тулаанд ашиглаж байсан байна.

Энэ үеэс дэлхийд өнөө цагын голлох дайны харанга болох террорист бүлгүүдийн үйл ажиллагаа эхэлсэн ба улс орнууд өөрсдийн эсрэг аюул заналхийлэл халдлаг явуулж буй зэвсэгт бүлэглэл, зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн эсрэг тэмцэх маш өндөр сахилага бат, бэлтгэл сургуулалтай тулааны урлагыг нарийн эзэмшсэн цөөхөн тусгай алба хаагчдаар тэмцэх болсон бөгөөд тэдгээрийн шилдэгүүд нь мэргэн буудагч нар байсан ба голлох үүрэг гүйцэтгэдэг.

Дэлхийн жишиг тусгай алба болох “Альфа” ОХУ, “SEAL TEAM” АНУ, SAS ИБНВУ GSG-9 ХБНГУ, URNA БНЧУ гэх мэт олон шилдэгүүдийн зэвсэглэл, техник хэрэгсэл нь өндөр чанар, найдвартай ажиллагаатай байх нь дайны тулаан тэр дундаа тусгай ажиллагаанд маш их чухал байдаг.

Учир нь маш их өндөр өртөг, зардал, хүн хүч, цаг хугацаа зарцуулж бэлдсэн тусгайгын алба хаагчдийн цусаар бичигдсэн байдгыг тэр болгон олон нийт тэр дундаа улс төрчид мэддэггүй юм.

Дээрх улсуудын засгийн газар тусгай хүчинд хэзээч гар таталгүй хаана, аль улс оронд, ямар зэвсэг, техник хэрэгсэл, хувцас тусгай хэрэгсэл зэргийг шинээр бүтээж, сайжруулж байгааг соргоогоор хүлээн авч туршиж албанд ашиглаж байгааг анхаарах нь та бүхэнд илүүдэхгүй боловуу.

Манай улсад анх цагдаагийн байгууллагад хурандаа Ц.Уугангэрэл даргын санаачилгаар 1990 оны 5 дугаар сард Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар “III Тусгай тасаг” нэртэйгээр 3 бүлэг, 6 хэсэгтэй байгуулагдаж хэсэг тус бүр нь нэг мэргэн буудагчтай байсан ба зэвсэглэлд СВД мэргэн буудагчийн буутай үүрэг гүйцэтгэж байсан түүхтэй.

Энэ цаг үеэс өргөжин хөгжиж 2005 онд “ЦЕГ –ын Тусгай хэлтэс” болон өргөжин мэргэн буудагчийн дарга, бүлгийн мэргэн буудагч алба хаагч нар байсан ба анх удаа Монгол улсын хүчний байгууллага тэр дундаа цагдаагийн тусгай албанд

гуравдагч гүрний мэргэн буудагчийн зэвсэг болох АНУ-ын Цагдаа, тусгай албадын хэргэлдэг галт зэвсэг орж ирсэн нь анхдагч байсан юм. 2013 оны 5 сард мэргэн буудагчийн бүлэг байх шаардлагагүй гэж үзэн тараан довтолгооны бүлэгт мэргэн буудагч алба хаагчдыг хувиарлан орон тоог нэмсэн ба урд урдын зэвсэглэл дээр бага боловч мэргэн буудагчийн зэвсэг, хэрэгсэл нэмэгдсэн нь олзуурхууштай байна.

Мэргэн буудагчаар тусгай албанд ан хийдэг, буудлагын спортоор хичээллэдэг, буудлагын барил болон туршлагатай хүмүүсийг сонгож мэргэн буудагчаар бэлтгэж ажлуулах нь цаг хугцаа болон хөрөнгө мөнгө, хүн хүчинд хэмнэлттэй байв. Учир нь тэд холбогдох дадал арга барил эзэмшсэн сэтгэл зүйн хувьд бэлтгэгдсэн байх ба энэ нь маш чухал үзүүлэлт юм.

Өнөөгийн байдлаар мэргэн буудагчдийн гүйцэтгэж байгаа үүргээс цухас дурдвал багаар болон дангаар үүрэг гүйцэтгэж байгаа ба багаар бол нэг нь буудагч нөгөө нь хянагчийн үүрэг гүйцэтгэх ба багийн гишүүд хэн хэнийхээ үүргийг орлон гүйцэтгэх чадвартай байх шаардлагатай гадны туршлагаас үзхэд илүү ур чадвар мэдлэг сайтай нь хянагчийн үүрэг гүйцэтгэдэг. Гэмт үйлдэл болсон үед нэн ялангуяа хүн барьцаалахтай холбоотой мэргэн буудагчийн үүрэг, цар хүрээ асар их юм.

Буудагчийн үүрэг бол гал нээх бол хянагч нь олон тооны үүрэг гүйцэтгэнэ. Тухайлбал хянагч байг ажиглах, агаар орчины хэмжилт хийх, багийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй. Мөн дайралтын баг удирдлагад мэдээлэл дамжуулах, тэдгээрийн орц гарцыг галаар хамгаалах, тэсэрч дэлбэрэх бодистой ажиллах, тагнуул хийнэ, хамтрагчдынхаа маневр, шилжин байрлах хөдөлгөөнийг халхавчилна, хянагч нарыг хамгаалах, хэргийн газрыг бүслэн хамгаалах ажиллагааг хангана.

Буудагч дайрах бүлгийнхэнд хандуулж буй гэмт этгээдүүдийн анхаарлыг сарниулах, нууц ажиллагаанд саад болж буй нохой, гэрэлтүүлгийн хэрэгсэл, хяналтын камер зэрэг эсрэг талын хамгаалалтын хэрэгслүүдийг устгах олон үүргийг гүйцэтгэдэг.

Тушаал авсан тохиолдолд оновчтой буудалт хийж “аюулгүй болгох болон аюул”-ыг устгана. Чөлөөлөх ажиллагаа эхэлмэгц тэрээр дайрах бүлгийн ажиллагааг оновчтой галаар хамгаалж халхавч хийж галын алба, эмч нар болон бусад үйлчилгээний ажилтнуудын аюулгүй байдлыг хангах ёстой.

Мэргэн буудагч дайрах бүлгийн шилжих хөдөлгөөнийг зохицуулж, тэдний зам дахь занга, урхи, сэжигтэй этгээд болон бусад аюулаас сэрэмжлүүлдэг. Зарим тохиолдолд тэрээр дайрах бүлгийн хараанд өртөхөөргүй байрлаж, аюул занал учруулж болох сэжигтэй этгээдүүдийг устгана.

Гэмт этгээдүүдийг устгах тушаал авсан бол “бай”-г сонгохдоо түүний ач холбогдлынх нь дарааллыг баримтална. Гол төлөв хамгийн эхэнд нэн аюултай зэвсэг \автомат буугаар зэвсэглэсэн гэмт этгээд гар буугаар зэвсэглэснээсээ түрүүлж үхэх ёстой гэсэн зарчим баримталдаг\ барьсан “бай”-г устгана. Гэмт этгээдүүдийг устгахдаа тэдний эрүүгийн “түүх”-ийг үндэслэнэ. Эцэст нь барьцааныханд болон дайтах бүлгийнхэнд хэн илүү их аюул учруулж болохоор байна гэдэг зарчим баримтлана гэм зэмгүй хүмүүсийн дэргэд хамгийн ойр байгаа нь гэдэг ч юмуу.

Хянагч байг илрүүлж, ажиглан тогтоож өгөх бөгөөд буудлагын дүнг хянадаг төдийгүй тусгай чиглүүлэгчийн дурангаа ашиглан газар орны физик шинжүүд, газрын дулаанаас үүссэн зэрэглээ зэргийг ашиглан салхины чигийг тогтоодог.

Мөн буудагчтай харилцаж бай хүртлэх зайг тогтоон буудлагын өнцөг, баллистик, траектор, салхины хурд, газрын гадарга зэргийг тооцоолсны үндсэн дээр дуран харааны засварыг зааварчилж өгдөг.

Нэг үгээр хэлбэл хянагч нь гал нээхээс бусад бүх үүргийг гүйцэтгэдэг гэж тайлбарлаж болно. Өнөө үед хянагч нар тусгай баллистикийн тооцоолох программ бүхий зөөврийн компьютерийг ажиллагаандаа хэрэглэх нь нийтлэг болоод байдаг.

Хянагч нь ихэвчлэн багийн аюулгүй байдлыг хангадаг учир автомат буугаар зэвсэглэсэн байдаг.

Багийн гишүүн бүр мэргэн буудагчийн винтов буутай үед 2 зэвсэг зэрэг агсаж үүрэг гүйцэтгэдэг явдал бий. Гэвч ихэнх тохиолдолд мэргэн буудагчийн винтов бууг зөвхөн буудагчид олгодог учир дээрх мэт давхар зэвсэг агсах нь ховорхон байдаг.

Мэргэн буудагчдыг сонгохдоо түүний эрүүл мэнд, бие бялдрын хөгжилд онцгой анхаардаг. Алба хаагчид өндөр сахилга бат, ёс суртахуунтай, хариуцлага өндөртэй, мэргэшсэн чадварлаг, эр зоригтой, сэтгэл зүйн хувьд төлөвшсөн, харилцааны соёл зэрэг олон шалгуурыг хангасан байдаг.

Яагаад гэвэл мэргэн буудагч зарим үед хүн хүрэхэд маш хэцүү газар байрлах, тийшээ очиход түүнээс асар их хүч тэнхээ, ур ухаан, эв дүй шаардагддаг юм. Тэвчээр хатуужилтай байх нь мэргэн буудагчдын бас нэг гол чанар мөн.

Тэрээр үүрэг гүйцэтгэх үедээ сонгосон байрлалдаа хэдэн цагч суух \тэгэхдээ бараг хөдөлгөөнгүй шүү\ шаардлага гардаг. Ингэхдээ тэрээр хэрэгтэй ганцхан агшинд байгаа хөнөөх тийм чадварыг хадгалж байх ёстой.

Дэлхийн бусад улс орнуудад тусгай албаныхан мэргэн буудагч нараа дотроосоо, байлдааны туршлагатай болон анчдын дундаас сонгон авсан байдаг. Яагаад гэхээр тэдгээр хүмүүс нь холбогдох дадал олсон, туршлага суусан хүмүүс юм. Тэд хэрэгтэй үед эргэлзэж, тээнгэлзэхгүйгээр гохоо дарж чаддах сэтгэл зүйн бэлтгэлтэй байдаг юм.

Монгол улсад “Зэвсэглэсэн тусгай бэлтгэлтэй бүлэг” байх шаардлагатай юу? Хэрэв үгүй бол хууль сахиулах алба хаагчдын ур чадвар, хүч чадал, техник хэрэгсэл, зэвсэг, тусгай хэрэгсэл хүрэлцэхгүй хэрэг нөхцөл байдал бий болговол яах вэ? Засаг захиргаа, Улсын их хурал гадаад харилцаа маань дэлхийд тэргүүлэх хүчирхэг хоёр гүрэн болох ОХУ, БНХАУ –аас ил болон далдаар тусламж гуйх уу, тийм эрх зүйн орчин байна уу? Эсвэл БХЯ-ны харьяа 084-р ангийг хууль сахиулах ажиллагаанд татан оруулах шаардлагатай юу?

Хэрэв үгүй бол дээр өгүүлсэн дэлхийн хэмжээнд ойртуулах, одоогийн энэ техник, зэвсэг, тусгай хэрэгсэл болон мэргэн буудагч нарыг сургах бэлдэх багш, сургалтын орчин эдгээрийг нэн тэргүүнд бэлдэж бий болгохгүй юм бол гарах үр дагавар нь энгийн хүний амь, тусгай албаны ажилтан, цаашлаад төрийн ямар нэг өндөр албан тушаалтаны амь нас эрүүл мэндэд ноцтой хохирол учрах тийм бодит аюул нь цаг хугацаны асуудал болоод байна.

Тусгай албаны мэргэн буудагчийн үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар авах чухал арга хэмжээ нь бүтэц, орон тоо, албан хаагчдын үүрэг гүйцэтгэх эрх зүйн орчин, далд байх зарчим, нийгмийн баталгаа, техник хэрэгсэл, санхүүжилтийн талаар томоохон үе шаттай алхамууд хэрэгжүүлэх нь тулгамдаж буй асуудал болоод байна.

Дээр дурьдсан асуудлыг хуульд тусгах, журам, дүрэм, заавруудыг шинээр гаргах, ялгаж ангилах, системчлэх хэрэгтэй ба төрөөс санхүүгийн хувьд бодлогоор тасралтгүй байнга хангаж байх үүргийг хүлээж үүний зэрэгцээ хатуу хяналт тавих нь зүй юм.

Цаашид хурдацтай хөгжиж байгаа өнөөгийн нийгэмд мэргэн буудагчийн үйл ажиллагаанд орчин үеийн шинэ технологийг нэвтрүүлэн ашиглах, мэргэн буудагчийг мэргэшүүлэх сургалттай болгох, багаар ажиллах чадварыг дээшлүүлэх, мэргэн буудагчдын зэвсэг, сумны чанар, агсамж зэрэг олон зүйлсийг шинэчлэх, стандарттай болгох шаардлагатай байна.

МОНГОЛЧУУД ГАЗРЫН ЗУРАГ ХИЙЖ АШИГЛАЖ БАЙСАН НЬ



Г.Мөнх-өртөнц

ХСИС-ийн Хилийн сургуулийн, Цэргийн
хэргийн тэнхимийн эрхлэгч, дэд хурандаа

Бид газрын зургийг их төлөв бид Атлас гэж нэрлэн дасчээ. Атлас (Бас Атлант ч гэдэг) бол грекийн үлгэр домогт гардаг аварга биет тэнгэр бөгөөд одод, сансрыг бидний толгой дээр унагаад хагалчихгүй өргөж байх үүрэг хүлээдэг ажээ.

Их мөстлөгийн өмнөхөн Мексикийн буланд унасан эрхсийн асуудлыг хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэж тооцвол, түүнээс хойш гэм хор багатайхан солир унаж байгааг эс харгалзвал Атлас баатар үүргээ нэр төртэй биелүүлсээр иржээ.

Одот тэнгэрийн зургийг л нэрлүүштэй Атласын нэр газрын зурагт орсон нь нэлээд тохиолдлын чанартай.

1595 онд хэвлэгдсэн Герард Меркаторийн атласаас энэ нэр эхэлжээ.

Меркатор газрын зургийн номынхоо эхний нүүрийг Атлас баатрын зургаар чимэглэжээ.

Хэрвээ газар дэлхийг өргөж байдаг хэмээн Дорнын домогт өгүүлэх яст мэлхийн зургийг тэнд хэвлэсэн болж гэм өдгөө газар зүйн багш нар "Дэлхийн яст мэлхийн дээрээс Монгол орноо ч олж чадахгүй хэвтэж" гэж ирээд шавь нараа хангинах байж.

Хүмүүс орчин тойрноо, нутаг орноо нэн эртээс ямар нэгэн байдлаар зурж, төсөөлж иржээ.

Нэг овог, хошууны нутгийг зурах бол амархан байж. Харин тэдгээрийг нийлүүлж тив дэлхийн зураг бүтээх үнэхээр амаргүй.

Газрын зургийн түүх нэн эртээс улбаатай боловч дэлхий ертөнцөө хэрхэн зурах тал дээр тун саяхан буюу 1891 онд Швейцарын Берн хотод болсон дэлхийн газар зүйчдийн их хурлаар сая нэг тохиролцжээ. Энэ үеэс хойш газрын зураг нарийссан уу гэхээс биш, "өргөжөөгүй" аж.

Анхны шинжлэх ухаанч газрын зургийн түүх нь мөнөөх "Атлас" нэртийг гарахаас өмнө амьдарч байсан Александрын одон оронч, газар зүйч, газар зураглаач (картографч гэдэг үгийг ингэж орчуулбал ямар сонсогдож байна?) Птолемейтэй холбогдоно.

"Ертөнцийн төв"-өөс харж үйлдсэн олон бүтээл газрын зургийн түүхэнд байх ба түүний дотор XIV зууны хятадын газар зураглаач Чу Шибен гэсэн нэр олонтаа гарна.

Монголын хуучин хошууд өөрийн гэсэн нутгийн зурагтай байж, бас хилийн харуулууд ч хэрдээ нарийн гаргасан "атлас" хэрэглэдэг байсны зарим нь үлджээ.

Чухам эдгээр зургууд л XX зууны Монголын хил хязгаарыг шинэчлэн тогтоох үндсийн нэг болсон гэж учир мэдэх хүмүүс нь ярьдаг.

Монголын анхны газрын зургийг 1924 онд Лисовский гэдэг хүн үйлдсэн бололтой байдаг. Баатар цагаан хааны вед хөрс сайжруулах мэргэжилтнээр ирсэн энэ хүн Монголд удаан ажиллаж, газар зүйн хүрээлэнгийн үүсвэр мөхлөгийг өнөөгийн өндөрлөгөөс харахад болхидуу мэт боловч "хаанаас нь ч харсан газрын зураг" бүтээсэн байна.

Дараа нь 1930-аад оны эхээр "Симуковын ногоон зураг" хэмээх тухайн үедээ машид боловсронгуй бүтээл гарчээ.

Манайхны дунд "Шар Дамдинсүрэн" хэмээн алдаршсан Андрей Дмитриевич Симуков С.Зориг агсны өвөө гэдгийг хэлсэн хэлээгүй мэдэх байх даа.

Монголын хамгийн сайн, өндөр нарийвчлалтай зургийг мэдээж оросууд, мэдээж цэргийн зориулалтаар хийсэн байдаг. Үүнээс болоод ч юмуу, манай улсын хуулиар бол 25.000 ,100.000 .масштабтай зургуудыг ард түмэн үзэх ба мэдэх ёсгүй байдаг.

Та наад зах нь л гэхэд Францын Спот хиймэл дагуулын зургуудыг сонирхоорой. Хиймэл дагуулаас хүсвэл, машины дугаарыг ч харж болдог өнөө үед өмнөд хөршийн зөндөө дагуул дээгүүр нисч яваатай, улсын нууцлалд байгаа зургийн тухай мэдээллийг харьцуулаад нэг үзээрэй.

Газрын зураг цаашдаа хөгжлийн явцдаа хотын, замын гэхчлэн салбарлажээ. Автозамын гайгүй сайн зураг бол Адмон компаниас гаргасан "Монгол орны авто замын зураг юм."Симуковын ногоон зураг" дээр "Нэг сангтиметр дор 20 километр багтмуй" хэмээсэн байдаг бол дээрх замын зургийн нэг см-т 10 км багтчихуй.

Орчин үеийн хотыг түүний зураггүйгээр төсөөлөх аргагүй. Жуулчид аль ч хотод очмогцоо зургийг нь олж авдаг.Тэгээд түүгээр газарчаа хийж, түвэггүй аялж болдог.

Газрын зургийн ангилал харуулсан зураглал:

Дээр үеэс эхлэн газрын зураг гэдэг ойлголтыг хавтгай дээрх газрын гадаргыг багасгасан дүрс юм гэж тодорхойлон заншжээ. Энэ нь энгийн хялбар ойлгомжтой тодорхойлолт боловч агуулгын хувьд хангалтгүй ойлголт юм.

Учир нь байгалийн байдал , газрын гадаргыг дүрсэлсэн уран зураг , гэрэл зураг ч газрын багасгасан дүрс байдаг түүнчлэн зөвхөн газрын гадаргын дүрс гэж үзсэнээрээ агуулгын хувьд дутуу санаа байна.

Газрын үзүүлдэг элементүүдэд ус зүй, газрын хотгор гүдгэр , ургамал хөрс орно. Мөн газрын зурагт халуун хүйтэн агаарын даралт, хүн ам үндэсний бүрэлдхүүнийг харуулна. Ийнхүү дүрслэн үзүүлэхдээ газрын зураг нь дараах үндсэн шинжийг хадгалдгаараа уран зураг , гэрэл зураг зэрэг бусад газрын гадаргын дүрснээс ялгаатай байдаг.Үүнд: Ямар ч газрын зургийг зохиоход уг зургийн үндэслэл болох тооны онцгой хуулиар газрын гадаргын дүрсийг хавтгайд шилжүүлэн дүрслэх аргыг хэрэглэдэг нь газрын зургийн онцлог юм.

Газрын зургийн хоёр дахь шинж нь юмс үзэгдлийг таних тэмдгээр дүрслэх онцгой аргыг бас хэрэглэдэг.

Газрын зургийн гурав дахь шинж нь дүрсэлж байгаа байгалийн юмс үзэгдлийг сонгох ба ерөнхийлэх арга (генерализац) –ыг хэрэглэдэг нь юм.

Дээрх үндсэн шинжүүдийг үзэн газрын зургийн тухай нэгтгэн тодорхойлбол , Газрын зураг гэдэг нь байгаль ба нийгмийн үзэгдлүүдийг тооны тодорхой хуульд үндэслэн гадаргатай харьцангуйгаар хавтгай дээр үзүүлсэн дүрслэл юм.

Газар зүйн судлаачид газрын зургийг хүмүүсийн харилцааны хоёрдах хэл соёл гэж тодорхойлдог. Газрын зургийн тухай ойлголт нь хүмүүс орон зайн баримжаалал бий болох үеэс оюун санаанд бий болж хөдөлмөрийн багаж зэвсгийн өөрчлөлтийг дагаж бодит хэрэглэгдхүүн болж хөгжсөн. Газар зүйн шинжлэх ухаанд судалгааны ажил газрын зургаар эхэлж гарын зургаар дуусдаг ба бүх дүгнэлт үр дүн нь газрын зурагт тусдаг.

Эртний гүн ухаантнууд дэлхийн тухай ойлголт төсөөлөл давамгайлсан болон хийсвэр зураглал үүсгэх нөхцлийг бий болгосон энэ нь тухайн үед ноёлж байсан шашин зан үйлийн ертөнцийг үзэх үзэлтэй шууд холбоотой байжээ.Орчин цагийн шинжлэх ухааны үндэс суурь болох газрын зургийн эхлэлийг эртний гре кийн эрдэмтэн Эростоефен МЭӨ II зууны үед бий болгосон . Эростофен эртний хийсвэр дүрслэл буюу үзэл санааны зураглалыг геометрын дүрслэл нар сар оддын харилцан үйлчлэлийн онолыг үндэслэн газрын гадарга дээрх тоон хэмжээс буюу голдож зэргэдийг газрын зурагт бий болгосон.

Газрын зургийг хэмжээс , агуулга , зориулалт нутаг дэвсгэрийн хамаарал , өнгө хуудасны тоо ашиглалтын байдал зэрэг олон шинжээр нь ангилдаг.

Газрын зургийг хэмжээсээр нь гурван хэсэгт хуваадаг .

- 1.Том хэмжээсийн газрын зураг
- 2.Дунд хэмжээсийн газрын зураг
- 3.Жижиг хэмжээсийн газрын зураг

Газрын зургийг агуулгаар нь Ерөнхий газар зүйн зураг, гэж газар зүйн ландшафтын үндсэн элементүүд ба түүнтэй холбоотой нийгмийн үзэгдлүүдийг үзүүлсэн зургийг хэлнэ. Иймд ерөнхий газар зүйн зургийн агуулгад Ус зүй, рельеф буюу газрын гадаргын хотгор гүдгэрийн байдал , хот суурин зам харилцаа, улс гүрний ба засаг захиргааны хил, зарим хөрс ургамлын бүрхүүлийн элементүүд ордог.

Ерөнхий газар зүйн зураг нь мөн дотроо :

- 1:200000 аас том хэмжээстэй зургийг байр зүйн буюу тонографийн.
- 1:300000 аас 1:100000 хэмжээстэй зургуудыг тоймчилсон байр зүйн зураг
- 1:100000 аас бага хэмжээстэй нь тоймчилсон ерөнхий газар зүйн зураг гэж тус

тус хуваадаг...

Үргэлжлэл бий

БУСАД САЛБАР ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ

БНХАУ-ААС МОНГОЛ УЛСАД ХУДАЛДАА, ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БҮС БАЙГУУЛАХ БОЛОМЖИЙН ТУХАЙ СУДАЛГАА



Сүхбаатарын Оргил

/苏和巴特尔/ /敖日格乐/

БНХАУ-ын Улс төр, Хуулийн их сургуулийн
Олон улсын эрх зүйн сургуулийн докторант

Монгол Улс нь Хятад, Орос хоёр их гүрний дунд оршдог, өвөрмөц газарзүйн байрлал, байгалийн нөөц баялаг ихтэй улс бөгөөд БНХАУ-ын үе үеийн удирдлагаас Монгол улстай улс төр, эдийн засгийн харилцаа хөгжүүлэхийг чухалчилж үздэг. Хятад улс нь Монгол улстай эх газраар хамгийн урт хилийн шугамаар холбогдсон хөрш орнууд бөгөөд Стратегийн төвшний харилцаатай түншүүд билээ. Зөвхөн Өвөрмонголын өөртөө засах оронтой 3000 гаруй километр урттай хилийн шугамаар холбогдож, тус өөртөө засах орны голлох үндэстэн өвөрмонголчуудтай соёл, зан заншлын хувьд ижил төстэй олон зүйлээр холбоотой байдаг. БНХАУ-аас Монгол Улстай хөгжүүлж буй гадаад худалдааны дийлэнх хувийг Өвөрмонголын өөртөө засах орноос хийж байна.

1. Хятад улсаас Монгол Улсад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулж, хоёр улсын худалдаа, эдийн засгийн харилцааг улам бүр хөгжүүлэх шаардлага

Аж үйлдвэрийн өөрчлөлтийг дагаж Хятадын хөнгөн үйлдвэр,гэр ахуйн цахилгаан хэрэгсэл, барилгын материал, химийн үйлдвэр, металлургийн болон бусад томоохон үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдэж, өрсөлдөх чадвар ихтэй, харьцангуй давуу тал бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэж, дотоодын зах зээлдээ хангалттай нийлүүлж байна.

Харин Монгол улсад хөнгөн үйлдвэрлэлийн хөгжлийн түвшин харьцангуй сул, БНХАУ-аас импортолж, дотоодын хэрэгцээ хангаж буй бүтээгдэхүүн цөөнгүй байгаа юм. Хэрэв хоёр улс хамтран худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бүсбайгуулж чадвал, БНХАУ-ын хөнгөн үйлдвэрүүдийг Монгол улсад оруулж ирэх боломжтой бөгөөд Монгол Улсад маш их хэмжээний хөрөнгө оруулалт хийгдэж, олон тооны ажлын байр бий болох, ард иргэдийн амжиргааны түвшинг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой. Түүнчлэн Монгол улсын хөнгөн үйлдвэрийн дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ, зах зээлийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх өргөн боломж байгаа юм.

Үүнээс гадна, БНХАУ Дэлхийн худалдааны байгууллагад нэгдэн орсноос хойш, тус улсын экспортын худалдаа өсөхийн хирээр худалдааны маргаан нэмэгдсэн байдаг. Гэсэн хэдий ч аливаа маргааныг зүй зохистой шийдвэрлэхэд гадаад худалдааны олон улсын эрх зүйн зарчим, хэм хэмжээ эрүүлээр нөлөөлсөөр байгаа юм.

Талууд Худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны бүсбайгуулж “Хятадад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн - Хүлээн авагч улсад үйлдвэрлэсэн” гэж өөрчлөх замаар шилжүүлж болох төдийгүй Монгол Улс өөрийн нэрээр тариф, гаалийн хөнгөлөлт эдэлдэг улс орнууд руугаа гаргах, дотоодын зах зээлийг хангах боломж бүрдэнэ.

2. Монгол, Хятад хамтран Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулж, хоёр улсын эдийн засгийн хамтын ажиллагааны харилцан нөхөх нөхцлийг бүрдүүлэх боломж

Ойрын жилүүдэд Хятад улсын эдийн засгийн тасралтгүй хөгжлийг дагаж ашигт малтмалын шаардлага улам нэмэгдэж, дотоодын ашигт малтмалын нийлүүлэлт хангалттай бус байна. Монгол Улс нь байгалийн баялаг арвин их нөөцтэй, зэс, нүүрс, төмрийн хүдэр, цайр, алт, хайлуур жонш, газрын тос, фосфат гэх мэт маш олон төрлийн ашигт малтмалын нөөцөөрөө дэлхий нийтийн анхаарлыг татаж буй улс орон юм. Гэвч Монгол Улсын уул уурхайн салбар нь хөгжиж буй, хүнд аж үйлдвэр, олборлолтын туршлага багатай, шинэ дэвшилтэт технологи, гадаадын хөрөнгө оруулалт хангалтгүй байна.

Харин Хятадын ашигт малтмал олборлох, боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, машин механизм, шинэ дэвшилтэт тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, технологи дэлхийн стандартад нийцэж байгаа тул хоёр улс тус тусын давуу талд тулгуурлаж, ашигт малтмал олборлох, уул уурхайн үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлж, хамтдаа хожих нөхцлийг бүрдүүлж болно.

Монгол Улс нь газар зүйн хувьд хойд зүгт орших ба уламжлалт нүүдлийн соёл иргэншлийн төв хэмээн олон улсын тавцанд нэрлэгдэж, дотоодын нийт бүтээгдэхүүний дийлэнх хувийг хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн эзэлж байна.

Харин хятад бол уламжлалт хөдөө аж ахуйн орон бөгөөд бүтээгдэхүүний нэр төрөл олон, тоо хэмжээ их, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг их хэмжээгээр экспортлох хүчин чадалтай орон хэдий ч өнөөгийн байдлаар дотоодын хэрэгцээг бүрэн дүүрэн хангахад чиглэсэн бодлого баримталж, гадаадад хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн гаргахыг хязгаарлаж байна.

Иймд Монгол Улсын мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортын хэмжээ харьцангуй их, зэрлэг ан амьтны нөөцбаялаг байдлыг харилцан ашигтай байдлаар ашиглаж, Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бүсэд хамтарсан боловсруулах үйлдвэр байгуулах замаар БНХАУ-ын хэрэгцээний зохих хувийг хангах өргөн боломжтой.

Түүнчлэн Монгол Улсын мал аж ахуй, зэрлэг ан амьтны гаралтай бүтээгдэхүүний хэмжээ харьцангуй их тул хөдөө аж ахуй, мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний импорт, экспортын хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэх нөхцлийг бүрдүүлж, харилцан нөхөх боломж байгаа юм.

2012 оны байдлаар БНХАУ-ын гадаад худалдаа, импортын бүтцэд зонхилж буй улс орнууд, барааны нэр төрөл

Эх сурвалж: НҮБ-ийн статистикийн газрын худалдааны тоо баримтын мэдээллийн сан

Импортын бараа	1	2	3	4	5
Цахилгаан бараа, электрон тоног төхөөрөмж	Солонгос улс	Япон улс	Малайз улс	Америк улс	Герман улс
Ашигт малтмалын түлш, тос, нэрэх бүтээгдэхүүн зэрэг	Саудын Араб	Ангол	ОХУ	Иран	Монгол
Машин, цөмийн реактор, уурын зуух	Япон	Герман	АНУ	Солонгос	Тайланд
Хүдэр, нефтийн шаар, үндэс	Итали	Бразил	Өмнөд Африк	Перу	Монгол
Оптик, фото зураг, эмнэлгийн болон бусад техник, тоног төхөөрөмж	Солонгос	Япон	АНУ	Герман	Англи
Ноос, мал, амьтны үс, адууныхөөвөр, даавуу	Итали	Шинэ Зеланд	Итали	Япон	Монгол
Малын арьс, үс, үслэг эдлэл	АНУ	Австрали	Итали	Бразил	Монгол

3. Монгол улсад Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулахад нөлөөлөх сөрөг тал, бүтээн байгуулснаар бий болох боломж

Монгол Улсын дэд бүтцийн хөгжил сул, зам тээврийн нөхцөл шаардлагын түвшинд хүрдэггүй тул гадаадын хөрөнгө оруулагчид тус улсад хөрөнгө оруулж, орд газар нээх, ашиглах явцад их хэмжээгээр экспортынхүндрэл учирдаг. Монгол Улсаас авто замаар 3,4 чиглэлээр, төмөр замаар цорын ганц чиглэлээр тээвэрлэлт хийдэг бөгөөд тус улсын дайран өнгөрч буй замын урт 2000 км хүрдэггүй, тээвэр гүйцэтгэх хүчин чадалнэн сул байна.

Хоёр улсын хилийн бүсэд, Монголын тал шороон замтай бөгөөд олон улсын стандартад нийцсэн, авто зам үндсэндээ байхгүй гэж хэлж болно. Тус улсад уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт хийж, ашигт малтмал ашиглаж буй БНХАУ-ын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдийн хувьд хилийн боомтоос багагүй зайтай, хамгийн ойрдоо 300 км зайтай байгаа юм.

Энэ зайнд шороон замаар тээвэрлэлт хийхэд хүндрэлтэй төдийгүй, хүнд даацын автомашин их хэмжээгээр тээвэрлэлт хийхэд нутгийн иргэдийн эсэргүүцэлтэй тулгарч, Хятадын аж ахуйн нэгжүүд Монголд олборлосон баялагаа тээвэрлэхэд ихээхэн хүндрэл учирч байгаа юм.

2010 онд Монгол Улсын Засгийн газар дэд бүтцийн бүтээн байгуулалтад улсын төсвөөс 25.5%-ийн хөрөнгө оруулалт хийсэн бол 2011 онд 32.8%-д хүргэж нэмэгдүүлсэн. 2010онд зам барих, сэргээн засварлах бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалт улсын төсвийн 20%-ийг эзэлж байсан бол 2011 онд 23.6% болж өсчээ.⁸⁰

⁸⁰数据来源于中国商务部网站, <http://www.mofcom.gov.cn/>

Монгол Улс замын бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлсэн нь зарим талаар эерэг үзүүлэлт хэдий ч уул уурхай эрхэлж буй аж ахуйн нэгжүүд бүтээгдэхүүнтээвэрлэх, экспортлох шаардлагын түвшинд хүрдэггүй.

Хятадын зарим аж ахуйн нэгж Монголын зах зээлд байр суурь олохын тулдалдагдал хүлээхийг үл хайхарч, тус улс улс руу гаргаж буй бүтээгдэхүүний үнэ ханшийг буулгаж, тус улсын зах зээлд нөлөөлөх явдал цөөнгүй байдаг.

Түүнчлэн Монголын зах зээлд үнэ багатай чанаргүй бүтээгдэхүүн нийлүүлж Хятадын үйлдвэрлэгчдийн нэр хүндийг унагах тохиолдол цөөнгүй байгаа юм. Тухайлбал, 2006 онд Монгол Улсад Хятадаас оруулж ирсэн зарим нэр төрлийн жимс, хүнсний ногоо хүний биед хортой, аюул учруулж болох талаар мэдээлэл олон нийтэд цацагдсаны улмаас жил ирэх тусам Хятадаас Монгол руу экспортын хэмжээ буурч, хоёр улсын гадаад худалдаанд сөрөг нөлөө үзүүлж байна.

Тэрчлэн Монголд хөдөлмөр эрхлэгч хятад иргэд олширч байгаа нь монгол, хятад иргэдийн дунд зөрчил, маргаан дагуулж, монголчуудын дунд хятад иргэдэд таагүй хандах нөхцлийг бүрдүүлж, зарим талаархоёр улсын гадаад худалдааны хөгжилд сөрөг нөлөө үзүүлдэг зэрэг сөрөг талыг дурдаж болно.

Гэсэн хэдий ч талууд хамтран Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулж чадвал дотоодын тээврийн аж ахуйн нэгж, зам тээврийн компани зэрэгт ашигтай бөгөөд зарим талаар дэд бүтцийн хоцрогдлыг эерэгээр шийдэх нөхцөл бүрдэнэ.

Нөгөөтэйгүүр Монгол Улсын цахилгаан, усан хангамжхарьцангуй хоцрогдмол, тус улсын 110 гаруй сум, суурин төвийн эрчим хүчний системд холбогдоогүй байгаа юм.⁸¹Талууд хамтран Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бүсбайгуулсан тохиолдолд тухайн бүсийн аж ахуйн нэгжүүдийн ус, цахилгааны хэрэглээг Хятадын талаас хангаж, дэд бүтцийн сул талыг арилгах бүрэн боломжтой гэж үзэж байна.

Монгол улсын хүн амын тоо бага, зах зээлийн эрэлт хязгаарлагдмал хэдий ч Хятад Улсад экспортлох эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, хоёр улсын гадаад худалдааны гол субъектжижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх гарцыг хамтдаа олж болно.

Хятад улс нь Монгол улсад худалдаа, гадаад эдийн засгийн хамтын ажиллагааны бүсбайгуулснаар Хятад улсын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн тоо, хөрөнгө оруулалтын хэмжээг бодит утгаар нэмэгдүүлэхээс гадна гадаад худалдааны эргэлт нэмэгдэх өндөр ач холбогдолтой.

4. Хятад улс нь Монгол улсад гадаад эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны бүс байгуулахад анхаарах асуудал

Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бүсбайгуулахаас өмнө Хятадын засгийн газар гадаад харилцааны шугамаар сайтар нөлөөлөл үзүүлж, Хятадын хөрөнгө оруулалтаар Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийг амжилттай бүтээн байгуулах нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн бодлого явуулах шаардлагатай. Тус хамтын ажиллагааны бүсийг бий болгох явцад хоёр улсын засгийн газрын төвшинд харилцаа холбоо, зохицуулалтын механизм үүсгэн байгуулна.

Улмаар харилцаа холбоо, зохицуулалтын механизмыг ашиглаж, худалдааны эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийг бүтээн байгуулах, хөгжүүлэхэд тулгарах аливаа асуудлыг шийдвэрлэж, аж ахуйн нэгж болон хүлээн авагч улс хоорондын харилцааг сайжруулах ач холбогдолтой.

Түүнчлэн Хятадын засгийн газраас Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа байгуулах аж ахуйн нэгжид мөнгөн тусламж үзүүлэхээс гадна татвар, зээл, гадаад валют, даатгал зэргийг зохицуулах цогц арга хэмжээавдаг. Энэ нь тухайн аж ахуйн

⁸¹中国境外经济贸易合作区推介会在南宁举行〔EB/OL〕、商务部，

<http://guangxi.mofcom.gov.cn/aarticle/sjshangwudt/200910/20091006593851.html>

нэгжид улсаас тусламж авч, санхүүжилтийн асуудлаа шийдвэрлэх боломж олгож, улмаар үйл ажиллагаа өргөжүүлэн Хятадын дотоодын санхүүгийн байгууллагаас урт хугацааны, нэн хөнгөлөлттэй зээл авч, урт хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулах үндэс суурийг тавьж өгдөг юм.

Хятадын томоохон үндэстэн дамнасан аж ахуйн нэгжүүд гадаадад хөрөнгө оруулах, хувьцаа эзэмших, уул уурхайн олборлолт эрхлэх зэрэгт нэн хөнгөлөлттэй зээл авах боломжтой бөгөөд дотоодын банк, түүний гадааддахь салбар нэгжээс зээл авах боломжтой байдаг.

Хятад улсаас хилийн чанадад Худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах явцад бүх төрлийн даатгалын байгууллагыг дэмжиж, чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрдөг нь хөрөнгө оруулалт хийж буй аж ахуйн нэгжид экспортын зээлийн баталгаа авах, хөрөнгө оруулалт, дайн бүхий байдал болон засгийн газрын гэрээ зөрчих зэрэг улс төр, эдийн засгийн эрсдлээ багасгах, даатгалын үндсэн хүлээн авагч улсын хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулах боломж олгодог байна.

Аж ахуйн нэгж нь микро эдийн засгийн бие даасан нэгж бөгөөд гадаадын хөрөнгө оруулалтын мэдээлэл олж үзэхэд хүндрэлтэй байдлыг харгалзан Хятадын Засгийн газраас мэдээллийн нөөцийг эрчимтэй түгээхэд интернет, хэвлэл мэдээлэл, үзэсгэлэн худалдаа, семинар, хөрөнгө оруулалтын уулзалтын төлөөлөгчид зэрэг маш олон зам сувгаар мэдээлэлтүгээдэг.

Цогц мэдээллийн үйлчилгээний системийг байгуулахад тухайн хүлээн авагч улсын эдийн засгийн байдал, хууль тогтоомж, шашин шүтлэг, зан заншил, философи зэрэгт холбогдох нөхцөл байдал, орчныг сайтар судлаж, мэдсэн байх шаардлагатай.

Монгол Улсад Хятадын талаас хөрөнгө оруулж бизнес, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх сонирхолтой жижиг том аж ахуйн нэгж нэмэгдэж байгаа нь хөрөнгө оруулалт хийх аж ахуйн нэгжүүдийн хоорондэмх замбраагүй өрсөлдөөн, зарим талаар хор уршигтай зөрчил үүсгэж байгаа байдлыг Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хамтран байгуулах замаар тус бүсэд олон улсын стандартад нийцсэн, Хятадын томоохон аж ахуйн нэгжүүдийг оруулж ирэх замаар менежментийг сайжруулж, Хятадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд Монголд бүрэн утгаараа байр сууриа олоход ахиц болох болно.

ХУУЛЬ САХИУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ДАХЬ СЭТГЭЛГЭЭНИЙ ТУЛГАМДСАН АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ, ЧИГ ХАНДЛАГА

Л.Цогтбаяр

Орхон Их Сургуулийн Эрүүгийн эрх зүйн
ахлах багш, ХСИС-ийн докторант,

Харилцах хаяг: Moncpfgensec@yahoo.com mobile num: 99117460

Товчлол:Хууль сахиулах үйл ажиллагаа нь захиргаадах бус хүмүүсийн сэтгэлгээг өөрчлөх хүрээнд нэгдмэл бодлоготой хэрэгжүүлэх нь эерэг үр дүнд хүрэх арга зам, чиг хандлагын талаар энэхүү илтгэлдээ тусгасан болно.

Abstract:Law enforcementactionwith integrated policy should be implemented in the frame to change public psychology report tells above view can be a good tendency as will non risking ways.

- 1. Хууль сахиулах үйл ажиллагааны шинэтгэл, инновацийн үйл ажиллагааны харилцан хамаарал, ач холбогдол**

Хүн төрөлхтөн ертөнцийн юмс үзэгдлийг танин мэдэхийг эрмэлзэж байсан тэртээх үеэс эхлээд өнөөдрийг хүртэл асар их зүйлсийг танин мэдсэн хэдий ч урд өмнө мэдсэн, сурсан зүйлээ маш богино хугацаанд ор тас мартаж ирсэн нь хамгийн харамсалтай үйлийг нэг ажээ.

Аливаа амьтан бүрийн туйлын зөн нь амгалан тайван, аз жаргалтай амьдрах, таатай орчинд орших зүй тогтолтой билээ. Энэ ертөнцийн түмэн зүйлийн амьтадын дотроос ой ухаан, сэрэх сэрэхүй, хүсэл мөрөөдөл, эрмэлзлэл, сэтгэлгээ бүхий шинж бүрдмэл нь гагцхүү нийтээрээ сүрэглэн амьдрах зөн билигт байгалийн өвөрмөц бодгаль болох хүн.

Засгийн эрхэм үүрэг нь тухайн **угсаатан** иргэдийгүеийнүедээрэг сэтгэлгээ, өөдрөг үзэл бодолтой (айх аюулгүй, азжаргалтай, амар амгалан амьдрах) итгэл үнэмшилтэй байх нөхцөлийг баталгаажуулах зорилгоор хүний эрхийг баталгаатай хангах, хамгаалах, зөрчигдсөн тохиолдолд эрхийг сэргээх, хохирсон хохиролыг арилгах, гэм буруутай хэн бүхэнд тохирсон хариуцлага хүлээлгэхэд чиглэгдсэн бодлого, үйл ажиллагааны цогц ойлголт юм.

Угсаатан нь грекийн **“ethnos”** буюу “ард түмэн” хэмээх үгээс гаралтай.

Түүхэн хугацаанд тодорхой нэг нутаг дэвсгэрт бүрэлдэн тогтсон, нэг гарал үүсэлтэй, нэгэн хэлээр ярьдаг, аж ахуй, соёл, сэтгэлзүйн хувьд нийтлэг шинж бүхий, өөрсдийгөө тухайн угсаатны нэг гишүүн хэмээн ухамсарласан хүмүүсийн нэгдлийг ойлгоно. Академич Ю.В.Бромлей⁸² “Соёл болон сэтгэл зүйн тогтвортой онцлог бүхий түүхийн хувьд тодорхой нутаг дэвсгэр дээр бүрэлдэн бий болсон, мөн түүнчлэн өөрсдийн нэгдэл болон бусдаас ялгарах ялгааг ухамсарладаг хүмүүсийн цогц юм. Төр-засаг бодлого, шийдвэр батлан, хэрэгжүүлэхдээ хүн төрөлхтний угсаатан бүрэлдэн бий болсон нутаг дэвсгэр, хэл, соёл, сэтгэл зүйн бүхий л үзэгдлийг инновацид суурилсан нэгдмэл бодлогоор хараат гарал үүслийн хуулийн дагуу хамтатган авч үзэх зайлшгүй шаардлагатай болжээ.

Өөрөөр хэлбэл бодлого, шийдвэр, хууль тогтоомжийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэхдээ **“санамсаргүй бодол-санааны таамгаар бодлого боловсруулах”** бус **“шинжилгээ судалгааны үр дүнгээр баримжаалж, түүнд тулгуурлаж бодлого боловсруулах”**⁸³ инновацийн үйл ажиллагаа-үйл явц руу шилжих хэрэгтэй байгааг өнөөгийн цаг үе шаардаж байна.

“Хүн бүрийг хамгаалсан хуулийг хүмүүс цаг ямагт хамгаалдаг” гэсэн ойлголт нь эрх зүйн шинэчлэлийг инновацийн үйл ажиллагаанд үндэслэн батлан хэрэгжүүлэх шаардлагатайг илэрхийлнэ.

Иймд нийт иргэдэд хууль, шударга ёсны сэтгэлгээ, зан төлөвийг хэвшүүлэхэд чиглэсэн инновацийн үйл ажиллагаанд тулгуурласан бодлогоор төлөвлөх, зохион байгуулах, зохицуулах, журамлах нь төр-засгийн нэгдмэл бодлогын тулгамдсан асуудлын нэг мөн.

Төрийн бодлого үйл ажиллагааны үндэс нь Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний Аюулгүй Байдлын Үзэл Баримтлал, Гадаад Бодлогын Үзэл Баримтлалд тулгуурлан төрөөс баримтлах тодорхой хугацаатай бодлого боловсруулах, хөтөлбөр хэрэгжүүлэх, салбарын ерөнхий хууль батлах, салбар хуулиуд батлан хэрэгжүүлэх, түүнд тохирсон байгууллага, хүний нөөцийн асуудал зэрэгт уялдуулахад чиглэгдэх учиртай.

Манай улс 1992 онд өнөөгийн Үндсэн хуулийг батлан мөрдүүлсэнээс хойш 22 гаруй жилийн хугацаанд салбар, салбарын 550 гаруй хууль, 16 бодлогын баримт бичиг батлан, хэрэгжүүлсэн боловч дийлэнх нь тухайн салбарын алс хэтийн зорилго, нэгдмэл бодлогод тулгуурлаагүй, хугацаа тодорхой бус, өөр хоорондоо уялдаа муутай төдийгүй эрх зүй, эдийн засаг, хүний менталитет, байгаль, нийгэм, техникийн шинжлэх ухааны

⁸²Теорый этнография. Мос., 1984 г,

⁸³“Логикийн лекцийн хураангуй” Л.Цогтбаяр. УБ., 2012 он

үүднээс судалгаа шинжилгээ дутмаг, үндэслэл муутай боловсруулж, батлан, мөрдүүлж ирсэн нь нилээдгүй эсэргүүцлийг дагуулж нийт иргэд төдийгүй тухайн салбарын хамт олны зүгээс хүлээн зөвшөөрөхгүй байгаа учраас засгийн нэр хүнд унах, тэдэнд итгэх итгэл алдах хандлагатай явж ирсэн.

Энэ байдалаас шалтгаалж шат шатны албан тушаалтан, дураар авирлах, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, сахилга хариуцлага алдагдах, авлига, албан тушаал, зохион байгуулалттай, үндэстэн дамнасан зэрэг олон төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх үндсэн шалтгаан болно.

Энэ бүх бодит нөхцөл байдлыг ухаалаг зохицуулахын тулд эрх зүйн шинэчлэлийг инновацийн үйл ажиллагаанд тулгуурлан үндэслэлтэйгээр яаралтай зохион байгуулж, хэрэгжүүлэхийг өнөөгийн цаг үе шаардаж байна.

Харин 1998 онд УИХ-аас батлагдсан “Эрх зүйн шинэчлэлийн хөтөлбөр”-ийн 1 дүгээр зүйлийн 1 дэхь хэсэгт⁸⁴, 1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт⁸⁵, 1 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт⁸⁶ заалт, 2000 онд УИХ-ын тогтоолоор баталсан “Монгол Улсын Шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө”-нд тусгагдсан заалт, 2009 онд УИХ-ын 38 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Хууль тогтоомжийг 2012 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн заалт, 2009 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 105 дугаар зарлигаар баталсан “Ерөнхийлөгчийн бодлого үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн заалтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд Шүүх засаглалын эрх зүйн шинэчлэлийн нилээд ажил хийгдэж бодит биелэлээ олж, иргэд, олон нийтийн зүгээс сайнаар үнэлэгдэн, амжилттай хэрэгжиж эхэлж байгаа нь нэн сайшаалтай.

Эрх зүйн шинэтгэл нь эрх зүйн тогтолцоог улам боловсронгуй болгох, хууль ёс, сахилга батыг бэхжүүлэх, эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг сайжруулах, хүний эрх, эрх чөлөө, язгуур ашиг сонирхол, үнэт зүйлийг баталгаатай хангах, хамгаалах, нийтийн амьдралд эрх зүйн сэтгэлгээ, ухамсар, соёл, хэв шинж, уламжлалыг бүрэлдүүлэх, нийт хүмүүст хууль ёсыг ягштал биелүүлэх сэтгэлгээ, уламжлалыг төлөвшүүлэн тогтоох зорилтод чиглэсэн цогц үйл ажиллагаа байдаг тул энэхүү зарчим алдагдах магадлалтай.

Эндээс харахад эрх зүйн шинэтгэлийн зорилтот шаардлагыг хангахад хүндрэл учирч болох доорхи 3 багц дутагдал байна гэж үзэх үндэслэлтэй.

1. Эрх зүйн нэгдсэн чиг хандлага, нэгдмэл бодлого, эрх зүйн тогтолцоо, хуулиудхөгжлийнхэтийнтөлөв, хоорондын уялдааг хэрхэн шинэчлэх,
2. Нийгмийн бусад шинжлэх ухааны нэн чухал салбаруудын уялдааг хэрхэн хангах, /Анагаах, Сэтгэц судлал, Соёл судлал, Түүх уламжлал судлал, Имижлоги, Генетик, Биологи, Антропологи, Мифологи, хагжиж байгаа зарим ШУ/
3. Төр-засгийн байгууллага, аж ахуйн нэгж байгууллага /компани/, хамт олон /олон нийтийн байгууллага/-ыг бэхжүүлэх үүднээс нийт хүмүүсийг /албан тушаалтанаас эхлээд алба хаагч, энгийн ажилчин иргэд бүгд хамаарна/эрхзүйнхариуцлага, эрх зүйн мэдлэг, ухамсар, соёл, хэв шинж олгох, хууль ёсыг ягштал биелүүлэх ёс зүйтэй болгон төлөвшүүлэх чиглэлээр тодорхой зорилго агуулаагүй байна.

Манай улсын хууль санаачлах, хууль тогтоох байгууллага нь аливаа хууль, тогтоомж боловсруулах, батлах, мөрдүүлэхдээ нэгдмэл хэтийн бодлого, үзэл баримтлалгүй, инновацийн үйл ажиллагаа-үйл явцад тулгуурлахгүй зөвхөн тоонд анхаарч ирсэн нь харамсалтай.

2012 онд батлагдсан Инновацийн тухай хуульд “инновацийн үйл ажиллагааны зарчим, удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт, төрийн дэмжлэг, оюуны өмчийг

⁸⁴УИХ-ын 18 дугаар тогтоол 1998.01.22.

⁸⁵УИХ-ын 18 дугаар тогтоол 1998.01.22.

⁸⁶УИХ-ын 18 дугаар тогтоол 1998.01.22.

эдийн засгийн эргэлтэд оруулан эзэмших, ашиглах, эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино”⁸⁷ гэжээ.

Инновацийн тухай хуулийг батлан мөрдөж байгаа нь сайн хэрэг боловч хууль тогтоох, хүний эрүүл мэнд, сэтгэлзүйн цогц судалгаа, шинжилгээний талаар инновацийн үйл ажиллагаа огт тусгаагүй нь эрх зүйн шинэтгэлийн үйл явц дахь сөрөг хүчин зүйлийг бий болгох магадлал ихэссэн гэж үзэх үндэстэй.

Эрх зүйн соёл, уламжлал төлөвшсөн ихэнх улс оронд ямар салбарт эрх зүйн зохицуулалт шаардлагатай байгааг судалгаа, шинжилгээний /инновацийн тогтолцоонд/ үр дүнд үндэслэлтэй тогтоох зорилготой цогц үйл ажиллагаа хэрэгжүүлсэнээр иргэншсэн, итгэл үнэмшилтэй хууль хэрэгжүүлдэг.

Энэ үйл ажиллагаа нь тодорхой үе шат дамжин хэрэгждэг.

1. Тухайнсалбарт эрх зүйн зохицуулалт шаардлагатай байна гэж үзвэл хараат гарал үүслийн хуулийн дагуу өргөн хүрээнд хамруулансудласны дараа төр-засгаас баримтлах хэтийнбодлогын баримт бичигболовсрууланбаталдаг(40 /50/, 100 жилийн баримжаатай)

(энэ хугацаандаа сургалт, судалгаа, сурталчилгаа, эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран ирээдүй судлалын үйл ажиллагаа явуулах),

2. Тухайнсалбарынүйлажиллагааныхэтийнтөлөвийгтодорхойлсонерөнхийболон тусгайхөтөлбөрийгбодлогынбаримтбичигтүндэслэнболовсрууланбатлан, хэрэгжүүлдэг (4-8 жилийнбаримжаатай)

(сургалт, судалгаа, сурталчилгаа, техник-технологид тулгуурлан бодит үйл ажиллагаа эхэлдэг),

3. Салбарынерөнхийхуульбаталдаг. Энэ хуулийг дээрхи бодлогын баримт бичгийн хүрээнд хэрэгжүүлсэн хөтөлбөрийн үр дүнд гарсан үзүүлэлт, хамаарах асуудлыг зохицуулах чадвартай нийтлэг харицааг зохицуулахуйц байхаар батлан хэрэгжүүлдэг. (20-40 жилийн баримжаатай)

(маш сайн судалж, шинжилсэний дүнд судлагдсан нөхцөлийн дагуу тухайн салбарын үйл ажиллагааг хэрэгжүүлэх байгууллага байгуулах, хүний нөөц, технологи, техник гарах үр дүн, өрсөлдөх чадвар зэргийг тооцсон байх),

4. Тухайн салбарт шаардлагатай салбар/органик/ хуулиудбатлах, хэрэгжүүлэх (4-20 жилийн баримжаатай)

(судлагдсан нөхцөлийн дагуу хэрэгжүүлэх байгууллага байгуулах, хүний нөөц, технологи, техник хэрэгсэлээр хангах, гадаад дотоод хамтын ажиллагаа гэх мэт) гэсэн өөр хоорондоо нягт харилцан хамааралтай, салшгүй нийтлэг шинжтэй, ухаалаг технологитой⁸⁸.

Ер нь эрх зүйн шинэчлэлийн хүрээнд инновацийн үйл ажиллагаанд тулгуурлан үндэслэлтэй боловсруулагдсан хууль, тогтоомжийн эцсийн зорилго хүмүүсийн хоорондын үйл ажиллагааг зохицуулах, хүн бүрийн эрх, эрх чөлөөг баталгаатай хангах, хамгаалах арга хэрэгсэл учир энэ технологи үйл ажиллагаа нь маш энгийн, ойлгомжтой, үр дүн сайтай байвал хүмүүст хуулийг хамгаалах, итгэл үнэмшил, эрмэлзлэл аяндаа төлөвших хандлага байдаг.

Монгол Улсын Үндсэн хууль⁸⁹-ийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 1 дэхь хэсэг, 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 1 дэхь хэсэгт

⁸⁷www.Legalinfo.mn, “Инновацийн тухай Монгол Улсын хууль”, 2012.05.22.

⁸⁸Технологигэсэн ойлголтыг их өргөн хэрэглэдэг бөгөөд Монголчууд эрт дээр үеэс аливаа ажил үйл ажиллагааг хэрэгжүүлэх тохирсон арга ухааны цогц ойлголтоор ойлгож ирсэн, Харин өнөөдөр аливаа үйл ажиллагаа хэрэгжүүлэхдээ төлөвлөгөө гаргах, хөтөлбөр боловсруулах, үйл ажиллагааны зорилго, зорилт, чиглэл, оролцогчид, үр дүнг тодорхойлох, сургах, мэдээллэх зэрэг өөр хоорондоо хамаарах үйл явцыг зөв зохион байгуулах арга ажиллагааг багтаасан цогц ойлголт мөн.

⁸⁹Монгол Улсын Үндсэн хууль 1992 он

төр-засгаас бодлого шийдвэр батлан, хэрэгжүүлэхдээ инновацийн үйл ажиллагаанд тулгуурлах шаардлагатайг илэрхийлсэн заалт мөн гэх үндэстэй.

Тухайлбал:

1. Байгаль, нийгмийн талаас Шинжлэх ухааны орчин үеийн арга, технологи ашигласан, үндэслэлсайтай,
2. Зорилготой, тогтвортой, бодитой, амьдрах чадвартай, алсын хараатай,
3. Үндэсний болон олон улсын эрх зүйд нийцсэн,
4. Бусад хууль, тогтоомжтой уялдаа холбоо сайн, харилцан нөхцөлдсөн,
5. Нийтийн эрх ашиг, шударга ёс, амьдрал үйл ажиллагаанд бүрэн тохирч нөхцөлдсөн,
6. Оролцогч нарын сэтгэц зүйд нөлөөлсөн зэрэг орон зай, цаг хугацаа, тоон ба чанар, агуулга ба хэлбэртэй байх үзэл санаанд үндэслэгдсэн байх учиртай.

Хууль нэг талаас хүний сайн сайхан, амар амгалан, аз жаргалтай амьдралын баталгааг хангах, хамгаалах, нийт хүмүүст хууль ёсыг ягштал биелүүлэх сэтгэлгээ, өв уламжлалыг төлөвшүүлэн тогтоох үндсэн зорилготой батлан мөрдүүлдэг, нөгөө талаас хүн тухайн хууль, ёс журмыг ой ухаандаа ойлгон, танин мэдэх, эрх зүйн сэтгэлгээ, ухамсар, соёл, хэв шинж, уламжлалыг бүрэлдүүлэх хамтын цогц үйл ажиллагаа ажиллагаа.

Ийм нэгдмэл үйл ажиллагаа байхгүйгээр ямар ч сайн хууль, тогтоомж батлан, хэрэгжүүлж, хатуу чанд дэг журам тогтоолоо ч ёс суртахуунгүй, бусармаг үзэгдэл, үйл ажиллагаа амь бөх оршсоор байдгыг хүн төрөлхтний түүх гэрчилнэ.

Харин эрх зүйн шинэчлэлийг инновацийн үйл ажиллагаанд тулгуурлан үндэслэлтэй зохион байгуулж хэрэгжүүлэхдээ хүмүүсийн ой ухаан, сэтгэл санаанд нөлөөлж, үнэн зөв ухуулан таниулах аваас хууль-эрх зүй муу байсан ч сайн талаас нь хүлээн авч хэрэгжүүлэх хүсэл зориг, сэтгэл санаа, тархи оюуны өгөгдөл аяндаа бий болох зүй тогтолтой.

2. Эрхзүйн шинэтгэл ба хүмүүсийн сэтгэлгээний сөрөг хандлага

Хүний материаллаг хэрэглээ төдийгүй оюуны хэрэгцээ ч мөн адил жил, сар, өдрөөр биш цаг хоромоор хөгжиж, өөрчлөгдөж байна.

Ядуурал, ажилгүйдэл, хүн амын эрүүл мэнд, боловсрол, хүрээлэн буй орчны болон хөгжлийн хурдыг сааруулж байгаа гол шалтгаан нь нийтийн боловсрол, сэтгэлгээний тулгамдсан асуудал мөн.

Энэ цаг үед боловсрол цаасан дээр биш амьдрал дээр, тунхаг төдий бус жинхэнэ утгаараа тэргүүлэх салбар нэгэнт болжээ.

Бид дэлхийн жишигт хүрсэн чанартай, хүртээмжтэй, нээлттэй, өргөн сонголттой бүх хүмүүсийг насан туршдаа суралцах, чанартай боловсролын тогтолцоог яаралтай бий болгон хэрэгжүүлэх хэрэгтэй болсон.

1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хууль маш сайн идеаль /үнэт зүйл/-тай, маш сайн институцлэгдсэн /бүтэцлэгдсэн/ тулгуур баримт бичиг гэдэгт олон хуульч санал нэг байдаг. Харин сэтгэлгээний хоцрогдолтой, буруу ёс зүй, ухамсартай зарим нэгэн хүмүүс өөрийн буруу хандлагад хуулийг тааруулж буруугаар тайлбарладаг нь харамсалтай.

Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хүрээнд гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, хууль сахиулахуйн үйл ажиллагааны шинэтгэлийн бодлогозарим нэг эсэргүүцэлтэй тулгарч байгаа шалтгаан нь сэтгэл зүйн харилцан хамаарлыг нөхцөлдүүлж, хүмүүст хуулийг хүлээн зөвшөөрөх хүсэл зориг, эрмэлзлэлтэй болгох **менталитетийг** хуульчилж чадаагүйтэй холбоотой.

“Аливаа хүн дордохоороо бурууг харин дээрдэхээрээ үргэлж зөвийг сэтгэдэг” гэсэн үг нь хүн өөрийгөө дээрдүүлэх гэж албан тушаалыг бус эрдмийг шүтэх менталитеттэй байх учиртай, **“Номонд мэргэн хүн ертөнцөд ч мэргэн байдаг”** гэсэн

үг нь шунал, уур хилэн, атаа хорсол, бардам сагсуу, эргүү мунхагаас эгнэгт салж сайхан бүхнийг сэтгэж, үйлддэг гэсэн утгыг илэрхийнэ.

Хүүхэд эцэг эхээ шууд дууриан хуулбарладаг адил, нийт иргэд манлайлах ёстой удирдлага, албан тушаалтан, ахмад үе, эцэг эхийгээ л дууриадаг, тэд буруу зүйл яриад, амин хувиа хичээн, албан тушаалд шунахаараад гүйгээд байвал иргэд дууриагаад л эмх замбараагүй байх болно гэдгийг анхаарач, судалгаа шинжилгээний үйл ажиллагааг эрс өөрчлөх цаг нэгэнт болсон.

“Хууль зүйн сэтгэл судлалын шинжлэх ухаан”-ны үүднээс тодорхойлвол:

А) Аливаа сайн-мууг, үнэн-худлыг, хэрэгтэй-хэрэггүйг, минийх-минийх биш гэдгийг таних оюуны хийгээд сэтгэлийн чадамжтай ямар ч хүнд хууль, дэг журам хэрэггүй тэдгээр хүмүүс ямар ч сургууль, боловсролгүй байлаа ч гэсэн тэдэнд нөлөөлөх боломжгүй. Ийм хүн оюуны боловсролоос гадна зүрх сэтгэлийн боловсрол, энэрэл нигүүлсэн ухаан дүүрэн байгаа хүмүүсийг **“бусдын эрх ашгийг хангах гэж өөрийн эрх ашгийг хасагч”** буюу орчин цагийн **иргэншсэн хүн** гэнэ.

Б) Хичнээн олон сургууль төгссөн, эрдмийн цол зэрэгтэй, олон улс орны хэл мэддэг, хөрөнгө чинээтэй, магадгүй хэнээс ч илүү албан тушаалтай атал сайн-мууг, үнэн-худлыг, хэрэгтэй-хэрэггүйг, минийх-минийх биш гэдгийг таних оюуны хийгээд сэтгэлийн чадамжгүй оюун ухааны хий хоосон, хуурамч дүртэй, оюун ухаан, сэтгэлийн боловсрол нь хоосорсон хүмүүсийг **“өөрийн эрх ашгийг хангах гэж бусдын эрх ашгийг хасагч”** буюу орчин цагийн үйлийн үрд баригдсан нүгэлтэн хүн гэнэ. Энэ хүнд ухааруулах, сэхээрүүлэхээс эхлээд засгийн хатуу хүмүүжүүлэх арга бүгд хэрэгтэй.

“Аливаа хүн өөрийн эрх, ашигаа хязгаарлан барьж амьдарч чадвал бусад хүний эрхийг хязгааргүй баталгаажуулж байгаа явдал болох” учиртай.

Өнөөдөр засгийн хуулиас иргэншсэн, олон нийтийн хуулийн засаглал руу шилжих үйл явц өрнөж байгаа тул засгийн бодлого, хуулийг батлан мөрдүүлэх, эрх зүйн шинэчлэлийг инновацийн үйл ажиллагаанд тулгуурлан, шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулсан тохиолдолд эрх зүй, сэтгэл зүй хоёр нэг шугам дээр давхцан улмаар нийтийн амьдралд аз жаргал, амар тайван байдал баттай оршин саар муу бүхэн аяндаа багасах хандлагад шилжинэ.

Нийтийн эрх ашиг, сонирхолыг хангах зорилготой эрх зүй, сэтгэл зүй хоёр өөр байрлалд байгаа учир дараахь хүндрэлтэй асуудал үүсэж байна.

Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хүрээнд гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, хууль сахиулахуйн үйл ажиллагааны шинэтгэлийн бодлого эхлэлийн төдий ч үргэлжилсээр, зарим нэгэн эсэргүүцэл, хүндрэл, саад бэрхшээлтэй тулгарч байна.

Монгол Улсын хэмжээнд жилд дунджаар 20 мянга орчим гэмт хэрэг бүртгэгдэж, бусдад 40 орчим тэрбум төгрөгний хохирол учирч, 1600 орчим хүн нас барьж, 7500 орчим хүн гэмтэж, эдгээр хэрэгт 20 орчим мянган хүн сэжигтэнээр тооцогдон шалгагдаж, 6000 орчим хэрэг шүүхээр шийдвэрлэгдэж, 9000 орчим хүн шийтгэгдэж, шийтгэгдсэн хүний 43 орчим хувь нь албан тушаал, албан ажил сургуульд суралцдаг, бусад нь эрхэлсэн тодорхой ажил сургуульгүй судалгаа гарч байна.⁹⁰

Гэвч сүүлийн жилүүдэд уламжлалт гэмт хэргээс гадна шинэ төрлийн гэмт хэрэг, хохиролтой ихтэй албан тушаалын гэмт хэргүүд шалгагдан шүүхээр шийдвэрлэгдэж, тэр тоо тасралтгүй өсөх хандлагатай байгаа нь урьд өмнө ийм гэмт хэрэг нуугдмал */latentis/* байсныг илэрэл. Тухайлбал:

Иргэдийн төлөөлөл, элч болсон УИХ-ын гишүүд, гэмт хэргийн шинжтэй үйл хэрэгт холбогдсон боловч хуулийн зохицуулалтаас шалтгаалан хууль, Шүүхээс тусгаар байгааг АТГ-аас мэдээлж байна.

⁹⁰Гэмт явдалтай тэмцэх төрийн бодлого, чиг хандлага ЭШХ-ын эмхтгэл 2, УБ., 2013, 174 тал,

/Монгол Улсын Үндсэн хууль⁹¹-ийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 3 дахь хэсэг/, МУ-ын ҮХЦ-ийн гишүүн, Засгийн газрын гишүүд, Агентлагуудын зарим нэгэн албан тушаалтан, Бүх шатны Засаг дарга нартай холбоотой шалгагдаж байгаа асуудал, Хууль сахиулах байгууллагын алба хаагч нартай холбоотой шалгагдаж байгаа асуудлууд гэх мэт хуулийн эсрэг үйл ажиллагаа цөөнгүй үйлдэгдэж байна.

Тухайлбал: Цагдаагийн алба хаагч нараас сахилгын шийтгэлийн хувьд жилд 2000 гаруй зөрчилд тийм хэмжээний алба хаагч, жилд 200 гаруй гэмт хэрэгт 200 гаруй алба хаагч холбогдон шалгагдаж шийдвэрлэгдэж байна.

1. Гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байгаа хүмүүсийн 50 гаруй хувь нь дээдээс доош боловсролтой ихэнх нь тодорхой ажил сургуульгүй гэж бүртгэгдсэн,
2. Бага насны хүүхдүүд /18-аас доош насны/ гэмт хэрэгт холбогдох, шийтгэгдэх асуудал харьцангуй өндөр хувьтай байгаа зэрэг явдал нь хуульдаа гэхээсээ илүү сэтгэлзүй, ёс суртахуун, соёл, уламжлал, бахархах, хайрлах, энэрэх, эелдэг зөв харилцаанаас үүдэлтэй байна.

Удирдан зохион байгуулж манлайлах албан тушаалтан нар нь хууль бус үйл ажиллагаа зохион байгуулдаг, оролцдог, үйлддэг зэрэг тэвчишгүй байдалд хүргэж байгаа нь сэтгэлгээний хоцрогдолтой тэмцэх, түүнийг тогтоох шалгуур, өөрчлөх арга зам, холбогдох бусад асуудлыг эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хамтатган инновацийн үйл ажиллагаанд тулгуурлан үндэслэлтэй зохион байгуулж хэрэгжүүлэх шаардлагатай болсон.

3. Монголчуудын шударга ёс эерэг сэтгэлгээний уламжлал

Хүний сайн талыг тэтгэн дэлгэрүүлж муу талыг хатаан хоосруулах нь сэтгэлгээгээр бусдыг удирдах ухаан буюу орчин үеийн менежментийн шинжлэх ухааны ойлголт юм. Иймд сэтгэлгээний уламжлалыг эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хамтатган инновацийн үйл ажиллагаанд ашиглах хэрэгтэй.

Менталитет гэдэг нь бодит байдлын хийсвэр дүр бөгөөд хүмүүсийн ертөнцийг ойлгох, таних, мэдрэх явдлыг тодорхойлж байдаг тогтвортой өвөрмөц систем болно.

Менталитет (от лат. mens and mentis—ум/оюун ухаан/ и лат. alis—другие /холбоотой бусад зүйлс/)⁹²

Монгол хүмүүс энэ утгаараа дэлхийн аль ч үндэстнээс ихээхэн ялгаатай.

Нүүдлийн иргэншилд зохицсон сэтгэлгээ, нийгэм, төрийн байгуулал нь монголчуудын менталитетыг тодорхойлсоор ирсэн.

Монгол хүний менталитетыг нэлээд эртний үеэс улируулан философийн үүднээс судалсан нь доктор Н.Хавх гуай **менталитет** гэдэг үгийг “**унаган төрх**” гэсэн монгол нэр томъёогоор оновчтой тодорхойлсон байна.

Доктор Н.Хавх монгол хүний сайн талуудыг: “нэг чигт шударга шулуун гүндүүгүй байдал, бусдыг хуурч мэхлэх, залилах явдалгүй бат үйл, бусдыг тэтгэх болон бусдаас харж хүлээж хүсэх хиргүй тунгалаг сэтгэл, ах зах дээд хүмүүст үзүүлэх сэтгэлээ дагасан хүндэтгэл, бусдыг сэтгэлээрээ шууд мэдрэн таних онцгой чадвар, өрөвч зөөлөн харимтгай сэтгэл, бусадтай хиргүй цагаан сэтгэлээр харьцах харьцаа, сэтгэл санааны их эрч хүч, эрмэлзэл тэмүүлэл” хэмээн тодорхойлжээ. Харин муу талуудыг: “өрх гэрийн хүрээнд ураг төрлийн хүмүүсийн харьцаагаар бий болсон хязгаарлагдмал үзэл бодол нь өөр хүрээлэлд таарч тохирохгүй болоод ирэхлээр хямардаг, түүнээс гарахын тулд тэр үедээ тархи толгойгоо эрч хүчтэй далайцтай ажиллуулна, ухаан бодлоо сийлнэ, тэр хэрээр хурдан түргэн хямралаас гарах арга замыг олно; харин энэ хооронд үе үе туйлширна, өрх гэрийн хүрээнд төлөвшин бий болсон үзэл бодол, шинж, унаган төрхөөсөө огцом эрс ухарч, бусдыг дуурайн, тэднийг аялдан дагана, эс дагагсдыгаа хавчиж шахна, овжин зальтай, хуурч мэхлэх, итгэл

⁹¹Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он,

⁹²Mentalitet., Wikipedia.org

алдуулах, хувиа хичээх явдлыг чухалчлан сонирхоно, залуус нь эцэг эх, ахмад үетэйгээ, эхнэр нь эр нөхөртэйгөө эвдрэлцэж, тэд нь ч үр хүүхэд, залуу үе, эхнэртээ итгэх итгэлээр тааруу болно” хэмээн дүрсэлжээ.

Монгол хүний менталитетын талаар хятадын эртний сурвалжууд, гадаадын жуулчид (Марко Поло, Плано Карпини, Гильом де Рубрук нарын аян замын тэмдэглэл, судлаач М.И.Майский, Николай Михайлович Пржевальский Н.Р.Рерих, нарын) нарын зохиол бүтээлд тодорхой дурдсан байдаг.

Манай улсад Менталитетын суурь өөрчлөлт хоёр удаа болсон бөгөөд нэг дэх нь монгол хүний “уламжлалт” хэв маягаас “социалист” монгол хүн болон өөрчлөгджээ. Удаахь суурь өөрчлөлт нь 1990-ээд оны өөрчлөлт шинэчлэлээр эхэлж одоо үргэлжилж байгаа “социалист” монгол хүн “капитал шүтсэн иргэншсэн” монгол хүн болон өөрчлөгдөх үйл явц болж байна.

Уламжлалт, социалист, капиталист /иргэншсэн/ гурван хэв маяг хүний амьдралын гурав, дөрөв үеийн дотор солигдсон нь монгол хүний менталитет, тухайлбал үнэт зүйлс, сэтгэлгээ, зан араншинг ихээхэн зөрчилтэй, тодорхойгүй, чиг баримжаагүй болгож, нийгмийн харилцааг үлэмж зөрчилтэй бөгөөд ихээхэн онцлогтой болгож байгаа юм.

Монгол хүн харизматик удирдагчийг хайх, төрийг төлөөлсөн хувь хүнийг төртэй адилтгах менталитеттай байдаг нь тухайн хувь хүнийг бусдаас үлэмж илүү, жирийн бус гэж үздэг явдал нь менталитетын хамгийн тааруу шинж юм. Иймээс жир бус хүн буюу дарга болох туйлын дуртай, өөрөөсөө дээш хүнийг дагалдаж амьдрахыг илүүд үзнэ.

Тэгсэн атлаа өөрийнх нь хувь заяаг өөрөө биш, төр шийднэ гэдэгт итгэлтэй байдаг учраас төрийн бодлогод нөлөөлөх оролдлогыг бараг илүүц зүйл мэт ойлгоно.

Дээд албан тушаалтанд гомдлоо мэдүүлэх, өргөдөл бичих, зарга хийх хэлбэрээр аливаа асуудлыг шийдвэрлүүлэх дуртай. Энэ нь албан тушаалтныг аялдах, ойртох, хүлцэнгүй байх, долигнох, бялдуучлах сэтгэл зүйг бий болгодог.

Өөрөөр хэлбэл манайд рациональ сэтгэлгээ гэхээсээ логик бус сэтгэлгээ давамгайлж нэг хүнийг тахин шүтэх үзэгдэл удаа дараа гарсан нь санамсаргүй явдал биш.

Иймээс “дээрээс”, “төрийн бодлогоор”, “нэг шугамаар”, “нэг төлөвлөгөөгөөр” хийж буй зүйлд тун хүлцэнгүй ханддаг, ийм зүйлийг хүлээдэг, бараг дуртай гэж хэлж болно.

Манай өнөөгийн хууль, тогтоомж, бодлого шийдвэр ч менталитетын ийм нөхцөлийг хуульчлахгүй байгаа нэн даруй өөрчлөх цаг болсон.

Эндээс төрийн нэрээр далайлгах, сүржигнэх, албархах, мэдэмхийрэх, бусдаас дээр гэж харагдах, эрх ямба хүндлэл шаардах, зэрэг зиндаагаараа дээрэлхэх, тансаглах, дээдсийг дуурайх зэрэг **менталитет** үүсдэг.

Ийнхүү сөрөг шинж байгаа ч Монголчуудын нүүдлийн иргэншлийн доторх оюуны өвөрмөц нэгэн бүтээл, шилдэг уламжлал туршлагын нэг бол яах аргагүй сурган хүмүүжүүлэх сэтгэлгээний ухааны зэрэг олон сайн шинж түүнийгээ ашиглах аваас улс ороноо, хүнээ хөгжүүлэх бүрэн боломжтой билээ.

Сэтгэцийн үйл ажиллгаа, сэтгэлийн зоригдолын үр дүн нь сэтгэлгээ юм. **Сэтгэхүй бол хүний оюун ухааны дээд эрэмбэт үйлдэл, хүний ухамсрын хамгийн хөгжингүй хэлбэр мөн.** Хүн оюун сэтгэхүй, сэтгэлгээний ачаар юмс үзэгдлийн мөн чанар, учир утгыг ухааран таньж, байгаль, нийгэм, хүмүүнтэй харилцах олон талт харилцааг тогтоож, нийгмийн оюуны үнэт баялагийг бүтээдэгт оршино.

Харамсалтай нь бид өнөөдрийг хүртэл хүмүүний ерөнхий шинж төлөв, сэтгэл зүйн нийтлэг онцлогтой холбон монгол хүний уг гарвал шинж, төрц төрх, оюун сэтгэлгээний онцлог хэв маяг, монгол хүний шинжийн өөр бусдаас (үндэстнээс)

ялгарах ялгаа, оюун сэтгэхүйн давуу ба дутмаг талыг шинжин судлаагүй байсаар байна.

Хүн судлал, биологи, анагаах ухаанд “монголиод” гэсэн хүний ген бүлэг буй.

Монголын нийгмийн хөгжлийн түүхийн урт удаан хугацааны цагийн шугам дээр монгол улсын иргэдийн боловсрол, сурган хүмүүжүүлэх сэтгэлгээнд гарч байсан ололтыг анхаарах хэрэгтэй эртний ба дундад үе, орчин үе гэсэн ерөнхий гол гурван томоохон үед хуваан үзэж болмоор байна⁹³. Үүнд: **Нэгдүгээр** үеийг монголчуудад сурган хүмүүжүүлэх үзэл санаа бүрэлдэн тогтсон үе, Аливаа хүн хүч чадалтай байвал өрсөлдөгч дайснаа амархан ялж дийлнэ гэсэн тийм үзэл санаанаас шалтгаалж монгол сурган хүмүүжүүлэх сэтгэлгээнд баатарлаг үйл, баатарлаг сэтгэлгээ дамамгайлах хандлагатай гарч ирсэн.

Хоёрдугаар үеийг монголчуудад гэгээрэл боловсрол соёл нэвтэрсэнтэй холбоотой сурган хүмүүжүүлэх үзэл санаа нь улмаар сэтгэлгээний түвшинд боловсорч хөгжсөн үе, дорно дахины олон хэлнээс үлэмж тооны ном орчуулж хэвлэсэн, шашны ба төрийн сургуулиуд байгуулагдан шашин төрийн хос ёсны боловсрол хөгжсөн гээд яривал монголын гэгээрэл боловсролын хөгжлийн чухал үе хамаарагдана.

Гуравдугаар үеийг монголчууд өнөө үеийн боловсрол мэдлэгийг эрхэмлэж үр хүүхдээ бүх шатны сургуулиар хүмүүжүүлэн сургах болсон үе.

Монголчуудын хүнийг шинжин таних, үнэлэх, хөгжүүлэх, төлөвшүүлэх үзэл санаа, сэтгэлгээнд сурган хүмүүжүүлэх үзэл санаа хэдий үеэс үүсэн бүрэлдэж тогтсон нь ихээхэн сонирхолтой юм.

Ер монгол айл гэрт монгол хүн төлөвшсөн бүхий л үйл явц эрт үеэс өнөөдөр хүртэл уламжилж ирсэн бөгөөд монголын уламжлалт сурган хүмүүжүүлэх ухаанд “гэр бүлийн хүмүүжил” гэх буюу “Гэрийн хүмүүжил”, “Гэрийн сургууль” гэх нэр томъёо нэгэнт хэвшин тогтсон нь гэр бүл, ураг төрлийн харилцаа үүссэн нь сурган хүмүүжүүлэх үзэл санааны хөгжлийн бодит үр дүн мөн.

Тухайлбал: Монголын сурган хүмүүжлийн үзэл санааны түүхийн эхлэлтийг “Монголын нууц товчоо”-нд ...Алунгоо эх таван хөвгүүдээ сургасан домог үлгэрийн өгүүлэмж, үзэл санаатай холбон тайлбарлах явдал ч буй.

Алунгоо эх бол Чингисийн 11 дүгээр үеийн дээдэс болох Добу мэргэний эхнэр бөгөөд таван хөвгүүн төрүүлж тэднийгээ “хамт нэгэн эетэн” болгож, “хар тэргүүнт хүнтэй” адилтагшгүй, хамгийн хаадын залгамж болгон өсгөн хүмүүжүүлсэн алдарт эх болно. Өүлэн эх ч урьдын Алун гоо эхийн хүүхдээ сургасан 5 сумны үлгэрийг сурган, хавт Хасар, Тэмүүжин нарыг эвтэй найрамдалтай явахыг нэг бус удаа сануулан сургаж байсан домгийн сурган хүмүүжүүлэх үзэл санааны онцгой ач холбогдол оршино.

Амь зуулгын амьдралд эрчүүд чухал үүрэгтэй байсан болохоор эр хүнийг дээдлэх, эр бяр, биеийн хүч тэнхээг эрхэмлэх үзэл давамгайлж байжээ.

Тухайлбал: 1224 оны орчим холбогдох “Чингисийн чулууны бичиг” хэмээн түүхэнд алдаршсан бичээст нэгэн их найр хурим үеэр Чингисийн нэгэн баатар цэрэг эр 350 алд газар байг мэргэн онож харвасан Есүнхэйг алдаршуулан нь эртний монголчуудын үзэл санаанд ямар хүнийг төгс сайн эрийн загвар болгож, үнэлж загвар жишээ болгож, ийм хүнийг сурган бэлтгэхэд тэр үеийн төр улсын болон иргэний боловсрол сургуулиудын эрхэм зорилго чиглэж байжээ.

Чингис хаан нэгэнтээ “**Морин дэл дээрээс Засгийг байгуулах амархан, харин мориноос буугаад Засгийг төвшитгөх бэрхтэй**” хэмээн айлдсан нь дайн тулалдаанд ялалт, ялагдал хүлээх нь хоромхон зуурын хэрэг байдаг бол харин Засгийг энхжүүлэн тогтоож барих нь алс хэтийн, өнө мөнхийн, хүнд сорилт, хүчир ажил болохыг хэлсэн хэрэг юм.

⁹³Ч.Жүгдэр, “Монголчуудын гүн ухааны сэтгэлгээний түүх”, Л.Түдэв “Монголын уран зохиолын үндэсний болон нийтлэг шинж”, С.Дулам “Монгол домог зүйн дүр”, А.Очир, Д.Чулуунжав нарын бичсэн “Монголын төрт ёсны уламжлал, улс төрийн сэтгэлгээ”

Засгийн хүний шинж, засагт алба хаших түшмэл хүнийг сонгох, сургах боловсруулах бүхэл бүтэн сургалтын тогтолцоо энэ үеэс бий болжээ. Монгол ардын сурган хүмүүжүүлэх ухааны өвд “Хаан хүний 35 эрдэм”, “Түшмэл хүний 15 эрдэм” гэж байдаг нь чухамдаа засаглах хүнийг шинжих, таних, боловсруулан сургах чухал заавар юм.

Монгол оронд хүн ард, хүүхэд залууст боловсрол мэдлэг, мэргэжил олгох зорилготой 3 хэв шинжийн сургууль боловсролын өвөрмөц тогтолцоо байсан. Тухайлбал: 1. Үндэсний хэл бичгээр уншиж бичих, тоо бодох, зурах, урлах, бие махбодыг тамиржуулах, хүмүүжүүлэх зорилготой иргэншсэн суурь боловсрол олгох гэрийн сургууль, 2. Хууль цааз, засаг захиргааны боловсрол олгох буюу төрийн түшээ, тамгын ажилтныг бэлтгэх төрийн сургууль, 3. Түвд хэл бичиг зааж шашны суурь боловсрол эзэмшүүлэх буюу сүм хийдэд хурлын лам нарыг бэлтгэх шашны сургууль тус тус сургалт хүмүүжлийн үйл ажиллагаа явуулж байжээ.⁹⁴

“Амьдрал ахуйд хүүхдийг дуурайлган хөтөлж, өөрт нь байгаа чадварыг хөгжүүлэх сургалт явагддаг, Гэрийн сургуульд тусгай багшид шавилуулан ахуйд олж авсан мэдлэгтэй нь хослон, зарим үед түүнийг гүнзгийрүүлэн лавшруулах, зарим тусгай мэргэжлийг олгодог, ордны сургуульд шилж сонгосон хүүхдийг тусгай эрдэм эзэмшсэн багш нар журамлах эрдэмд сургадаг, сүмийн сургуульд эрхшээх амьдралын нь суурь болох мэдлэгийг олгодог, зориуд чиглэлтэйгээр /зурхай, анагаах гэх мэт/ сургадаг, зарим мэдлэгийг лавшруулж, танин мэдэхүй, шинжлэх ухааны зарим мэдлэг олгодог, төрийн сургуульд чиглэсэн зорилгоор гол нь тодорхой шинжлэх ухааны мэдлэг олгодог буюу уламжлалт мэдлэгийг нэлээд цэгцтэй тогтолцоот байдлаар сургадаг байжээ”⁹⁵

Чингис хаан Засгийг засаглах ёсыг Тангуудтайн Гоо сэцэнээс асуусанд: Хаан хүнээс засаглах ёс нь **“нар мэт үл хождуулах, нуур мэт үл голон хатуужих буй”** хэмээсэн ажгуу. Үүний тайлбарыг 3 өдөр эс олсонд Гоо сэцэн Хаан хүнийг нар мэт бүү хождуул хэмээх минь наран ургаваас сайн ба мууд, амьд ба үхсэнд тэгш харуул гэгээнээ хүргэюү. Хаан хүн тэр мэт тэгш сэтгэлт боловоос их улсын дуран яахин хочирху, нуур мэт бүү гол хэмээх минь нуурт сайн ба муу бээр усанд орьюу. Сайн муу адгуусан усан ороод буртагдаваас нуур тэд бүгдийг үл голон шингээюү. Хаан хүн тэр мэт сэтгэл сайн, муу бээр үг сонсвоос үнэн худал зан, гүехэн үгс сонсвоос өргөс хатгах үгэнд үл орон тэгш болгож сонсвоос их улс яахан эвдрэх хэмээсэн ажгуу.⁹⁶

Энэ мэтээр Засгийн үйл хэрэгт олон эрдэмтэн мэргэдтэй зөвлөж байв.

Сэтгэгч **Аристотел** “Полис бол нэгдэл энэ нэгдэл Шударга үнэн бол улс гэрийн салшгүй хэсэг, нийгмийн нэгдлийг цэгцлэн байгуулагч эд юм”⁹⁷.

Тэрбээр Уул хад, ой модоор алхаж явах зуураа байгалийг ажиглан юмс үзэгдлийг танин мэдэж тэрхүү ухаанаар сурагчиддаа лекцээ уншдаг байсан ба энэ арга барил заншлаас нь үүдэн сургуулийг нь **перипатетик** сургууль гэж нэрлэцгээсэн. Аристотел тухайн үедээ байгалийг ажиглан танин мэдэж сургалтаа явуулж байсан тул өнөө үед түүний заах арга зүйг дэлхийн суралтын байгууллагууд нэвтрүүлж эхлээд байна.

Чингис хааны бага хүү Толуйн их хатан Ван хаан Торилын Жаха-Хамбын бага охин Соргагтани хатан Чингис хааны шударга чиг сургаал, захиас даалгавраар үр хүүхдүүдээ чинхүү шударга журам, ёс дэг, хатуужлаар хүмүүжүүлсэний зэрэгцээ харц ард, шашин мөргөлтөн нарт ихээхэн энэрэл, нигүүлсэнгүй ханддаг байсан. Хатан өөрөө Христос шашинд сүсэгтэй байсан хэдий ч Исламын шашиныг нэгэн адилаар энэрч 1240 оны үед мянган уут шижир алт өгч (Бухара, анх Согд хэлнээ **βuxārak** «заяат

⁹⁴Их эрдэмтэн Б.Ринчин “Монгол бичгийн хэлний зүй”-н тэргүүн боть

⁹⁵Дашням.Л, 18 дахь тал.

⁹⁶Лувсанданзангийн Алтан товч

⁹⁷*Great Issues in Western Civilization (volume I) Politics by Aristotle*

газар» гэж байсан бололтой) эртний түүхтэй, өдгөө Узбек улсын Бухар хот “хатны сургууль”⁹⁸ байгуулж 1000 хүүхэд сургаж байсан бөгөөд өнөө ч хэвээр бий.

Хубилай хаан 1264 онд Их Юань гүрнийг байгуулсаны дараа их гүүш Пагваг дэргэдээ суулган дөрвөлжин үсгийг зохиолгон түүнийг Монголын шинэ үсэг хэмээн хэрэглүүлэхээр болж нийслэл Кей-пин (одоогийн Бээжин)-д 1230-аад оноос эхлэлтэй анхны сургууль байгуулж “**Төрийн хөвгүүдийн**”⁹⁹ болон “Күнзын” сургууль гэж нэрийдсэн бөгөөд одоо энэ сургууль түүх дурсгалын үзүүлэн газар болсон байдаг.

Тэрхүү сургуулийн үүдэнд байх самбарт 50700 (тавин мянга долоон зуун) хүн амжилттай сайн суралцаж төр засгийн ажилд оролцож байсан гэх түүхэн баримтад тэмдэглэн үлдээжээ.

Шашны гүн ухааны сургуулиудад “**ухааны таван их орон**” гэдэг хичээлийг голлон судалж байв. Тэдгээр нь:

1. Үг, дууны эндүү ташааг арилгагч дуун ухаан буюу хэл шинжлэл
2. Үг, утга, агуулгын эндүү ташааг арилгагч учир шалтгааны ухаан буюу логик
3. Эрүүл энх, урт удаан наслахыг бүтээгч тэжээхүй ухаан буюу анагаах ухаан
4. Бие, хэл сэтгэлийн урлагийг бүтээгч урлахуй ухаан буюу урлаг судлал
5. Амьтны дотоод сэтгэлийг засамжлан боловсруулах дотоод ухаан буюу гүн ухаан зэргийг багтаан үздэг.

Үүнээс гадна “**ухааны таван бага орон**” гэдэг эрдмийг судлан үздэг. Үүнд:

1. Зохиол ба зохиолын үгийг чимэглэхүйд мэргэжүүлэгч яруу найраг
2. Шүлэглэн холбох ёсонд мэргэжүүлэгч холбоо найраг
3. Эрт цагийн олон үлгэр, домог ба үлгэрийн гаралтай нэр томьёолол мэргэжүүлэгч ёгт үг
4. Эртний хүн, хүн бусын үлгэр домгийн тус тусын хэлээр үзүүлэгч өгүүлэн бүжиглэхүй
5. Огторгуйн олон ба ил, далдын авах, орхихуйг шинжлэн мэдүүлэгч одон зурхайн ухаан зэрэг арван ухааныг тус тус үзэж судалдаг байжээ¹⁰⁰.

Хүн төрөлхтөн үр хүүхэддээ сайн хүн болохыг чухалчлан сургаж, төрийн түшээдээсээ шударга ёсыг шаардаж, бие биенээсээ хүндлэл хайрыг хүсэмжилж, нэгэн дэлхийд нэгэн нарны доор өөр өөрсдийн соёл, ёс заншлаар амьдралыг цогцлуулсаар... Ингэхдээ хүмүүсийн зан араншин, биеэ авч яваа байдал, үйлдлийн сайн мууг ялган салгах, үүргээ хэрхэн биелүүлж байгаа байдал зэргийг ёс зүй хэмээх ойлголттой холбон ойлгож нэгэнтээ даджээ.

Ёс зүй хэмээх энэ ойлголт нийтийн дунд амьдарч, бусадтай харилцаж байгаа иргэн хүний эргэцүүлэл, ухаарал бодлоос өгсүүлээд эрдэмтэн мэргэдийн сургаал, үзэл баримтлал оюун ухаанаа уралдуулсан өргөн цар хүрээтэй, энгийн мөртлөө нарийн асуудлуудыг хамаардаг ба хүн төрөлхтний анхаарлын төвд байсаар ирсэн юм.

Эрдэмтэн мэргэд хүмүүсийн сайн сайхан аж байдал, аз жаргал, сайн үйл, сайн зан чанарт илүүтэй их ач холбогдол өгч, энэ тухай зохиол бүтээлдээ туурвиж байсан.

Дорно дахины болон монголын зарим гүн ухаантнуудын ёс зүйн талаархи сургаал, үзэл баримтлалаас та бүхэнд толилуулъя.

Энэтхэгийн их сэтгэгч **Нагаржуна (МЭ 150-250)**-гийн ёс суртахууны сургаалууд онцгой байр эзэлдэг. “Гайхамшигт оюунт мэргэдийн дотроос Энэтхэгийн төрүүлсэн их ухаантны нэг Нагаржуна онцгой”¹⁰¹ гэжээ.

⁹⁸Рашид ад-дин /1247-1318/ Судрын чуулган

⁹⁹Р.Сайшаалт Чингис хааны товчоон 1987

¹⁰⁰“Эдүгээ хүн төрөлхтөн тэнгэрт шувуу мэт нисэж, далайд загас мэт сэлж сурчээ. Гагцхүү газар дээр хүн ёсоор амьдарч хараахан сураагүй байна” гэж **Бернард Шоу** хэлсэн(Джордж Бернард Шоу ([англ. George Bernard Shaw](#), [26 июля 1856 года](#), [Дублин](#), [Ирландия](#) [2 ноября 1950 года](#), [Хартфордшир](#), [Англия](#))

¹⁰¹Неру Ж. Открытие Индии. М., 1957 х.17/

Хүн өөрийн багтаж буй хорвоогийн ёсыг үргэлж тунгаан баримталж явах тухай хаан түшмэл, харц иргэн тус бүрт зориулсан сургаалийг Нагаржуна туурвижээ. Хаан хүнд зориулсан “Эрдэнийн эрх”, хан хөвүүнд зориулсан “Захиа бичиг”, түшмэлд зориулсан “Зуун билигт”, “Билгийн гол модон”, нийт иргэдэд зориулсан “Ардыг тэжээхүй дусал” зэрэг сургаалийн зохиолууд бий.

Эдгээр сургаалийн зохиолдоо тэрээр цаг үеийнхээ аясыг даган хаан эзэн, төрийн түшмэл, жирийн иргэдийн эрхлэх үйл, зан араншингийн шинж чанар ямар байхыг зааж сургасан байна.

Жишээлбэл: Хаан хүн “бие, хэл, сэтгэлийн аливаа үйлсээ ямагт сайтар шинжиж, бусдад туслахыг голлон эрхэмлэ” гээд билиг эрдэмд суралцах, сургууль бичгийн ажил зохиох, хөгшид нялхсыг асрах, өвчтөнийг эмчлэх, ядууст өглөг өгөх ажлыг хаан төрөөс анхааран зохиохыг онцолж, “**жаргаланг өгөхөөс илүү өглөг үгүй**” хэмээн бичжээ¹⁰².

Нагаржуна “Ардыг тэжээхүй” шашдиртаа төв шударга байх, худал үл хэлэх, хуурмаг зан үл гаргах, омогдон хилэгнэх, эд мөнгөнд шунахайрахыг тэвчих, эрдэм ном хичээн сурахыг заасан байдаг. Түүнчлэн хүний ёс суртахууны шилдэг шинж гэж дараах зүйлийг заан сургамжилжээ.

“Сайжран дээшлэхийг хүсэгчид залуугаас эрдэм сур

Сааль сүүг эдлэхийг хүсэгчид өвлөөс үнээ тэжээ

Сайн тариа идэхийг хүсэгчид хавраас хөрөнгө тарь

Сац энэ гурвуул үрийн үрийг амсахын шалтгаан бий”¹⁰³ гэжээ.

Энэтхэгийн их сэтгэгч Нагаржунагийн ёс суртахууны номлол нь нийгмийн гишүүн бүрийн үүрэг хариуцлагыг ухамсарлуулах, бүх нийтийг ёс суртахууны эерэг сайн чанараар хүмүүжүүлэх тухай утга төгөлдөр санааг гаргаж тавьсан нь олон зууны туршид уламжлагдан иржээ.

Конфуций буюу **Күнз (МЭӨ 551-МЭӨ 479)** төгс бие хүн гэдэг нь сайн үйлтэй, сайхан сэтгэлтэй, үнэнд тэмүүлдэг, шударга, оюуны соёлоор баян гэх зэрэг шинж чанаруудтай байх ёстой ажээ.

...Аливааг тодорхой олж үзэхийг ...Андуггүй зөв сонсохыг

...Царайгаа ямагт урин тааламжтай харагдуулахыг ...Хийж байгаа алхам бүр нь бусдад хүндэтгэл төрүүлхүйц байхыг

...Үг яриа нь үнэн голоосоо төрөн гарахыг ...Үйл хэрэг нь болгоомжтой няхуур байхыг

...Уурлаж хилэгнэснээс хожим ямар нөлөө гардгийг зайлшгүй санаж явахыг

...Ямар нэгэн ашиг, завшаан тохиолдох үе таарлаа гэхэд шударга ёсыг хэзээд баримтлах зэргийг Күнз ариун сурталт, төгс бие хүний эн тэргүүнд бодож явах 9 зүйл хэмээн тодорхойлжээ.

Монголчуудын дундаас төрөн гарсан суут ухаантнууд ёс зүйн асуудалд мөн л онцгой анхаарал хандуулж байлаа.

Говийн ноён хутагт хэмээх Данзанравжаа (1803-1856) хүмүүний нийтлэг чанарыг харуулсан олон бүтээл туурвисан байдаг.

Түүний гол үзэл нь хойч үеийнхнийг ертөнцийн аливаа ёс, ард түмнийхээ зан заншлыг мэддэг, хүнлэг нийтэч зан чанартай болгоход оршиж байв¹⁰⁴

Түүний “Цаасан шувуу”, “Сэтгэлийг амраагч хэмээх сургааль”, “Дөрвөн улирал”, “Олон хөгшид хүүхдийн хэлэлцдэг үгсийн товч хэмээх сургаал оршив” зэрэг зохиол бүтээлд нь дээрх үзэл санаанууд нь тусгагджээ.

¹⁰² Лувсан цэрэн Г. Төв үзэл түвшин бодлого УБ., 1994х. 3/

¹⁰³ Мөн тэнд

¹⁰⁴ Ц.Бүжидмаа. Боловсролын философи. УБ., 2002 он. х.124

Ялангуяа “Цаасан шувууны үлгэр” гэх сургаалд бие хүний сайн, муу зан чанаруудын тухай тодорхой хэлсэн байдаг. Жишээлбэл:

... Үл мэдэгч муухай, ... Саруул ухаан сайхан,

... Өст сэтгэл хортой, ... Сайхан сэтгэл тустай.

... Ёстныг хүндэл, настныг баярлуул, ачтанаа эрэх, бачтанаас зайл, сайнаас бүү сал, садныг бүү эр, олныг бүү арилж ... муу нөхөртэй бүү нөгц, зүйл бүрийн хувцас бүү өмс, зүг талгүй бүү гайхуул. ...

... Хордон бусдын гэмийг бүү малт ... “Ховсорч хэрэггүй үг бүү зөө

... Самуун хүнтэй бүү учир ... Санасан бүрийг бүү итгэ

Тэр энэ гэж бүү эрэлх ... Тэгэх ингэх гэж бүү зарла” гэж хүний бие авч явах байдал, ёс зүйн дэг жаягийг нарийн тодорхой зааж өгснөөс гадна бие хүн төлөвших үйл явцад хувь хүн өөрийгөө залж жолоодож, өөрийгөө хүмүүжүүлэх нь онцгой нөлөөтэй гэсэн санааг тод томруун илэрхийлсэн байдаг.

Мөн Монголын буддын гүн ухааны нэрт зүтгэлтэн, яруу найрагч **Зая бандид Лувсанпирэнлэй(1642-1715)** төгс төгөлдөр иргэн хүн болж төлөвшихөд нэн чухал ёс суртахууны 10 дүрмийг зохиосон байна. Үүнд:

Биеийн 3 гэм: амь таслах, эс өгснийг авах, ариун бус явдал,

Хэлний 4 гэм: худал хэлэх, ширүүн хараал хэлэх, дэмий чалчааг өгүүлэх, хов ярих,

Сэтгэлийн 3 гэм: хомголзох сэтгэл, хорлох сэтгэл, буруу үзэл зэрэг болно.

Энэхүү 10 гэмийг тэвчсэний нөгөө тал нь 10 буян болох бөгөөд ингэж гэмийг ухаарч эрдмийг хичээснээр зөв хүн болж төлөвшинө гэж үзэж байжээ.

Тэрээр хүний муу чанарыг өгүүлэхдээ чалчаа хүнийг шаазгайтай, арга бачит хүнийг үнэгтэй, олз хайгч хүнийг хулгайчтай адилтгасан бол сонсох санах эрдэм ихтэй хүнийг нартай, ухаан бодол уужим хүнийг огторгуйтай адилтгасан нь хүний ёс суртахуун, оюун ухааны чадварыг өндрөөр үнэлсэн хэрэг байлаа¹⁰⁵.

Ийнхүү Дорно дахины ёс зүйн сургаал, үзэл Эш ухааны гол цөм нь “хүнийг эхлээд ертөнцийн дотор зөв амьдруулж сургаад дараа нь номын ёсонд сургах” гэсэн санаа байсан бөгөөд энэ нь тэр үеийн мэргэдийн зохиол бүтээлүүдийн ихэнхид нь тусгалаа олж өнөөг хүртэл уламжлагдан ирсэн гэдгийг санах хэрэгтэй болжээ.

Дүгнэлт

Эрх зүйн шинэтгэлийн үйл явц нь өргөн хүрээний цогц судалгаа, шинжилгээний үр дүнд үндэслэх ёстой ба цогц байдлаар дүгнэн хэрэгжүүлэхгүй байх аваас эсэргүүцэл, бэрхшээл салахгүй. Үүнийг засах арга, уламжлал байгаа тул судалгааны үндсэн дээр нэн даруй хэрэгжүүлэх (төрийн албаны мерит зарчим) шаардлага байна.

Иймд эрдэм шинжилгээний их дээд сургууль, салбарын яамд, засгийн газар, мэргэжлийн байгууллагууд, үйлдвэрлэгчдийн хоорондын хамтын ажиллагааны механизм огт байхгүй байгааг анхаарах хэрэгтэй болжээ. Өөрөөр хэлбэл Монгол Улс үндэсний инновацийн тогтолцоогоо өнөөг хүртэл бүрдүүлж чадаагүйбайгаа нь судалгаа шинжилгээний ажлын үр дүн амьдралд нэвтрэх боломжгүй.

Төр-засаг ухаалаг байхын нэг гол үндэс нь итгэл даасан, найдвартай судалгааны байгууллагуудтай байж судалгаа шинжилгээнд тулгуурлан бодлого боловсруулах соёл, сэтгэлгээ, үйл ажиллагаанд ихээхэн ач холбогдол өгч их хурал, салбарын яамдад бодлого боловсруулах үндэслэл, хувийн хэвшилд хөрөнгө оруулалтын чиг баримжаа болох технологийн судалгаа зайлшгүй хэрэгтэй байна. Бид өнөө хэр салбар бүрээр техонлогийн тухайд баримтлах бодлогоо тодорхойлж чадаагүй л байна.

¹⁰⁵Хүрэлбаатар Х. Огторгуйн цагаан гарди УБ.,1996. х. 90

Герман улсад бодлогын судалгааны 135 хүрээлэн байгаагийн олонх нь эдийн засаг, эрх зүйн чиглэлээр ажилладаг ба дунджаар зуугаас дээш тооны ажиллагчидтай, жилд дунджаар 451 сая еврогоор санхүүждэг (зарим судалгааны байгууллагын санхүүжилт их өндөр дүнтэй).

АНУ-д бодлогын судалгааны чиглэлээр 1500 хүрээлэн ажиллаж, гол 15 хүрээлэнгийн жилийн дундаж санхүүжилт нь 32.8 сая доллар.

Монгол Улс даяар төсвөөс судалгаанд зарцуулж байгаа зардал Израйлийн бол 2-оос гурван эрдэмтний, Шведийн бол 5-аас 6 эрдэмтний л зардалтай тэнцэхээр байгааг анхаарах цаг нэгэнт болсон.

Санал:

Эрх зүйн шинэтгэлийн үйл ажиллагааны хүрээнд илтгэл болон дүгнэлтэд тусгагдсан асуудлууд нь манай улсын эдийн засаг, эрх зүйн бодлогод тулгамдсан хүчин зүйл гэж үзэж, нэн даруй хуульчлах шаардлагатай гэж үзсэн доорхи саналыг багцлан дэвшүүлж байна.

1. “Эрх зүйн шинэтгэл”-ийн хүрээнд УИХ хөгжлийн хэтийн нэгдсэн бодлого, нэгдсэн хөтөлбөр, ерөнхий хууль, салбар хууль батлахдаа Засгийн газар, Агентлаг, нэгж, судалгааны байгууллага, судлаач нарыг хамруулах боломжит эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх,
2. Улсын хэмжээнд Сэтгэцийн эрүүл мэнд, судалгаа шинжилгээний байгууллагуудыг эдийн засаг, эрх зүй, хүний нөөц, сургалтын хувьд хөгжүүлэх,
3. ШШХ-ийн бүтэцэд “Хүн судлалын шинжлэх ухаан”-ы нэгж байгуулах, бэхжүүлэх,
4. Судалгааны байгууллагуудыг бодлого боловсруулах үйл ажиллагаандаа оролцуулах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх,
5. Засгийн албанд ажиллаж байгаа болон ажиллах сонирхолтой хүн бүр жил бүр сэтгэцийн иж бүрэн үзлэг шинжилгээнд хамруулж, нэгдсэн дүгнэлтийг мэдээллэж байх тогтолцоог бүрдүүлэх,
6. Байгууллага бүр алба хаагч бүрийн ажлын байрны сэтгэлгээ, уламжлал, хууль тогтоомжийн бодлогын талаар сар бүр сургалт явуулж хэвшүүлэх, төсвөөс дэмжих тогтолцоог бүрдүүлэх,
7. Хууль сахиулах байгууллагын алба хаагч бүр жилд багц цагийн хичээл судлаж дүгнүүлж байх тогтолцоог бий болгох,
8. Тусгай албад дотоод бүтэцэдээ “сэтгэцийн алба”-тай болох тогтолцоог бүрдүүлэх,
9. Төрийн байгууллагын алба хаагч нараас гэмт хэрэг, зөрчил, дутагдал гаргасан хүний судалгааг гарган, хариу арга хэмжээ зохион байгуулалтыг иргэншилтэй тохируулж хуульчлах,
10. Удирдах алба хаагч бүр хөгжлийн бодлогод нийцсэн өөрийн гэсэн инновацитай байж түүнээ мэдлэг болгох арга хэмжээ авах ажлыг зохион байгуулах тогтолцоог хуульчлах,
11. Олон улсын “EBSCO” эрдэм шинжилгээний хайлтын системд судалгааны байгууллагуудыг нэгдсэн журмаар холбох, хамтын ажиллагааг бэхжүүлэх, эдийн засаг, хүний нөөцийн тогтолцоог бүрдүүлэх,
12. Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтийг нэн даруй өөрчлөх үйл ажиллагаанд судалгааны байгууллага, судлаачдын оролцоонд тулгуурлах зэрэг болно.

**ЦАГДААГИЙН АЖИЛ-ЭРХ ЗҮЙ МЭРГЭЖЛЭЭР СУРАЛЦАГЧ НАРЫН
ХАРИЛЦААНЫ УР ЧАДВАРЫГ ГАДААД ХЭЛНИЙ СУРГАЛТААР
ТӨЛӨШҮҮЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ**



Ч.Батчимэг
ХСИС-ийн ЭЗНУС-ийн Гадаад
хэлний тэнхимийн ахлах багш

Монгол улсын иргэд хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэмд өөрийгөө бүрэн дүүрэн илрүүлэн амьдрах ажиллахад шаардагдах мэдлэг чадвар технологи, соёлыг эзэмших таатай орчин бүрдүүлэхэд боловсролын эрхэм зорилго оршино гэж боловсролын талаархи төрийн бодлогын үндсэн баримт бичигт заасан билээ. Энэхүү таатай орчинг:

- Материаллаг орчин
- Сэтгэл зүйн орчин
- Бүтээлч үйлийн орчин гэж ангилж болох юм.

Гадаад хэлний сургалтаар оюутан сонсогчдыг хөгжүүлэх тэдний ур чадварыг төлөвшүүлэхэд суралцагсдын нас хүйс, мэргэжил, дадлага тулшлага авъяас сонирхлыг нь тооцож байх нь зүйтэй.

Эндээс гадаад хэлээр харилцах бүтээлч үйлийн орчин, харилцааны ур чадвар эзэмшихэд таатай нөхцөлийг бүрдүүлэхэд дөхөм болно. Суралцагч бие хүн нь төрөлх хэл, төрсөн газар орон, үндэстэн ястны онцлог, хүн ам зүйн бодлого /эмэгтэй, эрэгтэй/, ажил мэргэжил гэсэн 5 холбоо хамаарал болох социал тогтолцоонд сурч боловсорч харилцан хөгжиж төлөвшиж байдаг.

Хүн байгаль нийгэмд болон сэтгэхүйн шинжлэх ухаантай бусад хүмүүстэй янз бүрийн орчинд байнгын ухамсартай харьцаанд харилцаж ойлголцож тэр ч бүү хэл гадаад орны орон судлал, түүх соёлыг харилцан судалж байдаг билээ. Хүн хэдий чинээ зөв харьцаа үүсгэж бусадтай боловсон харьцана тэр хэмжээгээрээ юмс үзэгдэлтэй дасан зохицож амьдардаг.

Даяаршил мэдээлэл технологийн эрчимтэй хөгжилийн зуунд гадаад хэлний тэр тусмаа англи хэлний тархац хүрээ өргөжсөөр дэлхийн олон сая хүний харилцааны чухал хэргэлүүр болсоор байгаа өнөө үед улс төр нийгэм эдийн засгийн бүхий л салбар мэргэжлээр мэдээлэл солилцож хамтран ажиллаж суралцах олон боломж нээгдээд байна.

Иймээс гадаад хэлний хичээлээр суралцагсад хэлний мэдлэгээ тасралтгүй хөгжүүлэхийн тулд хэлний мэдлэгээ өөрийн болгон харилцаандаа хэрэглэх нь чухал юм.

Их дээд сургуулийн хэлний бус мэргэжлийн ангийн оюутнуудад гадаад хэлний хичээлийг заах гол зорилго нь тодорхой хэмжээний сууь чадвар, дадалтай болсон оюутан залуучуудын ярих, бичих, унших чадварыг дээшлүүлэхэд оршино. Эдгээр нь цогцоороо харилцааны ур чадварыг төлөвшүүлнэ.

Гадаад хэлийг тухайн сонгосон мэргэжилтэйгээ холбон мэргэжлийн үг хэллэгийг эзэмшиж түүнийг ашиглан харилцах хэрэглээ болгон сурах нь ач холбогдолтой. Хуульч эрх зүйч бол нийгмийн бүхий л салбар хүрээг хамарсан хамгийн нийгэмлэг чухал мэргэжил юм гэдгийг судлаачид тогтоосон байдаг.

Энэ утгаараа хуулийн мэргэжлээр суралцаж буй оюутан сонсогчид сайн боловсон хүчин болохын зэрэгцээ мэргэжлийн өндөр мэдлэг олж авахын тулд харилцааны ур чадварыг маш сайн эзэмших хэрэгтэй. Өөрөөр хэлбэл ямар ч хуулийн байгууллагад ажилладаг хуульч хүний өдөр тутмын ажилд харилцааны ур чадвар ихээхэн хамаардаг байна. Харилцааны ур чадварт хамаарах асуудлыг ерөнхийд нь мэдээлэх өөрийгөө илэрхийлэх ур чадвар, сэтгэн бодох ур чадвар, хоорондоо харилцах чадвар гэж хуваана. Харилцааны ур чадварт хамаарах асуудлыг ерөнхийд нь:

1. Харилцан мэдээлэх өөрийгөө илэрхийлэх ур чадвар
2. Сэтгэн бодох чадвар
3. Хоорондоо харилцах чадвар гэж хуваана.

Сургалтын явцад мэдээлэх, өөрийгөө илэрхийлэх чадвар нь:

- Суралцагсдын боловсон соёлч байх
- Уншиж анализ хийх
- Албан бичиг бие даан боловсруулах
- Бусдад ярьж илтгэх
- Бусдыг хүлээцтэй сонсох зэргээр илэрдэг.

Харин сэтгэн бодох чадвар нь:

- Суралцагсдын хичээлийн идэвхи байр сууриа хамгаалах
- Асуудалд шүүмжлэлтэй хандах
- Үзэл бодлын зөрөлдөөнийг шийдвэрлэх зэрэг хандлагаас мэдрэгддэг.

Хамт олонтой харилцах чадвар нь:

- Бусдад нөлөөлөх
- Зорилгоо тодорхойлж төлөвлөх
- Бусад хүмүүсийг идэвхижүүлэх
- Хамт олны таатай уур амьсгал бүрдүүлэх
- Бие дааж шийдвэр гаргах зэрэг ур чадвараас нь илэрдэг.

Харилцааны ур чадварыг хөгжүүлэхийн тулд эх хэл дээрээ болон гадаадын олон орны хэл дээр мэргэжлийн болоод бусад төрлийн ном унших, орон судлалын өргөн мэдээллийг солилцож мэтгэлцэж байх нь хэлний баялагаа нэмэгдүүлж харилцааны ур чадвараа хөгжүүлэхэд чухал юм.

Бусад орны туршлагыг авч үзвэл Америкийн нэгдсэн улсын нэгэн хуулийн сургуульд communications skills буюу ярианы ур чадварын хичээл 1, 2, 3, 4, 5 гэж ангилан ордог байна. Жишээ нь харилцааны ур чадвар 1 гэсэн хичээлийн зорилго нь:

- А. Суралцагчдад харилцааны сэтгэл зүйг судалж мэдэх чадвар эзэмшүүлэх. Үүнд: хүний зан төлөв, хүмүүст хандах зарчим, бусдад өөрийгөө ойлгуулах, гадаад дотоодын түншүүдтэй харилцах, ёс зүй тэдгээрийн онцлогуудыг судалж мэдэх.
- В. Суралцагчдыг мэдээлэх өөрийгөө илэрхийлэх чадварт сургах. Энэ нь өөрт хэрэгтэй материалыг уншиж гол гогцоо асуудлыг олж шүүмжлэлтэй хандаж сургах.
- С. Бичгийн хэлэнд сургах чадвар эзэмшүүлэх. Тухайлбал: өргөдөл, гомдол, протокол, байцаалт, мэдүүлэг, тушаал, шийдвэр зэрэг албан бичиг захидлыг төлөвлөх зөв алдаагүй найруулга сайтай бичих зэрэг бичгийн чадвар сургах.
- Д. Аливаа санал жүүмжлэл гаргах, шүүмжлэл болон бусдын саналыг хүлээцтэй сонсож тусган авах зэрэг чадваруудыг олгоход оршино.

Харилцааны чадвар 2 хичээл нь сэтгэн бодох чадварыг дээшлүүлэхэд чиглэгдэнэ.

Гэхчлэн харилцааны ур чадварыг хөгжүүлэх 5 ангилалтай хичээл тус бүр нь өөр өөрийн зорилготой ба харилцааны сэтгэлзүйн өвөрмөц онцлогуудыг тусгасан байдаг байна.

Харилцааны ур чадвар нь мэргэжлийн ур чадварыг тодотгож улмаар үр дүнд хүрэхэд тусалдгаараа ач холбогдолтой. Хуульч, эрх зүйч, мөрдөн байцаагч нарын дунд явуулсан судалгаанд хуулийн мэргэжлийн хүнд өдөр тутмын мэдээ тайлан, мэдүүлэг, байцаалт, өргөдөл гомдлыг үндэслэн асуудлыг шийдвэрлэх шаардлага тулгарч байдаг.

Үүнд:

- ✓ Бичиж , тэмдэглэж илэрхийлэх
- ✓ Амаар илтгэж түүнийгээ хамгаалах
- ✓ Өөрийн байр сууриа илэрхийлэх, зөв хамгаалах
- ✓ Тулгарсан эсрэг үзэл санааг ойлгохын тулд бусдыг хүлээцтэй сонсох

- ✓ Маргаантай асуудлыг зохистойгоор шийдвэрлэх
- ✓ Зорилгоо тодорхойлж төлөвлөх
- ✓ Хамт олондоо нөлөөлөх
- ✓ Бусдыг идэвхижүүлэх
- ✓ Өөрөө манлайлах
- ✓ Бусдад хүндэтгэлтэй хандах
- ✓ Ажил хэрэгч байдлаар хандах
- ✓ Шударга үнэний төлөө ажиллах
- ✓ Үнэн зөвийг тогтоох зэрэг болно.

Үүнээс судалгаанд оролцон 150 гаруй хүнээс доорх үзүүлэлтүүд гарч байна. Үүнд:

- ✓ Бичиж , тэмдэглэж илэрхийлэх – 80 %
- ✓ Амаар илтгэж түүнийгээ хамгаалах -60%
- ✓ Өөрийн байр сууриа илэрхийлэх, зөв хамгаалах- 90%
- ✓ Тулгарсан эсрэг үзэл санааг ойлгохын тулд бусдыг хүлээцтэй сонсох -70%
- ✓ Маргаантай асуудлыг зохистойгоор шийдвэрлэх – 85%
- ✓ Зорилгоо тодорхойлж төлөвлөх – 95%
- ✓ Хамт олондоо нөлөөлөх 95%
- ✓ Бусдыг идэвхижүүлэх – 80%
- ✓ Өөрөө манлайлах – 90 %
- ✓ Бусдад хүндэтгэлтэй хандах – 90%
- ✓ Ажил хэрэгч байдлаар хандах – 100%
- ✓ Шударга үнэний төлөө ажиллах – 100%
- ✓ Үнэн зөвийг тогтоох - 100% гэх зэрэг байна .

Гадаад хэлний хичээлээр тухайн мэргэжлийн үг хэллэгийг эзэмшүүлэхээс гадна тухайн мэргэжлийн харилцааны хэрэгсэл талаас нь бодит хэрэглээнд судлах нь нэн чухал юм. Орчин үеийн мэдлэг мэдээллийг хурдан шуурхай хүлээн авах шилдэг арга бол аль ч салбарт ямар ч мэргэжлийн хүн дэлхийн хөгжилтэй орны болон хэрэгцээт мэдээллийн эх сурвалжийг шуурхай дамжуулдаг аль ч орны гадаад хэлийг эзэмших нь хүн бүрийн хичээл зүтгэлээс гадна харилцааны ур чадварыг хөгжүүлэх нь нэн чухал юм.

Хэл бол харилцааны хэрэглүүр мөн гэдэг утгаар гадаад хэлний сургалтыг орчин үеийн болоод ажил мэргэжилтэй холбон зохион байгуулснаар оюутан сонсогчийн харилцааны үг хэллэгийг ашиглан тухайн хэлээр харилцах чадвартай болох юм. Өнөө үед ярианы болон бичгийн соёлтой, өөрийн бодлоо зөв, товч, тодорхой ярьж, бусдад ойлгуулж ярьж сурах нь хүн бүхний хэрэгцээ болж байна.

Иймээс оюутан сонсогчдыг аливаа зүйлийн талаар болон гадаад орон судлалын чиглэлээр өөрийн олж авсан мэдээлэл, бодол санаа, үнэлэлт дүгнэлтээ бүрэн дүүрэн ойлгуулах, бусдын өмнө чөлөөтэй илтгэн ярьж , харьцах харилцааны болон ярианы чадварт сургах нь чухал юм.

Өмгөөлөгчид, хуульчдын өмнөө барих гол зэвсэг бол илтгэх урлаг. Учир нь харилцааны ур чадвар нь тухайн мэргэжлийн чадварыг илэрхийлэгч нь болдог ба гадаад хэлний мэдлэг нь түүний бий болгох мэдлэгийн хөшүүрэг нь болдог. Гадаад хэлний сургалтаар эзэмшиж ухаарч ойлгосон мэдлэг, туршлага хэл, сэтгэхүйн үйлд ашиглан хэл ярианы мэдлэг бүтээх хэрэглээ болгоход танин мэдэх үйл ажиллагаа чухал юм.

Энэ байдлаас үзэхэд гадаад хэлний тахимийн болон танхимийн бус үйл явц нь суралцагчдын тасралтгүй хөгжлийг бий болгож тэдний танин мэдэх үйл ажиллагааг гадаад хэлний сургалтын явцад идэвхжүүлэх боломжтой тул бие биеэс нь салгах боломжгүй байдаг харилцан уялдаа холбоотой юм.

Гадаад хэлний сургалтаар олсон мэдлэг, ухагдахуунаа хэрэгжүүлэх бие даасан танин мэдэх үйл ажиллагаа чухал шаардлагатай болсоор байна. Тухайлбал: Гадаад

хэлээр илтгэх, сонсгол бэлдэх, илтгэх урлагийн арга барил эзэмших, гадаад дууны хамтлагт оролцох, дуу шүлэг тогтоох, уралдаан, тэмцээнд оролцох зэрэг үйл ажиллагаанд манай зарим суралцагсад оролцож амжилтанд хүрч гадаад хэл эзэмших танин мэдэх хэрэглээний сэдэл тэмүүлэлтэй болсоор байгаа билээ.

Гадаад хэлний сургалтаар ярианы чадварт сургах, харилцан ярилцах, давтан ярилцах, бодит байдлыг ярилцах, хэрэг явдлыг ярилцах, уншсан болон цээжилсэн зүйлийг ярилцах, зурагт үзүүлэн харж тайлбарлан ярилцах, тодорхой асуултанд хариулт авч ярилцах зэрэг харилцааны ур чадварыг төлөвшүүлэх зэрэг олон аргуудыг ашиглаж боломжтой байдаг.

ОРЧУУЛАГЫН НИЙТЛЭЛ

ГАДААД ОРНУУДЫН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЦАХИМ ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААР ТУСГАСАН НЬ



О.Нарантуяа

ХСИС-ийн, Төгсөлтийн дараах сургуулийн ГХСБ-ийн дэд профессор, цагдаагийн хошууч

Америкийн Нэгдсэн Улс

АНУ-д мэдээллийн технологийн хүрээнд үйлдэгдсэн гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэх хуулийн төслийг анх 1977 онд боловсруулжээ. Энэ хуулийн төслийг үндэслэн 1984 оны 10 дугаар сард компьютер ашиглан залилан мэхлэх, түүнийг хор нөлөөтэйгээр ашиглах тухай хуулийг баталсан ба компьютерийн мэдээллийн хүрээнд үйлдэгдсэн гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлагын үндсэн хэм хэмжээ болох эрх зүйн актыг тогтоож өгсөн. Компьютер ашиглан залилан мэхлэх, түүнийг хор нөлөөтэйгээр ашиглах тухай хууль нь хэд хэдэн гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүнд хариуцлага хүлээлгэхээр заасан байна.

Үүнд: компьютерийн технологийг ашиглан тагнан турших үйл ажиллагаа явуулах, зөвшөөрөлгүй мэдээлэлд нэвтрэх, залилан мэхлэх, санаатай болон болгоомжгүйгээр хамгаалалттай компьютерийг гэмтээх, сүрдүүлэх, заналхийлэх, дарамт шахалт үзүүлсэн үйлдлүүдэд хариуцлага хүлээлгэнэ.

Цахим гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлага нь мөнгөн торгууль буюу хорих ял оногдуулдаг. Үйлдсэн гэмт хэргийн хүнд хөнгөн, учруулсан хохирлын хэмжээ, урьд нь эрүүгийн ял эдлэж байсан зэрэг олон хүчин зүйлээс хамаарч ялыг оногдуулна.

Өнөөгийн байдлаар АНУ-ын конгресс нь цахим гэмт хэргийн аюулгүй байдлын тухай хуулийн шинэ төслийг авч хэлэлцэж байгаа бөгөөд уг хуулийн төсөл нь цахим гэмт хэрэгт оногдуулах ялыг чангатгах, тэдгээрийн нийгэмд учруулах аюулыг бодит гэмт хэргүүдтэй адилтган үзэхийг тодорхойлж өгсөн. Хуулийн нэг хэсэг эдийн засгийг тагнан турших гэмт хэрэгт зориулагдсан ба америкийн хувийн компаниудын оюуны бүтээлийг хулгайлсан гэмт хэрэгт оногдуулах торгуулийн хэмжээг нэмэгдүүлэхийг заасан байна.

Хуулийн хэсэгт энэ гэмт хэргээр яллах шүүхийн шийдвэрт хорих хугацааг 15-20 жил болгон нэмэгдүүлэх талаар яригдаж байна. Хэрвээ АНУ-ын дэд бүтцийн компьютерийн сүлжээ, теле сүлжээ, дулааны сүлжээ, тээврийн сүлжээ, усан хангамжийн удирдлагын систем зэрэгт нэвтрэн хохирол учруулсан тохиолдолд хугацаанаас нь өмнө суллахгүйгээр 30 жил хорих ял оногдуулж болно.

Их британи улс

Их британид компьютерийг хор хөнөөлтэй буруугаар ашиглах тухай Акт 1990 оны 8 дугаар сараас хүчин төгөлдөр болсон. Энэ Актын 1 дүгээр зүйл “компьютерийн

мэдээлэлд нэвтрэх эрхгүй хүн нэвтэрсэнтэй” хамааралтай. Компьютерийн тусламжтайгаар программ болон мэдээллийг өөрчлөх, устгах, мэдээллийг хуулж авах, ямар нэг арга замаар мэдээллийг ашиглах зэрэг үйлдэл нь компьютерт нэвтрэх гэмт хэрэгт тооцогддог. Ийм гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд торгох буюу 6 сар хорих ял оногдуулна.

Компьютерийн гэмт хэрэгтэй тэмцэхэд 2000 оны терроризмын тухай хууль Их британид хүчин төгөлдөр үйлчилж байна. Энэ хуулинд анх удаа терроризмын тодорхойлолтыг өргөн утгаар нь тусгасан ба цахим ертөнцийн салбарыг хөндөж тавьсан. Английн хууль сахиулах байгууллагууд террорист үйл ажиллагаа нь идэвхтэй байдлаар ямар нэгэн электрон системийн ажилд оролцож, тэдгээрийг гэмтээж байгаа компьютерийн гэмт хэрэгтнүүдийг илчлэх шийдвэртэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх чухал гэж үзэж байна.

Герман улс

Германы эрүүгийн хуульд тусгай “Daten” гэсэн нэр томъёо ашигладаг бөгөөд уг нэр томъёоны тодорхойлолтыг Эрүүгийн хуулийн 202 дугаар зүйлд тайлбарласан байдаг. Энэ мэдээлэл нь цахим, соронзон хэлбэрээр хадгалагдаж дамжуулагддаг тул шууд харах боломжгүй компьютерийн мэдээлэл юм. Өөртөө болон гуравдагч этгээдэд ашиг олох зорилгоор тусгай хамгаалалттай компьютерийн мэдээлэлд хууль бусаар нэвтэрсэн этгээдэд 3 хүртэлх жилийн ял оногдуулдаг. Компьютерийн мэдээллийг арилгасан, устгасан, өөрчилсөн, эвдсэн болон ийм үйлдлүүд хийхийг завдсан бол торгох, 2 хүртэлх жил хорих ял оногдуулна. Эрүүгийн хуулийн 303 дугаар зүйлийн “b”-д DNS /компьютерийн хорлон сүйтгэх ажиллагаа/, вирусны нянтай программыг тараах, түгээх гэмт хэргийг заасан байдаг. Аж ахуй нэгж байгууллагууд, төрийн байгууллагууд, бизнесийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг боловсруулахад хөндлөнгөөс оролцож компьютерийн хорлон сүйтгэх, устгах, гэмтээх ажиллагаа явуулвал гэмт хэрэг заасан. Хөндлөнгөөс оролцох гэдэг нь мэдээллийг устгах, гэмтээх, ажиллагаагүй болгох, компьютерийн системийг өөрчлөх болон мэдээллийг дамжуулахад хөндлөнгөөс оролцохыг хэлнэ. Дээрхи үйлдлүүдэд 5 хүртэлх жилийн ял оногдуулдаг байна.

Нидерланд улс

Тус улс нь компьютерийн гэмт хэрэг бий болж үйлдэгдэж эхэлсэн үеэс тууштай тэмцэж ирсэн юм. Тэд компьютерийн гэмт хэрэгтэй тэмцэх Зөвлөх хороог байгуулж Нидерландын Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулинд өөрчлөлт оруулах бодит зөвлөмж болон компьютерийн гэмт хэргийн ангиллал төрлийг боловсруулсан.

Эрүүгийн хуулийн 139 дүгээр зүйлд өөртөө болон гуравдагч этгээдэд ашиг олох зорилгоор цахилгаан шуудан холбооны системээр дамжуулж байгаа мэдээллийг замаас нь авах, бичлэг хийхэд зориулагдсан техник төнөг төхөөрөмжийг ашигласан бол торгох буюу 1 хүртэлх жил хорих ял оногдуулна гэж заажээ. Цахилгаан шуудан холбооны системээр дамжуулж байгаа мэдээллийг хууль бусаар замаас нь авах, бичлэг хийхэд хэрэгслэлээр хангаж өгсөн этгээдийг торгох буюу 6 сар хүртэл хорино гэж заасан.

Голландын Эрүүгийн хуулинд зөвшөөрөлгүйгээр компьютерийн сүлжээнд нэвтрэх, мэдээллийг зөвшөөрөлгүй хуулах, компьютерийн хорлон сүйтгэх ажиллагаа, вирус нян тараах, компьютерээр тагнан турших зэрэг шинэ бүрэлдэхүүнүүдийг нэмж 1993 онд Нидерландад компьютерийн гэмт хэргийн тухай хуулийг баталсан. Голландын Эрүүгийн хуулийн зүйлд заасан уламжлалт гэмт хэргийн үйлдэлд /сүрдүүлэх, залилан мэхлэх, хуурамчаар үйлдэх/ хүлээлгэдэг хариуцлагыг үндэслэн нэмэлт болон тайлбарыг нэмж хуульчилсан.

Испани улс

Испани улсын эрүүгийн хуулийн 197 дугар зүйлд мэдээлэл эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр нууц мэдээллийг тараах, нийтэд ил болгох тэр тусмаа цахилгаан шуудан, мэдээллийг хадгалж байгаа бааз, цахилгаан шуудан холбооны мэдээллийг хууль бусаар олж авах, бичлэг хийх, сонсох төхөөрөмжөөр сонссон тохиолдолд торгох буюу 1-4 хүртэл жил хорино гэж заасан байдаг. Хэрэв мэдээллийг нийтэд задруулсан болон гуравдагч этгээдэд дамжуулсан бол 2-5 хүртэл жил хорих ял оногдуулна.

Ирланд улс

Ирланд улсад цахим гэмт хэрэгт 1991 онд батлагдсан эрүүгийн хохирлын тухай Актанд зааснаар хариуцлага хүлээлгэдэг. Актын 5 дугаар зүйлд тус улсын нутаг дэвсгэр дээр компьютер ашиглан хууль бусаар мэдээллийг олж авахаар төлөвлөсөн тохиолдолд мэдээллийг олж авсан эсэхээс үл хамааран түүнийг гэмт хэрэг үйлдсэнд тооцно гэж заасан. Дээрхи гэмт хэргийн үйлдэлд торгууль оногдуулах буюу 3 сар хорино гэж заасан байдаг.

Итали улс

Италийн эрүүгийн хуулинд компьютерийн болон цахилгаан шуудан холбооны системд нэвтрэх эрхгүй хүн нэвтрэхийг хориглосон байдаг. Өөрөөр хэлбэл компьютер, систем, аюулгүй байдлын хамгаалалттай арга хэмжээнүүдэд хууль бусаар нэвтэрсэн бол санкц нь 3 хүртэл жил хорих ял байдаг.

Украин улс

Украины Дотоод хэргийн яамны дэргэдэх “зөвлөн-магадлан шинжлэх” зөвлөлийн мэдээллээс үзвэл өнөөгийн байдлаар цахим гэмт хэрэгтэй тэмцэх хууль тогтоомж нь үр дүнтэй биш байгаа ба Засгийн Газрын гол зорилт нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх европын стандартад нийцсэн хууль тогтоомжтой болох явдал юм. Үүнтэй холбоотойгоор Украины сайд нарын танхим цахим гэмт хэрэгтэй тэмцэхэд чиглэгдсэн 2013 оны 3 дугаар сарын 12-ны №2483 хуулийн төслийг дэмжиж 2013 оны 6 дугаар сард “Верховный рад” сайтад интернет сангийн үйл ажиллагааг зохицуулахад чиглэгдсэн “Мэдээллийн орон зайг хамгаалах тухай” хуулийн төслийг байршуулсан.

Үндэсний аюулгүй байдалд заналхийлэх гэмт хэргийн жагсаалтанд төрийн мэдээллийн санд зөвшөөрөлгүй оролцох, хүчирхийлэл, харгислал, садар самуун болон салан тусгаарлах үзлийг цахим ертөнцөөр нийтэд тараах, сурталчилсан тохиолдолд гэмт хэрэгт тооцохоор заасан байна. Цахим ертөнцөд иргэдийг хамгаалах эрх зүйн үндслэлийг бий болгох зорилгоор дээрхи баримт бичгүүдийг боловсруулан гаргасан.

Украинд компьютерийн гэмт хэргийн дийлэнх хувийг цахим худалдааны хүрээнд залилан мэхлэх гэмт хэрэг эзэлж байна. Дээрхи үйлдлүүдэд хүлээлгэх хариуцлага нь 850 гривенээр /ойролцоогоор 3,5 мянган рубль/ торгох буюу эд хөрөнгийг хурааж 12 хүртэлх жилийн /хүндрүүлэх нөхцөл байдлаас хамаарч/ хорих ял оногдуулахаар тодорхойлсон байна.

ГАДААД ХЭЛ ДЭЭР БИЧИГДСЭН НИЙТЛЭЛ

ПРАВОВЫЕ ОСНОВЫ АДМИНИСТРАТИВНОЙ ОТВЕТСТВЕННОСТИ ДОЛЖНОСТНЫХ ЛИЦ В МОНГОЛИИ



П. Эрдэнэбаатар

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн, Мөрдөх ажиллагааны онол, тактикийн тэнхимийн багш

Товч утга: Өнөөгийн Монгол Улсын захиргааны эрх зүйн тогтолцоонд албан тушаалтанд захиргааны хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндсийг хэд хэдэн өөр талаас судалж тусгасан болно. Монгол Улсын захиргааны хариуцлагын хуульд албан тушаалтаны тухай эрх зүйн зохицуулалтын үндэс нууцлагдмал учраас түүнд дүн шинжилгээ хийх шаардагатай талаар авч үзсэн.

Abstract: In work some aspects of legal bases of the administrative responsibility of officials in modern Mongolia are considered, substantive provisions of the law are opened. About officials in Mongolia. The analysis of the law of Mongolia is lead. About the administrative responsibility, also the received basic conclusions are stated.

Key words:

1. *The administrative responsibility*
2. *An administrative offence*
3. *Officials*
4. *The legal person*
5. *Jurisdiction*
6. *Punishment*

В юридической литературе Монголии отмечается, что для наступления административной ответственности должностных лиц необходимо наличие достаточных оснований[2, с. 20].

В этой связи мы согласны с теми авторами, которые в качестве таковых выделяют:

- Нормативное основание-систему норм права, регулирующих административную ответственность;
- Фактическое основание-деяние конкретного субъекта, нарушающее предписания, защищаемые административно-правовыми санкциями;
- Процессуальное основание - акт компетентного субъекта административной юрисдикции о наложении административного наказания за конкретное административное правонарушение.

Административная ответственность должностных лиц является разновидностью и составной частью института административной ответственности, в силу чего ей присущи признаки последней:

1. Административная ответственность должностных лиц является сложным, многоплановым явлением, сущность которого определена социальным характером его происхождения и раскрывается через взаимоотношения личности и общества.

Отсюда, в общесоциальном плане административная ответственность должностных лиц представляет собой связь между двумя субъектами, где одна сторона (ответственная) - должностное лицо - обязывается в силу своего правового статуса строить свое поведение в процессе осуществления служебной деятельности в соответствии с ожидаемой моделью, содержащейся в нормах права, охраняемых административными санкциями, а другая сторона - орган административной юрисдикции

-Контролирует, оценивает такое поведение и его результаты, и в случае их отрицательной оценки и наличия вины вправе применить соответствующее административное наказание, предусмотренное нормами административного права.

При этом одной из основных функций административной ответственности должностных лиц в Монголии показывающих ее социальную ценность как средства обеспечивающего соблюдение дисциплины и законности должностными лицами при осуществлении своей служебной деятельности, является стимулирующая.

С этой позиции административная ответственность должностных лиц представляет собой систему мер морального, материального и психического воздействия уполномоченных на то государственных органов (субъектов административной юрисдикции) на сознание, волю должностного лица в целях достижения в соответствии с требованиями, закрепленными в нормах административного права, должного поведения, соответствующего интересам общества.

2. Признаками, составляющими содержание административной ответственности должностных лиц в Монголии и отражающими ее специфику как вида института административной ответственности, являются;

- Субъект - должностное лицо, характеризующееся наличием специального правового статуса;

- Основание - должностное административное правонарушение;

- Обособленная совокупность правовых норм регулирующих административную ответственность должностных лиц;

- Ограниченный перечень мер административной ответственности, применяемых к должностным лицам.

Как институт отрасли административного права Монголии административная ответственность должностного лица представляет собой урегулированные нормами административного права общественные отношения, возникающие по поводу применения субъектами административной юрисдикции в установленном процессуальном порядке административных наказаний к должностному лицу, совершившему административное правонарушение в связи с неисполнением или ненадлежащим исполнением своих служебных обязанностей.

3. Юридическим основанием административной ответственности должностных лиц является должностное административное правонарушение - противоправное, виновное действие или бездействие должностного лица, совершенное им в связи с неисполнением или ненадлежащим исполнением своих служебных обязанностей, отличающееся от других административных правонарушений физических лиц повышенной общественной опасностью, возникающей в силу обладания должностным лицом специальным правовым статусом (положения), и за которое законами субъектов местном об административных правонарушениях установлена административная ответственность.

4. Одним из содержательных признаков административной ответственности должностных лиц является наличие совокупности правовых норм, определяющих ее специфику, которая выступает составной частью нормативно-правовой базы института административной ответственности.

Для реализации данных положений, по мнению автора, необходима разработка и принятие соответствующего законодательного акта, которым должен стать закон «О должностных лицах в Монголии».

5. Важным моментом, необходимым для привлечения должностного лица к административной ответственности, является определение юридического состава совершенного должностного административного правонарушения.

Понимание данного вопроса способствует:

- 1) выявлению наиболее существенных признаков административных правонарушений, позволяющих производить их специализацию и группировку;
- 2) правильной квалификации административного правонарушения правоприменительными органами;
- 3) установлению и определению соответствующего вида административного наказания;
- 4) ограничению административного правонарушения от смежных с ними преступлений.

В этой связи автор акцентирует внимание на некоторых проблемах в области правового регулирования административной ответственности в Монголии, в частности административной ответственности должностных лиц, требующих более подробного рассмотрения и имеющих важное значение для исследуемой нами темы.

Условно их можно подразделить на две группы. Первая группа проблем носит общий организационно - правовой характер, так как они обусловлены государственным устройством и организацией государственной власти в Монголии, что, в свою очередь, влияет на форму и порядок законодательного установления административной ответственности в целом и административной ответственности должностных лиц в частности, другая - обусловлена недостатками, существующими в самой системе административно - правовых норм, регулирующих административную ответственность должностных лиц.

Создание нового законодательства об административной ответственности, в том числе об административной ответственности должностных лиц, невозможно без уяснения новых реалий Монгольского государства его устройства, объединяющего в принципе разнорядковых субъектов, а также без надлежащего разрешения проблем распределения полномочий между организацией и ее субъектами[7, с.199].

Историко - правовой опыт показывает, что развитие правовых институтов Монголии на определенном этапе времени напрямую связано с происходящими в стране политическими, социально - экономическими и другими конструктивными процессами. Поэтому мы считаем, что эффективный поиск новых правовых решений законодательного установления административной ответственности должностных лиц в современных условиях возможен лишь на основе осознания концептуальных идей новой организации государственной власти в Монголии.

Основным актом, устанавливающим административную ответственность должностных лиц, является закон Монголии «Об административной ответственности»[3, с. 17]. Данный закон состоит из общей части и особенной части. В общей части дано понятие административного правонарушения; круг субъектов административной ответственности; перечень взысканий; правила наложения взысканий. Особенная часть состоит из перечня административных правонарушений.

Данный нормативной акт также устанавливает следующие особенности административной ответственности должностных лиц в Монголии.

К ним следует отнести:

- Должностное лицо привлекается к административной ответственности за вред, причиненный им при исполнении своих служебных обязанностей.

- Право требования граждан и юридических лиц по возмещению ущерба и вреда, причиненных должностным лицом при исполнении своих должностных обязанностей, закреплено в пункте 13 статьи 16 Конституции Монголии, где указано, что «граждане имеют право требовать возместить убытки, причиненные гражданину или юридическому лицу в результате незаконных действий (бездействия) государственных органов, органов местного самоуправления или должностных лиц этих органов, в том числе издания не соответствующего закону или иному правовому акту акта государственного органа или органа местного самоуправления, подлежат возмещению

государством, соответствующим субъектом или муниципальным образованием». Это же положение содержится в пункте 7 части 2 статьи 4 Закона Монголии «О государственной службе», где указано, что «государство отвечает за ущерб, причиненный служебной деятельностью должностных лиц»[4, с. 6].

Вместе с тем, автор делает вывод о том, что при этом возникают особые обязательства, связанные с причинением ущерба из-за незаконной деятельности и административных актов должностных лиц, а именно:

1. В части 2 статьи 498 Гражданского Кодекса Монголии предусмотрено, что если должностные лица своей служебной деятельностью причинили ущерб и нанесли вред, то государство, либо юридическое лицо, на котором работает виновное должностное лицо, отвечает за устранение вреда и нанесённый ущерб[6, с. 199].

2. В соответствии со статьями 505 Гражданского Кодекса Монголии (возмещение ущерба, причиненного гражданином, не достигшим возраста 16 лет), 506 (возмещение ущерба, причиненного гражданином из-за смерти жертвы преступления) 508 (возмещение нематериального ущерба, причиненных гражданином). Ущерб, который был нанесён должностными лицами при исполнении своих служебных обязанностей, возмещается пострадавшей стороне государством.[5, С. 54].

3. Формы и виды ответственности государства перед своими гражданами, особенности возмещения ущерба имеют следующие специфические особенности:

- Возмещение ущерба, причиненных гражданам в связи с незаконной деятельностью государственных органов и их должностных лиц.
- Государственные органы и их должностные лица не должны причинять реальный ущерб правам граждан и юридических лиц даже при действиях, разрешенных законом для пересечения правонарушения.

Например, в соответствии с пунктом 1.5. 39 Закона о земле одним из оснований прекращения права владения землей является отчуждение данного права для специальных нужд государства. При этом государство обязано предоставлять денежную компенсацию за такое отчуждение права на землю[1, с. 346].

- Государство несет ответственность перед гражданами. Убытки, причиненные гражданину или юридическому лицу в результате незаконных действий (бездействия) государственных органов, органов местного самоуправления или должностных лиц этих органов, подлежат возмещению государством.

Например, возмещение компенсации, денежной выплаты пострадавшим от политических репрессий, в том числе их детям и членам семьи.

Административная ответственность должностного лица в Монголии представляет собой урегулированные нормами административного права общественные отношения, возникающие по поводу применения субъектами административной юрисдикции в установленном процессуальном порядке административных наказаний к должностному лицу, совершившему административное правонарушение в связи с неисполнением или ненадлежащим исполнением своих служебных обязанностей.

Список использованной литературы

1. Гражданский кодекс Монголии. - Улан-батор, 2002.
2. Долгорсурэн Ж. Административная ответственность. Монография (монг. яз.). - Улан-батор, 1998.
3. Закон Монголии «Об административной ответственности» от 15 декабря 1992 года. Улан-батор, 1992.
4. Закон Монголии «О государственной службе» от 28 июня 2002 года. - Улан-батор, 1992.
5. Закон Монголии «О земле» от 01 января 2003 года. - Улан-батор, 2003.
6. Мунхжаргал Т. Гражданское право Монголии (монг. яз.). - Улан-батор, 1998.

7. Одгэрэл П. Административное право Монголии. Общая часть. (монг. яз.)
Улан-батор, 2004.